



ХАРТ НОЙРС ЛТД



**УЛААНБААТАР АУДИТ
КОРПОРАЦИ ХХК**

МОНГОЛЫН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГА (МОУИТБС)

МОНГОЛ УЛСЫН ДӨРӨВ ДЭХ УДААГИЙН БУЮУ 2009 ОНЫ НЭГТГЭЛИЙН ТАЙЛАН



**Улаанбаатар хот
2011 оны 6 дугаар сар**

Энэхүү тайлан болон хавсралтууд нь санаачлагын зорилгын үүднээс МОҮИТБС-ын Үндэсний Зөвлөл болон Ажлын Хэсгийн хэрэгцээнд мөн олборлох үйлдвэрлэлийг сонирхогчдод зориулагдсан болно.

АГУУЛГА

Товчлолууд ба Тодорхойлолтууд	1
1. ОРШИЛ	4
1.1. Зорилго	4
1.2. ОУИТБС-ын Нэгтгэлд оролцогч талууд	4
1.3. Тайлангийн бүтэц	5
1.4. Талархал	5
2. ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ	6
2.1 Нийт ерөнхий урсгал	6
2.2 Санхүүгийн урсгалын хураангуй	7
2.3 Засгийн газрын хүлээн авсан дүн	8
2.4 Газрын тосны салбар	8
2.5 Уул уурхайн салбар	9
2.6 Засгийн газар болон компаниудын оролцоо	11
2.7 Аудитын болон Санхүүгийн Стандартууд	12
3. МОНГОЛЫН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТАЛААР	13
4. ХАНДЛАГА	16
4.1 Тайлан нэгтгэлийн хамрах хүрээ	16
4.2 Хязгаарлалтууд/Ажлын үзэл баримтлал	16
4.3 Үндсэн суурь ба материаллаг байдал	17
4.4 Хандлага ба арга	17
4.5 Ажлын чиглэл, хоорондын уялдаа	18
4.6 Аргачлал	19
4.7 Талуудын оролцооны схем	20
4.8 Хамрагдсан компаниуд	22
5. САНХҮҮГИЙН УРСГАЛЫН НЭГТГЭЛ	23
5.1 Анхлан тайлагнасан санхүүгийн нийт урсгал	23
5.2 Тохируулгын дараах санхүүгийн нийт урсгал	24
5.3 Ажлын хэсгийн 2011 оны 4 сарын 29-ний өдрийн хуралдаанд танилцуулсан санхүүгийн нийт урсгал	24
5.4 Ажлын хэсгийн 2011 оны 6 сарын 2-ний өдрийн хуралдаанд танилцуулсан санхүүгийн нийт урсгал	25
5.5 Бүх тохируулга хийгдсэний дараах санхүүгийн нийт урсгал	26
6. ШИЙДЭГДЭЭГҮЙ ЗӨРҮҮНҮҮД	26
6.1 Бүх тохируулга хийгдсэний дараа шийдэгдээгүй үлдсэн нийт зөрүүнүүд	26
6.2 Төлбөрүүд	28
6.3 Хураамж, үйлчилгээний шимтгэлүүд	28
6.4 Төр, засгийн байгууллагуудад үзүүлсэн мөнгөн дэмжлэг	28
6.5 Байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардал	29
6.6 Төр, засгийн байгууллагуудад үзүүлсэн хандив, дэмжлэг	30
6.7 Компаниудаас үзүүлсэн нийт хандив, дэмжлэг	31
6.8 Хандив, тусламжийг бүртгэх тухай Сангийн сайдын журмын хэрэгжилт	34
6.9 Оролцоо	34
7. АСУУДЛУУД	34
7.1 Байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд байршуулсан талаар	34
7.2 Байгаль хамгаалах зардлын талаар	35

7.3	Хураамж үйлчилгээний шимтгэл зөрүү үүсгэсээр байгаа талаар	35
7.4	Хандив тусламжийн талаар	35
7.5	Засгийн газрын тайланг гаргахад нэгжүүдийн уялдаа холбоо, хяналт чухал байгаа талаар	36
7.6	Тайланг илэрхийлсэн валютын зөрүү	36
7.7	ҮТЕГ-ын мэдээллийн нэгдсэн системд байгаа дутагдлын талаар	37
7.8	Тайланг нэгтгэх явцад гарч буй алдааны талаар	37
7.9	Хөдөө орон нутагт төлөгдөж байгаа төлбөрүүд зөрүүгийн дүнд нилээд нөлөө үзүүлж байна.	37
7.10	Лиценз шилжүүлэлт нь зөрүү үүсэхэд нөлөөлж байна.	37
8.	ЗӨВЛӨМЖҮҮД	40
8.1	Олборлох үйлдвэрлэлийн салбарт борлуулсан ЗГ-ын бондын орлогыг ОУИТБС-ын тайланд хамруулах тухай	40
8.2	Компаниуд нь хандив тусламжийн зарим хэсгийг ашиг орлогын урсгал хэсэгт тайлагнах тухай	40
8.3	Дэд-гүйцэтгэгч нарын тухайд	40
8.4	Хандив, тусламжийг бүртгэх журмыг хэрэгжүүлэх талаар	40
8.5	Материаллаг байдлын түвшинг тодорхой болгох тухай	40
8.6	Өөр валютаар илэрхийлэгдсэнээс үүссэн зөрүүг арилгах тухай	41
8.7	ЗГ-ын зүгээс анхны зөрүү үүсгэж байгаа асуудлыг сайжруулах тухай	41
8.8	МОУИТБС-ын ажлын албаны бүтэц зохион байгуулалтын талаар	41
8.9	Орон нутагт төвлөрдөг төлбөрийг ҮТЕГ-ын мэдээллийн баазад нэгтгэх талаар	41
8.10	ҮТЕГ-ын тайлангийн нэгтгэлд гарч буй дутагдлыг арилгах талаар	41
8.11	Нэгтгэлийн тайлан бэлтгэх хугацааны талаар	42
	Хавсралт А-Нэгтгэлийн дүнд үүссэн залруулгууд (1) – санхүүгийн урсгалаар	42
	Хавсралт Б-Нэгтгэлийн дүнд үүссэн залруулгууд (2) – санхүүгийн урсгалаар	67
	Хавсралт В- ЗГ-ын хүлээн авсан дүн (Санхүүгийн нийт урсгалаар)	377
	Хавсралт Г- Компаниудын төлсөн дүн (Санхүүгийн нийт урсгалаар)	384
	Хавсралт Д– /А/-Шийдэгдээгүй зөрүүнүүд /компаниар, ЗГ-ын байгууллагаар, санхүүгийн урсгалаар/	392
	Хавсралт Д– /Б/-Шийдэгдээгүй зөрүүнүүд /компаниар/	393
	Хавсралт Е- Анхны зөрүүнүүдийн хүснэгт	397
	Хавсралт Ж- Нэгтгэлийн дүнд үүссэн цэвэр залруулганы хүснэгт	415
	Хавсралт З- Мэдээллийн эх сурвалжууд-Засгийн газрын байгууллагууд	432
	Хавсралт И- Удирдлагын хариуцлагын захидлыг ирүүлсэн байдал	433
	Хавсралт К- СТОУС-ын хэрэглээ	434
	Хавсралт Л - Уулзан, ярилцсан хүмүүс	438
	Хавсралт М - Компаниудын оролцооны үнэлгээ	439
	Хавсралт Н - Төрийн байгууллагуудын оролцооны үнэлгээ	441
	Хавсралт О - Оролцогч талууд	442
	Хавсралт Ө - /А/ Компаниудын мэдээлэл	443
	Хавсралт Ө - /Б/ Төр, засгийн байгууллагуудын мэдээлэл	448
	Хавсралт Ө - /В/ Орон нутгийн захиргааны байгууллагын мэдээлэл	451
	Хавсралт П - Албан бичиг хүргэлт, түүний хариу авалт	452
	Хавсралт Р – Компаниудаас өгсөн хандив дэмжлэгийн товчоо	453
	Хавсралт С - Компаниудын орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөр хураамж, үзүүлсэн хандив, дэмжлэгийн хүснэгт /аймаг тус бүрээр/	464
	Хавсралт Т- Компаниудаас ТББ-д өгсөн хандив тусламжийн товчоо	497

Товчлолууд ба Тодорхойлолтууд

АМГ	Ашигт малтмалын газар
АХ	Ажлын хэсэг (ОУИТБС)
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АТӨЯХАТ	Автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар
АТГ	Авто тээврийн газар
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
Ам.доллар	Америкийн нэгдсэн улсын мөнгөн тэмдэгт (доллар)
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
АНУ	Америкийн нэгдсэн улс
АМГГУУКХ	Ашигт малтмалын газрын Геологи, уул уурхайн кадастрын хэлтэс
АМГУУСХ	Ашигт малтмалын газрын уул уурхай судалгааны хэлтэс
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар (аймгийн)
БГД	Баянгол дүүрэг
БОА	Байгаль Орчны Алба
БО	Байгаль орчин
БОНСС	Байгаль орчин нөхөн сэргээх сан
БОАЖЯ	Монгол улсын Байгаль орчин аялал жуулчлалын яам
БТСХ	Биеийн тамир спортын хороо
БНГ	Байгалийн нөөцийн газар
БЗД	Баянзүрх дүүрэг
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ГТГ	Газрын тосны газар
ГИХАЭГ	Гадаадын иргэн, харъяатын асуудал эрхлэх газар
ГХЯ	Гадаад харилцааны яам
ЗДТГ	Засаг даргын тамгын газар (нийслэл, аймаг, дүүрэг сум)
ЗД	Засаг дарга
ЗБҮӨАТ	Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар
ЗГ	Монголын засгийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ММНБИ	Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт
МОУИТБС	Монголын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга
МОУИТБСАА	Монголын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын ажлын алба
МҮГХ	Монголын үйлдвэрлэлийн геологичдын холбоо
МҮХАТ	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим
МУУҮА	Монголын уул уурхайн үндэсний ассоциаци
МХГ	Мэргэжлийн хяналтын газар (аймгийн)
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НБОУХ	Нягтлан бодогчдын Олон Улсын Холбоо
ОУИТБС	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга
ОНЗЗ	Орон нутгийн засаг захиргаа
ОХУ	Оросын Холбооны Улс
УГЕГ	Улсын гаалийн ерөнхий газар
УТОХГ	Улсын төсвийн орлого хяналтын газар
ҮЗ	Үндэсний зөвлөл
ҮСХ	Үндэсний статистикийн хороо

ҮТЕГ	Үндэсний татварын ерөнхий газар
ҮХЭХАТ	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар
СЭЗБЗГ	Санхүү, эдийн засгийн бодолго зохицуулалтын газар
СХЗГ	Стандартчилал, хэмжил зүйн газар
СХД	Сонгинохайрхан дүүрэг
СЯ	Монгол улсын Сангийн яам
СБД	Сүхбаатар дүүрэг
СЭЗХ	Санхүү, эдийн засгийн хэлтэс
СЭЗДС	Санхүү, эдийн засгийн дээд сургууль
ТДОИС	Тахир дутуу одой иргэдийн сан
ТӨХ	Төрийн өмчийн хороо
ТББ	Төрийн бус байгууллага
ТЗА	Тээвэр зохицуулалтын алба
Төг.	Монгол улсын үндэсний мөнгөн тэмдэгт (төгрөг)
ХҮХ	Халамж үйлчилгээний хэлтэс
ХЦА	Хилийн цэргийн анги
ХХЕГ	Хил хамгаалах ерөнхий газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХК	Хувьцаат компани
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ЧД	Чингэлтэй дүүрэг
ЭБЭХЯ	Эрдэс баялаг эрчим хүчний яам
ЭНЭШҮТөв	Эх нялхсын эрдэм шинжилгээний төв
ЭЦГ	Эрүүгийн цагдаагийн газар

**"Харт Нойрс" Лтд
Мэргэшсэн Нягтлан бодогчид**

The Old Coach House
Southern Road
Thame, Oxfordshire
OX9 2ED England

Tel: 44 01844 21 88 36
Fax: 44 08700 94 14 69
Website: www.hart-nurse.co.uk

**"Улаанбаатар Аудит
Корпораци" ХХК**

"Маргад Центр" Төвийн 4-р давхар,
Чингэлтэй дүүрэг, 5-р хороо,
Их тойруу, Улаанбаатар хот
Монгол улс

Утас: 976-11-321844, 329430, 70110744
Факс: 976-11-321844
Вебсайт: www.ulaanbaatar-audit.mn

Монголын Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын
Санаачилгын Ажлын Хэсэг
МОУИТБСАА
Монгол улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Амарын гудамж,
Туушин компаний байр, 512 тоот

2011 оны 04 сарын 29-ны өдөр

Англи улсын "Харт Нойрс" Лтд ба Монгол улсын "Улаанбаатар Аудит Корпораци" ХХК-ийн консерциум нь МОУИТБСАА-ны зүгээс МОУИТБС-ын 4 дэх удаагийн буюу 2009 оны Нэгтгэлийн ажлыг ("Гэрээт ажил") хийхээр сонгогдон гэрээ байгуулсан билээ.

Энэхүү гэрээт ажил нь АОУС буюу зөвшилцсөн горимын дагуу гүйцэтгэх ажилтай уялдан Холбогдох Үйлчилгээний стандартын дагуу хийгдсэн болно. Гэрээт ажлын горимууд нь тайлан болон түүний хавсралтууд энэхүү тайланд хавсаргасан Ажлын Даалгаварт тусгагдсаны дагуу гүйцэтгэгдсэн.

Бид олж илрүүлсэн зүйлсээ энэхүү тайлан, түүний хавсралтуудаар тайлагнасан. Учир нь: Гүйцэтгэсэн горимууд нь нэгтгэлийн болон шалгах ажлыг АОУС буюу Шалгах Ажлын Олон Улсын Стандартын дагуу гүйцэтгэх зорилго агуулаагүй бөгөөд бидний зүгээс энэхүү тайланд харуулсан тодорхой мэдээллүүд, тэдгээртэй холбогдох аливаа гүйлгээнүүдэд ямар нэгэн баталгаа өгөх үүрэггүй юм. Нэмэлт горимуудыг авч хэрэгжүүлсэн тохиолдолд магадгүй зарим зүйлсийг бид анхааралдаа аван та бүхэнд тайлагнах байсан.

Энэхүү тайлан нь Ажлын Даалгаварт тусгагдсан зүйлсийн хүрээнд зөвхөн Ажлын Хэсэг болон Үндэсний Зөвлөлд мэдээлэх зорилго агуулсанаас гадна олборлох үйлдвэрлэлийг сонирхогчдод мэдээлэл болгон ашиглахад зориулагдсан болно.

Тус тайлан нь зөвхөн заагдсан зүйлсийн хүрээнд хийгдсэн бөгөөд аливаа нэгэн нэгжийг бүхлээр нь хамарсан санхүүгийн тайлангуудийн хүрээнд хийгдээгүй.

**"Харт Нойрс" Лтд
Мэргэшсэн Нягтлан бодогчид**

**"Улаанбаатар Аудит
Корпораци" ХХК**

1. ОРШИЛ

Энэхүү тайлан нь МОУИТБС-ын 4 дэх удаагийн буюу 2009 оны Нэгтгэлийн гэрээт ажлын тайлан юм.

2010 оны 10 дугаар сарын 19-ний өдөр ОУИТБС-ын Олон улсын удирдах хороо Монгол Улсыг Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын шаардлагыг хангасан орноор зарлан, хүлээн зөвшөөрсөн байна. Иймээс энэхүү нэгтгэл нь олон улсын шаардлагыг хангасан байгууллагын хувьд анхны тайлан нь юм.

Энэхүү тайлан нь Ажлын Даалгаварт тусгагдсан зүйлсийн хүрээнд зөвхөн Ажлын Хэсэг болон Үндэсний Зөвлөлд мэдээлэх зорилго агуулсанаас гадна олборлох үйлдвэрлэлийг сонирхогчдод мэдээлэл болгон ашиглахад зориулагдсан болно.

Тайлан нь доорхи хэсгүүдээс бүрдэнэ:

Хэсэг I – Тайлан
Хэсэг II – Хавсралтууд

1.1. Зорилго

Энэхүү Гэрээт ажлын зорилго нь Олон улсын ОУИТБСАА-наас гаргасан журмын дагуу Монгол Улсын уул уурхайн болон газрын тосны салбарын компаниуд болон Засгийн газар хоорондын төлбөр болон орлогыг олон нийтэд ил тод, найдвартай байдлыг тодорхойлоход оршино. Эцэст нь, энэхүү Гэрээт ажил нь уул уурхайн болон газрын тосны салбарын 2009 онд хийгдсэн материаллаг төлөлтүүд болон орлогуудын нэгтгэл, дүн шинжилгээ зэргийг багтаасан.

1.2. ОУИТБС-ын Нэгтгэлд оролцогч талууд

Сангийн Яам нь Засгийн газрын харъяа яам, агентлагуудаас ирүүлсэн мэдээллийг ОУИТБС-ын маягтын дагуу бэлтгэн гаргаж өгсөн. МОУИТБС-ын 4 дэх удаагийн буюу 2009 оны Нэгтгэлд оролцсон Засгийн газрын харъяа яам, агентлагуудын нэрсийг дор харуулав. Үүнд:

- Сангийн Яам
- Үндэсний татварын ерөнхий газар
- Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам
- Ашигт малтмалын газар
- Газрын тосны газар
- Гаалийн ерөнхий газар
- Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар
- Төрийн өмчийн хороо.

Түүнчлэн Хавсралт Ө/в/-д дурьдсан аймаг, нийслэл, сум, дүүргийн засаг даргын тамгын газрууд өөрсдийн мэдээллийг ирүүлсэн.

Энэхүү нэгтгэлд улсын болон орон нутгийн төсөвт нийт дүнгээрээ 50 сая төгрөгөөс дээш хэмжээний татвар, төлбөр, хураамжийг төлсөн олборлох үйлдвэрлэл эрхэлдэг 101 компани хамрагдсан.

Хамрагдсан компаниудын нэрсийн жагсаалтыг Хавсралт Б-д харуулсан болно.

1.3. Тайлангийн бүтэц

Энэхүү тайлан нь дараахи бүтэцтэй:

- а. Гүйцэтгэлийн хураангуй
- б. Монголын олборлох үйлдвэрлэлийн талаар
- в. Гэрээт ажлыг гүйцэтгэхдээ ашигласан бидний хандлага
- г. Тайлагнан ирүүлсэн урсгалын (төлбөрүүд болон орлого) нийт дүн
 - i. МОУИТБСАА-д анхлан ирүүлсэн дүн
 - ii. Гэрээт ажлын хүрээнд хамаарахгүй зүйлсийг салган харуулсан дүн
 - iii. Анхны зөрүүнүүдийг нэгтгэсний дараахи байдлаархи дүн. Үүнийг хамрагдсан компаниудаас ирүүлсэн мэдээлэл болон тайлбарууд дээр суурилан хийх боломжтой байсны дагуу хийсэн.
- д. Шийдэгдээгүй зөрүүнүүдийн дүнг төлбөр, орлогын төрөл тэдгээрийн тухай мэдээлэл болон тайлагнасан дүнгүүд нь нэгтгэгдэн шийдэгдээгүй үлдсэн компаниудын нэрсийн хамт харуулсан байдал
- е. Гэрээт ажлын явцад ажиглагдсан асуудлуудын нэгтгэл
- ё. ОУИТБС-ын процесс болон ил тод байдлын үйл ажиллагааг сайжруулахад зориулан өгч буй зөвлөмжүүд

Анхны зөрүүнүүд, хийгдсэн залруулгууд болон шийдэгдээгүй зөрүүнүүдийн дэлгэрэнгүйг компани болон санхүүгийн урсгалын төрлөөр нь шинжилсэн ба эдгээрийг Хавсралтууд болон холбогдох анхан шатны баримтуудын хамт харуулсан.

1.4. Талархал

Засгийн газрын харьяа байгууллагуудын болон уул, уурхайн компаниудын гол албан тушаалтнуудтай уулзах, тэдэнтэй холбоо тогтоох, холбогдох газруудад захидал явуулах, хүлээн авах зэрэгт дэмжлэг, туслалцаа үзүүлсэн Монголын ОУИТБСАА-ны хамт олон, Ш. Цолмон, Б.Дэлгэрмаа нарт "Харт Нойрс" Лтд болон "Улаанбаатар аудит корпораци" ХХК-ийн хамтарсан консерциумын хамт олон чин сэтгэлийн талархал илэрхийлье

Мөн Засгийн газрын болон орон нутгийн засаг захиргааны байгууллагуудаас ирүүлэх мэдээллийн хариуг түргэвчлэх ажилд дэмжлэг үзүүлсэн Ажлын хэсгийн ахлагч, Монгол Улсын Ерөнхий сайдын ахлах зөвлөх Б.Долгор, Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын ахлах референт Э.Сумъяа нарт гүн талархал илэрхийлж байна.

Мөн Засгийн газрын байгууллагуудаас цаг алдалгүй хариу авахад туслалцаа үзүүлсэн холбогдох бүх хүмүүст талархалаа илэрхийлье.

2.2 Санхүүгийн урсгалын хураангуй

Дараах хүснэгт нь:

- i. Тайлагнагч нэгжүүдийн анхны нийт мөнгөн урсгал, Засгийн газрын хүлээн авсан дүн болон компанийн төлсөн дүн хоорондын зөрүү
- ii. Нэгтгэл тайлангийн ажлын явцад хийсэн тохируулгуудын үр дүн
- iii. Тохируулсан нийт мөнгөн урсгал болон шийдвэрлэгдээгүй үлдсэн зөрүүнүүд

(мянган төгрөгөөр)

Бүх компаниуд								
Компаниас улсын болон орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөр	Анхны нэгтгэл		Анхны нэгтгэлийн зөрүү*	Тохируулга		Тохируулгын дараа		Тохируулгын дараах шийдэгдэ эгүй зөрүү
	ЗГ-ын байгууллагын дүн /УТОХГ/	Компанийн дүн		ЗГ	Компани	ЗГ	Компани	
Төлсөн татварууд	299,868,830	299,176,914	691,916	779,192	1,471,108	300,648,022	300,648,022	-
Төлбөр	137,864,995	137,842,368	22,627	403,004	427,611	138,267,999	138,269,979	(1,980)
Хураамж, үйлчилгээний хөлс	10,015,277	9,608,983	406,294	1,229,368	1,637,783	11,244,645	11,246,766	(2,121)
Төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашиг	9,035,833	104,217,578	(95,181,745)	95,059,481	(122,264)	104,095,313	104,095,313	-
Хүлээн авагч Засгийн газарт төлсөн бусад төлбөрүүд	-	171,024,055	(171,024,055)	169,528,159	(1,495,896)	169,528,159	169,528,159	-
Төрийн байгууллагад үзүүлсэн дэмжлэг	3,852,268	5,616,326	(1,764,058)	2,950,319	1,208,020	6,802,587	6,824,346	(21,759)
Байгаль хамгаалах арга хэмжээнд зарцуулсан зардал	7,577,228	6,235,945	1,341,284	(639,051)	734,534	6,938,178	6,970,478	(32,301)
Нийт дүн	468,214,430	733,722,168	(265,507,738)	269,310,472	3,860,895	737,524,903	737,583,063	(58,161)

*ЗГ-ын байгууллагын тайлагнасан дүн компанийн дүнгээс (+) их, бага (-)

Дээр дурьдсан хүснэгтийг ашигт малтмал болон газрын тосны чиглэлээр салган хүснэгт №1, 2-оор харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №1

(мянган төгрөгөөр)

Ашигт малтмалын олборлолт эрхэлдэг компаниуд								
Компаниас улсын болон орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөр	Анхны нэгтгэл		Анхны нэгтгэлийн зөрүү	Тохируулга		Тохируулгын дараа		Шийдэгдэ гүй зөрүү
	ЗГ-ын байгууллагын дүн /УТОХГ/	Компанийн дүн		ЗГ	Компани	ЗГ	Компани	
Төлсөн татварууд	298,279,759	298,665,967	(385,736)	779,192	392,984	299,058,951	299,058,951	-
Төлбөр	137,820,551	132,916,486	4,904,065	(176,602)	4,730,113	137,643,949	137,646,599	(2,650)
Хураамж, үйлчилгээний хөлс	10,004,808	9,376,584	628,224	1,229,368	1,859,713	11,234,176	11,236,297	(2,121)
Төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашиг	9,035,833	104,217,578	(95,181,745)	95,059,481	(122,264)	104,095,313	104,095,313	-
Хүлээн авагч Засгийн газарт төлсөн бусад төлбөрүүд	-	143,422,000	(143,422,000)	144,200,000	778,000	144,200,000	144,200,000	-
Төрийн байгууллагад үзүүлсэн дэмжлэг	3,842,268	5,456,879	(1,614,612)	2,828,595	1,235,742	6,670,862	6,692,621	(21,759)
Байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардал	7,362,281	6,074,147	1,288,134	(522,541)	797,894	6,839,741	6,872,041	(32,301)
Нийт дүн	466,345,499	700,129,640	(233,783,669)	243,397,492	9,672,182	709,742,992	709,801,822	(58,831)

Хүснэгт №2

(мянган төгрөгөөр)

Газрын тосны олборлолт эрхэлдэг компаниуд								
Компаниас улсын болон орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөр	Анхны нэгтгэл		Анхны нэгтгэлийн зөрүү	Тохируулга		Тохируулгын дараа		Шийдэгдэ эгүй зөрүү
	ЗГ-ын байгууллагын дүн /УТОХГ/	Компанийн дүн		ЗГ	Компани	ЗГ	Компани	
Төлсөн татварууд	1,589,071	510,947	11,045,357	-	1,078,124	1,589,071	1,589,071	-
Төлбөр	44,445	4,925,883	(4,881,438)	579,606	(4,302,502)	624,051	623,381	670
Хураамж, үйлчилгээний хөлс	10,469	232,400	(221,931)	-	(221,931)	10,469	10,469	-
Төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашиг	-	-	-	-	-	-	-	-
Хүлээн авагч Засгийн газарт төлсөн бусад төлбөрүүд	-	27,602,055	(27,602,055)	25,328,159	(2,273,896)	25,328,159	25,328,159	-
Төрийн байгууллагад үзүүлсэн дэмжлэг	10,000	159,447	(149,447)	121,725	(27,722)	131,725	131,725	-
Байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардал	214,947	161,797	53,150	(116,510)	(63,360)	98,437	98,437	-
Нийт дүн	1,868,931	33,592,528	(21,756,364)	25,912,980	(5,811,287)	27,781,911	27,781,241	670

2.3 Засгийн газрын хүлээн авсан дүн

Ажлын хэсэг нь 2009 оны нэгтгэл тайлангийн хувьд ЗГ-ын байгууллагын хүлээн авсан дүн нь материаллаг хэмжээтэй байгааг тодорхойлж, тэдгээр тайлагнагч байгууллагуудыг маягтанд оруулахыг зөвлөсөн. Бид уг батлагдсан тодорхойлолтын дагуу тайлан нэгтгэлийн ажлаа гүйцэтгэсэн.

СЯ-наас ирүүлсэн ЗГ-ын хүлээн авсан мөнгөн дүнгийн талаарх дэлгэрэнгүй мэдээллээс харахад газрын тосны 6 компаниас авсан төлбөрийг 2009 оны тайлан нэгтгэлийн хувьд орхигдуулсан байна.

Мөн нэгтгэл ажлын нийт цар хүрээ нь ирээдүйг судлахыг шаарддаг. Учир нь материаллаг хэмжээтэй байж болох тодорхой хүлээн авсан дүн орхигдох болон ОУИТБС-ын тайлагналаар цаашид илүү анхаарч авч үзэх бусад урсгалууд байж болох юм.

2.4 Газрын тосны салбар

2.4.1 Хүлээн авсан дүн/төлбөрийг орхигдуулах

ТТГ-аас ирүүлсэн мэдээлэлд 2009 онд Бүтээгдэхүүн хуваах гэрээнд гарын үсэг зурсан компани тус бүрээр 50 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий гарын үсгийн урамшуулал, сургалтын урамшуулал, талбайн дэнчинд дараах мөнгөн дүнгүүд төлөгдсөн боловч ЗГ-ын тайланд орхигдсон байна. Үүнд:

Компанийн нэр	Гарын үсгийн урамшуулал	Сургалтын урамшуулал	Талбайн дэнчин	Гарын үсгийн урамшуулал	Сургалтын урамшуулал	Талбайн дэнчин
	ам.доллараар	ам.доллараар	ам.доллараар	мян.төгрөгөөр	мян.төгрөгөөр	мян.төгрөгөөр
Петро Чайна Дачин Тамсаг /Монгол/ ХХК		220,445	256,090		315,666	366,708
Доншен газрын тос /Монгол/ ХХК		60,000	53,210		85,917	76,194
Зон Хэн Юу Тиан ХХК*	120,000	70,000		171,834	100,237	
"DWM Petroleum AG" ХХК*	200,000	120,000	20,321	286,390	171,834	29,099
Сентрал Азиан Петролиум*	140,000	150,000	71,041	200,473	214,793	101,727
Эн Пи Ай ХХК*	150,000	75,000	9,861	214,793	107,396	14,120
М Си Эс ХХК*	100,000	75,000	31,430	143,195	107,396	45,006
Петро Матад ХХК*		25,000	28,500		35,799	40,811
Дүн	710,000	795,445	470,453	1,016,685	1,139,037	673,665
Хөрвүүлсэн ханш 1 ам.доллар = 1432 төгрөг						

Эдгээр компаниудын 6 нь (*-р тэмдэглэсэн) ОУИТБС-ын 4-р маягтанд ороогүй учир компаниудаас эдгээр төлбөрүүдийг баталгаажуулж өгөхийг хүсээгүй. Засгийн газраас ирүүлсэн 4-р маягтанд Петрочайна болон Доншен газрын тос /Монгол/ ХХК зэрэг компаниудын төлбөрийг оруулаагүй байсан.

Дээрх төлбөрүүдийг ам.доллараар хийсэн бөгөөд ам.доллар болон төгрөгөөр аль алианаар нь харуулав.

2.4.2 Орхигдуулах болсон шалтгаан

Газрын тосны газар нь “Петрочайна Дачин Тамсаг” болон “Доншен газрын тос” компаниудаас хүлээн авсан Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу төлсөн төлбөр, бусад татвар, хураамжийн талаархи мэдээллийг ҮТЕГ-т явуулсан гэж тайлбарласан.

Харин гарын үсгийн урамшуулал, сургалтын урамшуулал, талбайн дэнчин зэрэг материаллаг хэмжээний төлбөр төлсөн бусад газрын тосны компаниудын мэдээллийг ҮТЕГ-т явуулаагүй гэж мэдээлсэн. Учир нь газрын тосны компаниуд нь ОУИТБС-д нэгдэж, ил тод байдлын тайлан гаргах хууль эрх зүйн шаардлага байхгүй, мөн хайгуулын шатанд үйл ажиллагаа явуулж байгаа газрын тосны компаниудыг тайлагнах шаардлагагүй гэсэн тайлбарыг Газрын тосны газрын холбогдох албан тушаалтнууд өгсөн.

ҮТЕГ-аас энэ талаар тодруулахад ГТГ нь тайлангаа хугацаандаа ирүүлээгүй, өөрөөр хэлбэл СЯ-наас ОУИТБС-ын ажлын албанд нэгдсэн тайланг явуулсаны дараа ирүүлсэн гэсэн тайлбар өгсөн. СЯ нь ОУИТБС мэдээллээ аль хэдийн нэгтгэсэн байсан бөгөөд ГТГ-аас ирүүлсэн мэдээллийг нэмж оруулах хугацаа байгаагүй байна.

2.4.3 Нэмэлт тайлбар

Өмнөх жилүүдэд олборлолт явуулдаг газрын тосны 2 компани байсан бөгөөд тэдгээр нь тухайн жилүүддээ ОУИТБС-ын тайланд нэгтгэгдэж байсан.

Эдгээр хоёр компаниуд 2009 оны тайлан нэгтгэлд орсон боловч бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу төлсөн гарын үсгийн урамшуулал болон бусад төлбөрүүд нь ГТГ-аас оройтож тайлагнагдсан учраас 2009 оны ЗГ-ын тайланд ороогүй байна.

Бусад газрын тосны компаниудын төлсөн иймэрхүү төлбөрүүд нь ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн баталсан материаллагийн хэмжээнээс илүү байгаа ч ГТГ-аас тайлагнаагүй байна. СЯ-наас ЗГ-ын хүлээн авсан дүн нь ЗГ-ын тайлангийн маягтанд орсоныг батлах процесс гараагүй харагдаж байна. Бүтээгдхүүн хуваах гэрээ (ОУИТБС-ын тайлангийн маягтан дээрх нэг мөр)–г тодорхойлоогүйн улмаас эдгээр төлбөрүүд орхигдож байна.

ЗГ-ын мэдээг цуглуулах болон мэдээллийн бүрэн бүтэн байдлыг шалгах нь эдгээрийн газрын тосны компаниудын орхигдсон материаллаг төлбөрүүдийг шалгахыг шаарддаг.

2.5 Уул уурхайн салбар

2.5.1 Орхигдсон орлого/төлбөр

- i. “Эрдэнэт үйлдвэр” ХХК нь 95 тэрбум төгрөгийн ногдол ашиг төлсөн гэж тайлагнасан, харин ЗГ уг ногдол ашгийг тайлагнаагүй. Энэ нь ТӨХ хүлээн авсан ногдол ашгийг ЗГ-ын нэгтгэлд ирүүлээгүйгээс шалтгаалсан ба СЯ-наас ногдол ашгийг хүлээн авсан гэдгээ дараа нь баталсан. Бидний энэ бүлгийн 2.4.3 нэмэлт тайлбарт хамаарна.
- ii. “Оюу толгой” ХХК 100 сая ам.долларын буюу 143 тэрбум төгрөгийн ЗГ-ийн өрийн бичгийг худалдан авч, ОУИТБС-ын маягтандаа тайлагнасан ба ер нь ирээдүйд эргүүлэн авахгүй байх гэж тайлбарласан. Харин ЗГ нь ОУИТБС-ын маягтанд уг дүнг тайлагнаагүй ба Засгийн газрын орлого биш ирээдүйд эргүүлэн төлөх учир ОУИТБС-д хамруулаагүй гэж тайлбарласан.

Уг төлбөр нь Үндэсний зөвлөлөөс баталсан 50 сая төгрөгийн босгоос хэтэрсэн материаллаг төлбөр бөгөөд маягттай хамт батлагдсан аргачлал "Засгийн газарт төлсөн бусад төлбөрүүд-бусад" гэсэн маягтын зүйл дээрх тодруулгаас хасагдахгүй юм.

Мөн ОУИТБС-ын "Хэрэв орлогын урсгал орхигдох болон буруу тайлагнагдсан нь ОУИТБС-ын тайланд материаллагаар нөлөөлж байвал материаллаг гэж үзнэ" гэж Үндэсний Зөвлөлийн 7 дугаар хуралдааны шийдвэрт заасны дагуу материаллаг дүн юм. ЗГ ОУИТБС-ын тайланг мөнгөн сууриар бэлтгэдэг учир олборлох үйлдвэрлэлээс ("Оюу толгой" ХХК-иас авсан өрийн бичгийн орлогыг оролцуулаад) авсан мөнгөн урсгал нь Засгийн газрын орлогод тооцогдох ёстой. Олон нийтийн хэвлэл мэдээллээр өргөн хүрээнд хэлэлцэгдсэн орлогыг орхигдуулсанаар ОУИТБС-ын тайланд нөлөөлж болох юм.

Бид уг өрийн бичгийн орлогыг Засгийн газрын орлого гэж үзэх нь зүйтэй гэж Ажлын хэсгийн 2011 оны 4 сарын 29-ний хуралдаанд оруулсан ба Сангийн яамнаас энэхүү төлбөрийн талаарх тайлбарыг албан бичгээр хүлээн авч, ЗГ-ын талд нэмэгдүүлэх залруулга хийснээр зөрүүг шийдвэрлэсэн.

iii. Дэд гүйцэтгэгчид

Уул уурхайн компаниудын олонхи нь өөрсдийн үйл ажиллагааны зарим хэсэг болох хайгуулын болон олборлолтын шатанд бусад компаниудад дэд гэрээгээр даалган гүйцэтгүүлдэг. Монгол улсад ийм дэд гүйцэтгэгчдийн жишээ нь Австралийн "Лейтон Холдингс" компанийн охин компани "Лейтон уул уурхай ба дэд бүтэц Монгол" ХХК нь "Мон Эн Ко" ХХК-ийн Хөшөөтийн нүүрсний уурхай, "Редхилл Монголиа" ХХК-ийн Улаан Овоогийн нүүрсний уурхай болон "Энержи ресурс" ХХК-ийн Ухаа худагийн нүүрсний уурхайд хөрс хуулалтын болон олборлох ажлыг гэрээлэн гүйцэтгэж байна. Өөр нэг жишээ нь Канадын "Рэдпат Монголиа" ХХК нь "Оюу толгой" ХХК-ийн газар доорх ажлын гэрээлэгч бөгөөд "Оюу толгой" төслийн босоо амны нэвтрэлтийн ажлыг гүйцэтгэж байна.

Хэрвээ эдгээр дэд гүйцэтгэгч компаниудаас хийсэн төлбөрүүдийг тус уул уурхайн компани нь төлсөн бол ОУИТБС-ын маягтанд багтаах хэрэгтэй. Гэтэл эдгээр дэд гүйцэтгэгчид нь ОУИТБС-ын нэгтгэл тайланд хамрагдаагүй байгаа бөгөөд эдгээр компаниудын төлсөн татвар, төлбөр, хураамжууд нь ОУИТБС-ын тайланд хамрагдаагүй байна.

Иймд Ажлын хэсэг болон Үндэсний зөвлөл нь ОУИТБС-ын тайлан нэгтгэлд ороогүй боловч уул уурхайн ажил эрхэлж байгаа компаниудын дүн материаллаг хэмжээтэй эсэхийг хянах хэрэгтэй нь харагдаж байна.

2.5.2 Компанийн зүгээс төлсөн төлбөрүүд

ЗГ болон компанийн тайлагнасан дүнгүүдийн зөрүүгийн шалтгааныг тодорхойлох явцад бид эдгээр урсгалын системийн үйл ажиллагаанд сул талууд байгааг ажигласан. Тэдгээрийг бид тайландаа тусгаж, хэд хэдэн тохиолдолд зөвлөмж өгсөн. Анхаарал татах үндсэн 2 зүйл байна. Үүнд:

2.5.3 Байгаль хамгаалах арга хэмжээнд зарцуулсан зардал

Жил бүр компаниудыг Улсын болон орон нутгийн тусгай дансанд байгаль орчныг хамгаалах зардалтай холбоотой барьцааны мөнгийг төвлөрүүлэхийг хуулиар шаарддаг. Компаниуд нь байгаль орчинг хамгаалахтай холбоотой зардал гарсаныг нотолсоны дараа уг төвлөрүүлсэн мөнгөө ЗГ-аас эргүүлэн авна.

Олон компаниуд уг төлсөн мөнгөө эргүүлэн аваагүй бөгөөд үүний үр дүнд тусгай дансны сангийн үлдэгдэл 1,438.6 сая төгрөг болсон байна.

Компаниуд байгаль орчныг хамгаалах зардлын талаарх мэдээллийг ЗГ-ын өөр өөр агентлагуудад өгдөг боловч тэдгээр агентлагуудын тайлагнасан тоо хоорондоо зөрүүтэй байна. Эндээс үзэхэд ЗГ-ын нэгжүүдийн ажлын уялдаа холбоог сайжруулах хэрэгтэй байна.

Компанийн ЗГ-т тайлагнаж байгаа эсвэл ЗГ-ын нэгж хоорондоо тайлагнасан зардлын тайлагналыг шалгаж, тусгай дансанд төвлөрүүлсэн мөнгөний зарцуулалтыг шалгахыг зөвлөж байна.

2.5.4 Хандив, дэмжлэг

Компаниудын тайлагнан ирүүлсэн хандив, дэмжлэгийн дүнгүүд нь ихэнх тохиолдолд ЗГ-т өгсөн бус харин сайн дурын болон нийгэм, олон нийтийн ашиг тусын (барилга, засвар гэх мэт) тулд өгсөн зардлуудыг харуулж байгаа билээ.

Тиймээс ЗГ-т төлөөгүй буюу өгөөгүй дүнг ОУИТБС-ын маягтны Хамрах хүрээ 2 буюу Ашиг орлогын урсгал хэсэгт оруулах нь зүйтэй хэмээн зөвлөж байна. Түүнчлэн, Ажлын Хэсэг нь ЗГ-т тайлагнах хандив, дэмжлэгийн дүнгийн хамгийн бага дүнг тогтоох буюу анхааран үзэх хэрэгтэй.

2.6 Засгийн газар болон компаниудын оролцоо

ОУИТБС-ын 2009 оны тайлантай холбоотой мэдээллийг тодруулах зорилгоор нийт 290 газарт албан бичиг хүргүүлж, хариу авч ажиллалаа. Үүнд:

Яам агентлаг	23
Төсвийн байгууллага	26
Аймаг	20
Сум	120
Компани	101
Нийт	290

Ажлын дэлгэрэнгүй даалгаварт зааснаар тайлагнагч байгууллагуудын ил тод байдал, харилцааны соёлын талаар ямар байсныг тайландаа дүгнэлт оруулахыг даалгасан. Бид энэ талаар оролцогч 101 компани, Төрийн байгууллагуудын оролцоог үнэлсэн.

Тухайлбал: Компаниудын хувьд маш сайн оролцсон-12, сайн-35, дунд-38, муу-8, маш муу-8 гэсэн үзүүлэлттэй гарсан. Компаниудын нээлттэй байдлын талаарх хураангуйг (Хавсралт М)-д, идэвхи санаачлагата сайн оролцсон компаниудыг энэ тайлангийн 7.14-д тус тус харуулав.

Төрийн байгууллагуудын хувьд сайн-4, дунд-2, муу-2 гэсэн үнэлгээтэй гарсан байна.

Сангийн яам, Төрийн өмчийн хороо зэрэг байгууллагуудад дараахь шалтгааны улмаас “Дунд” гэсэн үнэлгээг өгсөн. Үүнд:

- Төрийн өмчийн хороо нь Засгийн газрын 2007 оны 80 дугаар тогтоолд санаачлагын тайланг гаргах чиг үүргийг зааж өгсөн боловч нэгтгэлийн тайланг жилийн жилд гаргаж өгдөггүй.
- Сангийн яам нь ОУИТБС-ын тайлангийн нэгтгэлийг хянах, мөн нэгтгэл тайлангийн явцад аливаа нэгэн тодруулагыг хүсэхэд, хариу өгөхдөө хойрго ханддаг.

БОАЖЯ-ны Байгалийн нөөцийн газар, Ашигт малтмалын газар зэрэг байгууллагуудад дараахь шалтгааны улмаас “Муу” гэсэн үнэлгээг өгсөн. Үүнд:

- БОАЖЯ-ны Байгалийн нөөцийн газар нь нэгтгэл тайлангийн ажилтай холбоотой мэдээлэл авах тухай албан бичгийг 2 сарын 17-нд хүргүүлэхэд, хариуг 4 дүгээр сарын 8-ны өдөр ирүүлсэн.
- Нөгөө талаас жилийн жилд байгаль хамгаалахтай холбоотой зардал дээр нилээд өндөр зөрүү гардаг, үүнтэй холбоотойгоор компаниас тайланг авахдаа нягтлан бодогчийн гаргасан санхүүгийн тайлантай нь уялдуулж үнэн зөв мэдээлэл авах тал дээр санаачлагагүй ажилладаг, зөрүү гаргахгүй байх талаар ямар нэгэн арга хэмжээ авдаггүй.
- Ашигт малтмалын газар нь 2009 онд батлагдсан Монгол Улсын “Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай” хууль, мөн “Ашигт малтмалын тухай” хуульд нөөц ашигласны төлбөрийг ам.доллараар хүлээж авах боловч тухайн өдрийн Монголбанкны ханшаар тооцно гэсэн заалтуудыг мөрдөж ажиллаагүйн улмаас ОУИТБС-ын тайланг гаргахдаа тус ажлын албаны тайлангийн маягтад дур мэдэн “Ашигт малтмалын ашиглалтын

болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр (доллар)” гэсэн мөр нэмж ам.доллараар нь гаргасны улмаас жил бүр зөрүү үүсдэг.

- Лицензийн худалдсан, шилжүүлсэн бүртгэл хөдөлгөөн бүрэн гүйцэд хийгдэдэггүйн улмаас өмнөх компанийн нэр дээр төлбөр нь хийгдсэнээс зөрүү их үүсдэг. Бүх оролцогчдын нээлттэй байдлын талаарх хураангуйг (Хавсралт Н)-д харуулав.

2.7 Аудитын болон Санхүүгийн Стандартууд

- i. ОУИТБС-ын тайлангийн нэгтгэлд ирүүлж буй мэдээлэл нь олон улсын стандартын дагуу аудитлагдсан тоонд үндэслэхийг шаарддаг.

Компанийн НББ-ийн талаарх судалгааны нэг хэсэг болгож бид тухайн компанийн аудитын тайланд аудитыг Аудитын олон улсын стандартын дагуу гүйцэтгэсэн эсэхийг баталгаажуулж өгөхийг хүссэн. Судалгааны хариуг 31 компани (Хавсралт К) ирүүлсэнээс бүх компанийн санхүүгийн тайлангийн аудитыг АОУС-ын дагуу гүйцэтгэсэн гэсэн хариултыг өгсөн.

Бид түүнчлэн ОУИТБС-ын нэгтгэлд ирүүлсэн мэдээлэл олон улсын стандартад нийцсэн аудитлагдсан тоонд үндэслэсэн гэдгийг нотолж өгөхийг тухайн компаниудын Захирлуудын зөвлөлөөс хүссэн.

- ii. Бид компаниудаас СТОУС-ын хэрэглээ хэр байгаа талаар судалгаа явуулсан. Судалгааны үр дүнд дараах байдалтай байна.

НББОУС 12 – Орлогын татвар – Хойшлогдсон татварыг нягтлан бодох бүртгэлд тусгадаггүй.

Судалгаанд хариу ирүүлсэн 31 компаниас 23 нь хойшлогдсон татварыг нягтлан бодох бүртгэлд тусгадаггүй гэсэн хариулт өгсөн. Ихэнх хүмүүс хойшлогдсон татварын талаарх ойлголт байхгүйгээс уг концепц санхүүгийн тайлан бэлтгэхэд ашиглагддаггүй байна.

Хэдий тийм ч уг стандартыг хэрэгжүүлэх, санхүүгийн тайлангаар илэрхийлэгдсэн татварын өмнөх ашиг, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлангийн татвар ногдуулах орлогын хооронд үүсэх байнгын ба түр зөрүүг бүртгэх, тайлангуудын уялдааг хангах, тайлант хугацааны хойшлогдсон татварын хэмжээг тодорхойлоход туслах зорилгоор Сангийн сайдын 2010 оны 05 дугаар сарын 25 -ны өдрийн 121 дугаар тушаалаар Санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах журам, түүнийг зохицуулах тайлангийн маягтыг ААН, байгууллагууд дагаж мөрдөх шаардлагатай байна. Мөн Үндэсний татварын ерөнхий газраас уг зөрүүг зохицуулах, түүний тайлагналыг нийтээр дагаж мөрдүүлэх зорилгоор ААНОАТ-ын тайлангийн маягтыг 2011 оны 1-р улирлаас дахин өөрчилж, энэ талаар илүү дэлгэрэнгүй, тодорхой тусгах болсон.

НББОУС 37 Нөөц, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө

Судалгааны үр дүнгээс байгаль орчныг нөхөн сэргээх нөөцийг нийтээрээ байгуулдаггүй нь харагдсан. НББОУС 37 Нөөц, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө стандартыг хэрэгжүүлж, байгалийг нөхөн сэргээх нөөц байгуулах талаар Сангийн сайдын 2011 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 12 дугаар тушаалаар “Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын зардлыг нягтлан бодох бүртгэлд бүртгэх журам”-д зааж өгсөн байна.

НББОУС 16 – Үндсэн хөрөнгө (“НББОУС 16”) – Зах зээлийн үнэлгээ

НББОУС 16 –ийн 34-д заасны дагуу үндсэн хөрөнгийг дахин үнэлэх хандлагыг сонгосон бол 3-5 жил тутамд үндсэн хөрөнгийн үнэлгээг хянаж үзэн, шаардлагатай тохиолдолд дахин үнэлгээг үе тутамд хийж байхыг энэхүү стандартаар шаарддаг. Аж ахуйн нэгжүүд үндсэн хөрөнгийн үнэлгээ буурсан нь тодорхой болсон ч дахин үнэлгээ хийдэггүй нь ажиглагдаж байна.

НББОУС 24 – Холбоотой талын гүйлгээ

Компаниуд холбоотой талын гүйлгээг тодорхойлж санхүүгийн тайланд тодруулгыг хангалттай хийдэггүй.

3. МОНГОЛЫН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТАЛААР

Монгол улс нь байгалийн баялгийн хувьд ихээхэн нөөцтэй ба ялангуяа, алт, зэс, нүүрс болон бусад ховор байгалийн эрдэс баялагуудтай. Алт болон зэсний орд нь нөөцөөрөө дэлхийн томоохон нөөцүүдэд тооцогддог.

Өнөөдөр Монголын уул уурхайн салбар 42 мянга гаруй (буюу нийт ажиллах хүчний 4%) хүнийг ажлын байраар хангаж, Монгол улсын экспортын нийт орлогын 75%-ийг бүрдүүлж байна.

Эдийн засагт олборлох үйлдвэрлэлийн үзүүлж буй нөлөө дараахи байдалтай байна:

	2004	2005	2006	2007	2008	2009
Дотоодын нийт бүтээгдэхүүний хувьд	17.3%	18,0%	30.0%	27,5 %	28.2%	22.5%
Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний хувьд	64.7%	65,5%	68,4%	67.8%	64.3%	65.9
Экспортын нийт бүтээгдэхүүний хувьд	70.80%	75.8%	76,0%	68,8%	80.7%	65.4%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Уул уурхайн үйлдвэрлэлээс гадна газрын тос олборлолтын талаар дор тайлбарлалаа.

А. Эрдэс баялаг

Монгол улс нь алт, зэс, нүүрс, жонш, төмрийн хүдэр болон вольфрамыг үйлдвэрлэдэг ба эдгээрийн бараг дийлэнх болох зэсийн баяжмал, молибдени, нүүрс болон цайрыг БНХАУ, жоншийг ОХУ, АНУ болон Украин улсуудад мөн алтыг Канад, АНУ, Англи болон БНХАУ улсуудад экспортолж байна.

Монголын АМГ-аас ашиглах болон хайгуул хийх боломжтой нөөцүүдийн талаарх мэдээллийг дараахи байдлаар нэгтгэн гаргадаг:

Монголын байгалийн нөөц


Natural resources	Number of deposits
Gold	511
Copper	6
Molybdenum	3
Lead	4
Zinc	4
Tin	12
Tungsten	17
Iron	29
Coal	85
Fluorite	83
Limestone	48
Clay	81
Sand and gravel	84
Sand for construction materials	53

[МЯН.ТОНН]

	2004	2005	2006	2007	2008	2009
Бүтээгдэхүүн						
Жонш	206.7	233.4	239.4	245	219.1	344.2
Жонш баяжмал	102.7	93.7	108.3	109.9	115.7	115.3
Зэсийн баяжмал	130	126.3	129.7	130.2	126.8	129.8
Молибдений баяжмал	1.14	1.15	1.41	1.98	1.78	2.41
Цагаан тугалгийн баяжмал/50%/	0.022	0.047		0.03	0.09	0.015
Вольфрамын баяжмал/68%/	0.077	0.078	0.182	0.244	0.142	0.039
Нүүрс	6665	7517.1	8074.1	9237.6	9691.6	13164
Алт	0.019	0.022	0.021	0.018	0.015	0.001
Катод зэс	2.38	2.48	2.62	3.01	2.59	2.47
Төмрийн хүдэр	33.5	167.7	180	265.1	1387.4	1379.0
Цайрын баяжмал /нойтон/		22.8	109.9	154.7	143.6	156.5
Каст зэс		0.20	0.22			
Молибдений хүчил			0.16	2.66	2.11	0.157

2008 оны хувьд Монгол улсын нийт экспортын орлогын 75% эрдэс баялагийн бүтээгдэхүүний экспортоос бүрджээ. Үүний 33% нь зэс, 24% нь алт, 7% нь нүүрс, 4% нь газрын тос, 6% нь цайр эзэлжээ. Нийт экспортын орлогын 66%-ийг БНХАУ-с, 17%-ийг Европоос, 11%-ийг Канад болон АНУ-с, 3%-ийг ОХУ-с мөн үлдсэн хувийг бусад улс орноос авчээ. (АМГ, 2009; Дэлхийн Банк). Мөн АМГ нь тухайн салбарын санхүүгийн хувьд оруулж буй хувь нэмрийг бас нэгтгэн гаргадаг. Үүнийг дор хүснэгтээр харуулав.

Уул уурхайн салбарын улсын эдийн засагт үзүүлж буй үүрэг роль




Б. Нүүрс

Нүүрсний ордны хувьд томоохон хэмжээтэй нь нутаг дэвсгэрийнхээ зүүн хэсгээр түгээмэл оршдог ч ерөнхийдөө тархаж байрладаг. Монгол улс нь дэлхийн хэмжээнд нүүрсний ордны хувь хэмжээгээрээ тэргүүлэх байр суурь эзэлдэг ба геологийн нөөцийн хувьд бараг 162.3 тэрбум тонн хүрэх бөгөөд нүүрсний чанарын хувьд нүүрсний шатнаас антрацит ангилал хүртэл байдаг.




Үйлдвэрлэлийн хувьд сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай байгаа ба дотоодын хэрэгцээ нь тогтмолжиж, экспортлох байдал нь голчлон БНХАУ руу төвлөрч байгаа.

2001-2009 оны нүүрсний олборлолт болон экспортын хэмжээг харуулбал:



Эх сурвалж: АМГ-ын веб хуудас




В. Газрын тос

Монголын нийт орд газрын 25 хайгуулын хэсэгт олон улсын сонгон шалгаруулалт зарлагдсан ба Монголын ПТГ нь дахин 4 газар дээр зарлахаар ажиллаж байна. Хайгуулын хэсгүүд нь гол төлөв нутгийнхаа өмнөд хагас, түүнчлэн төв, зүүн болон баруун хэсгээр оршдог. Зүүн говийн хэсэг нь ерөнхийдөө газрын тосны 4 дэд-бэлчир хэсэгт хуваагддаг.

Зүүн Баянгийн бэлчир хэсэг нь 1941 онд нээгдсэн ба эрчимтэй хайгуул болон олборлолтын ажил хийгдсэн. Тамсагийн бэлчир хэсэг нь Монголын зүүн хэсэгт байдаг бөгөөд 1990-2001 оны үед нээгдсэн ба БНХАУ-ын Үндэсний Тосны Корпораци нөөцийн судалгаа хийж 1.5 тонн хэмээн тогтоожээ. Сүүлийн жилүүдэд, нутгийн баруун хэсгийн Цагаан Элс болон бусад орд газруудад хайгуулын болон олборлолтын ажлууд хийгдсээр ирсэн. 1994-2008 оны хайгуулын ажлын хүрээнд нийт 17,600 км талбайн ажил нь 1 км газрыг хамарсан 2 талт, 6,000 км газрыг хамарсан 3 талт ажлууд болон 448 худгийн өрөмдлөг, 952 сая ам.долларын шууд гадаадын хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

2008 онд нийт газрын тосны хайгуул болон олборлолтын ажлыг Канадын 1 компани ("Шаман Ресорси" ХХК), Хятадын 3 компани ("Петро Чайна Дачин Тамсаг Монгол" ХХК, "Доншен Петролиум" ХХК болон "Чайна Голден Сий" ХХК) ба Монголын 1 компани ("Петро Матад" ХХК) нар хийж гүйцэтгэсэн байна. Тосон-Уул болон ПЭССИ-97 нь 50 ба 31 үйлдвэрлэлийн худаг тус тус гаргах

ажил хийгдсэн байна. Тосон-Уул нь өдөрт 3,800 тэрбум, ПЭССИ-97 өдөрт 1,800 тэрбум олборлолт хийж өссөн дүнгээрээ нийт 3.4 сая (3.1 сая нь экспортлогдсон, учир нь Монгол улс нь өөрийн газрын тос боловсруулах үйлдвэр байхгүй). Нийт улсын хэмжээнд, 2010 гэхэд “Петро Чайна Дачин Тамсаг Монгол” ХХК нь жил бүр ойролцоогоор 3 сая орчим бареллийг үйлдвэрлэх боломжтой байгаа ба энэ тооцоо 11.3 саяд хүрэх магадлалтай байна.



Эх сурвалж: Монголын Газрын Тосны Газар

4. ХАНДЛАГА

4.1 Тайлан нэгтгэлийн хамрах хүрээ

“Харт Нойрс” Лтд ба “Улаанбаатар Аудит Корпораци” ХХК-ийн (“Зөвлөхүүд”) консерциум нь Гэрээт ажлын даалгаварт тусгагдсан ажил үүргүүдийг хийж гүйцэтгэхээр сонгогдсон.

4.2 Хязгаарлалтууд/Ажлын үзэл баримтлал

Энэхүү тайланд өөрөөр заагаагүй бол, нэгтгэл нь бэлэн мөнгө болон бэлэн бусаар хийгдсэн төлбөрүүдийг нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурийн дагуу хийгдсэн.

Аливаа материаллаг дүн бүхий орлого эсвэл төлбөрүүд нь тайлангийн маяганд бүртгэгдэлгүй орхигдсон тохиолдолд бидний ажил үүрэг тэднийг олж илрүүлэхэд хангалтгүй юм. Тиймээс аливаа орхигдсон материаллаг дүн бүхий орлого эсвэл төлбөрүүд нь манай тайланд хамрагдахгүй болно.

Гэрээт ажлыг гүйцэтгэхдээ бид оролцогч талуудаас ирүүлсэн мэдээ мэдээлэл, тайлбарууд дээр тулгуурласан. Эдгээр мэдээллүүдийн нягт нямбай байдал болон бүрэн гүйцэд байдалд аливаа нэгэн нотолгоо хийгдээгүй болно.

Энэхүү тайланг Англи, Монгол хэл дээр бэлтгэсэн. Англи, Монгол хувиудын хооронд зөрүүтэй эсвэл зөрчилтэй зүйл гарсан тохиолдолд Англи хувийг баримтлана.

Энэхүү тайланд 2011 оны 6 дугаар сарын 8-ны өдрийг хүртэлх хугацаанд хүлээн авсан мэдээллүүдийг нэгтгэн оруулсан болно. Энэ өдрөөс хойш хүлээн авсан мэдээллүүдийг энэхүү тайланд оруулаагүй болно.

4.3 Үндсэн суурь ба материаллаг байдал

СЯ-ны зүгээс 2009 оны ОУИТБС-ын Нэгтгэлд ашиглагдахаар Ажлын Хэсгээс батлан гаргасан маягтын дагуу бөглөн ирүүлсэн олборлох үйлдвэрлэл эрхэлдэг нийт 363 компанийн ЗГ-ын хүлээн авсан дүнг харуулсан тайланг гаргасан. Энэхүү тайланд хамрагдсан бүхий л байгууллагууд, аймгууд болон сумд, Засгийн газрын харъяа яам, агентлагууд болон бусад байгууллагуудыг “Засгийн газрын байгууллагууд” гэсэн тодотголтойгоор нэрлэсэн.

2009 онд ОУИТБС-ын тайлангаа өгсөн 129 компани байгаа ба дээрхи ЗГ-аас ирүүлсэн компаниудын мэдээлэлтэй нийлүүлж тоон мэдээлэл гаргасан байна.

2010 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн МОУИТБС-ын Үндэсний Зөвлөлийн 7 дугаар хуралдааны шийдвэрээр төлбөрийн материаллаг байдал буюу татвар төлбөрийн нийлбэр дүнгээр 50 сая төгрөгнөөс дээш материаллаг орлого бүхий аж ахуй нэгжийг олон улсын хөндлөнгийн аудитад хамруулахаар шийдвэр гарсаны дагуу 2009 оны нэгтгэл тайланд дээрхи тоон мэдээллээс үндэслэж 101 компанийг хамруулахаар сонгосон байна.

Энэхүү 101 компаниудыг “Хамрагдсан компаниуд” гэсэн тодотголтойгоор нэрлэсэн ба Хавсралт Б-д харуулсан.

Нийт төлбөр болон орлогын хооронд үүсэх зөрүүг хянан үзэх материаллаг байдал дээр Ажлын Хэсгийн зүгээс аливаа нэгэн заавар удирдамж гаргаж өгөөгүй.

2010 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн МОУИТБС-ын Үндэсний Зөвлөлийн 7 дугаар хуралдааны шийдвэрээр материаллаг төлбөрийн тайлагнах доод хэмжээ татвар, төлбөр, хураамж, бусад орлогын нэр төрөл бүр дээр 10 мянган төгрөг (Тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 5.8, 13.1-д аж ахуй нэгжийг бүртгэх, гэрчилгээ олгох төлбөр 10,000 төгрөг)-өөс дээш хэмжээний татвар төлбөр, хураамж, үйлчилгээний хөлс, хандив дэмжлэгийг ОУИТБС-ын тайланд заавал хамруулахаар заасан ба уг шийдвэр нь 2009 оны нэгтгэлийн тайлангийн тайлагналын хугацааны дараа гарсан учраас энд хамруулах боломжгүй болсон.


Энэхүү 2009 оны нэгтгэлийн тайлангийн явцад уг материаллаг байдлаас доошхи хэмжээний зөрүү дүнг шууд тайлангаас тохируулах боломжтой гэсэн үндэслэл үүссэн. Гэхдээ материаллагын талаар илүү тодорхой зааж өгөөгүй нь бидний ажлын явцад ажиглагдсан. Энэ нь нэр төрөл бүр дээр нэг удаагийн төлбөрийн хувьд юм уу эсвэл нэр төрөл бүр дээр нийт төлбөрийн хэмжээгээр энэхүү материаллаг хэмжээ хамааралтай эсэх нь тодорхойгүй үлдсэн.

4.4 Хандлага ба арга

Бидний энэхүү ажилд хэрэглэсэн арга хандлагын талаар товч дурьдвал:

- Монголын ОУИБСАА-тай нягт харилцан ярилцаж, Монголын ОУИБС-ын заавар, журмуудтай танилцан, бүрэн гүйцэд ойлголт авч, холбогдох бичиг баримтуудыг үзэх, ялангуяа, тайлагнах маягтуудад зориулан боловсруулсан нягтлан бодох бүртгэлийн зарчмууд, аргачлал хандлагууд болон боловсруулсан алдааны хязгаар зэрэгтэй танилцсан.
- Хамрагдсан компаниудын маягтуудын мэдээллийг нэгтгэн хүснэгтлэх, эдгээр маягтуудад буруу зөрүү (шаардлагын дагуу мянгачлагдаагүй дүн) бөглөгдсөн зүйлсийг хасан (татварын торгууль, акт гэх мэт) зохих залруулгыг хийсэн. Тайлагнагдсан дүнг аль болох зөрүүгүй шийдвэрлэх зорилгын үүднээс нэгтгэлийн ажлыг гүйцэтгэсэн.
- Зөрүүнүүдийг шийдвэрлэхийн тулд компаниуд болон Засгийн газрын байгууллагуудтай хамтран ажилласан.
- Нэгтгэлийн явцад хийгдсэн бүхий л залруулгуудыг тайлбарласан.
- Шийдвэрлэгдээгүй үлдсэн зарим нэгэн зөрүүнд ЗГ-ын байгууллагатай протокол үйлдэж, цаашид зөрүү үүсгэхгүй байх талаар тодорхой зөвлөмжүүдийг өгсөн.

4.5 Ажлын чиглэл, хоорондын уялдаа



4.6 Аргачлал

Уул уурхайн компаниудын өгөгдлүүд буюу тоон үзүүлэлтүүд нь Монголын ОУИТБСАА-аас гаргасан Маягт №1 дээр тайлагнагдсан ба тухайн маягт нь компанийхаа аудиторар шалгагдалгүй бэлтгэгдсэн болохыг бид ажигласан. Тиймээс, бид Удирдлагын хариуцлагын захидлыг бэлтгэн компани тус бүрийн Захирлуудын зөвлөлд илгээж, тайлагнасан мэдээлэл нь компанийн аудиторроор хянагдсан эсэхийг баталгаажуулахыг зорьсон.

Маягт №1 нь дараахи үндсэн 2 бүлэгтэй:

Хүрээ 1: Хүрээ 1 нь үндсэн 2 хэсгээс бүрдэх ба эхний хэсэгт олборлох үйлдвэрлэл эрхэлдэг компаниудын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, борлуулалтын дүнг биет нэгж болон мөнгөн дүнгээр илэрхийлсэн байна. Хоёр дахь хэсэгт олборлох үйлдвэрлэл эрхэлдэг компаниудын Засгийн газарт төлсөн татварууд, төлбөрүүд, төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашиг, хүлээн авагч Засгийн газрын байгууллагуудад төлсөн бусад төлбөрүүд, Засгийн газрын байгууллагуудад өгсөн хандив, дэмжлэгүүд болон байгаль хамгаалахтай холбогдон гарсан зардлуудыг илэрхийлдэг.

Хүрээ 2: Орлогууд ба орлогын урсгалууд (сайн дурын үндсэн дээр)

Уул уурхайн компани тус бүрийн Маягт №1 дээрх үзүүлэлт бүрээр тайлагнасан төрийн болон орон нутгийн төсөвт төлсөн татварууд болон төлбөрүүдийг компьютерийн "ЭКСЕЛ" программын хүснэгтүүдийг ашиглан Засгийн газрын байгууллагуудын бэлтгэсэн тайлантай (Монголын ОУИТБСАА-аас гаргасан Маягт № 2 ба 3) компани тус бүрээр тулгасан болно.

Ийнхүү тулгах явцад үүссэн бүхий л зөрүүнүүдийг тогтоосон шалгуурын дагуу ач холбогдолтой буюу ач холбогдолгүй гэж ангилан хүснэгтэлсэн.

Үүссэн ач холбогдолтой зөрүүнүүдийн хувьд МОУИТБСА-аас гаргасан Маягт №3 дээрх нэгтгэсэн дүнгүүдийг ЗГ-ын байгууллагууд болон УТЕГ-аас Монголын ОУИТБСАА-аас гаргасан Маягт №2-ын дагуу ирүүлсэн мэдээллүүдээс шалгасан.


Ач холбогдолтой зөрүү бүрийн хувьд дараахи зүйлсийг тодорхойлно.


- Холбогдох ЗГ-ын байгууллагууд ба татварын албадаас (Маягт №2 дээрх дүнг харуулах үүднээс хүлээн авсан дүн буюу орлого хийгдсэн он сар өдөр, дүнгүүдийн дэлгэрэнгүй) дэлгэрэнгүйг авсан. Энэхүү дэлгэрэнгүйг уул уурхайн компаниудын төлсөн төлбөрүүдийн дэлгэрэнгүй мэдээлэлтэй тулган шалгахад хэрэглэснээр зөрүүнүүдийн боломжит тайлбаруудыг олж авсан.
- Уул уурхайн компаниудын бэлтгэсэн Маягт №1 нь тус компанийхаа аудиторроор хянагдсан эсэхийг мэдсэний үндсэн дээр тухайн компанийн хувьд үүссэн зөрүүнүүдийн тоо хэмжээ, төрөл (үзүүлэлт) болон бусад холбогдох хүчин зүйлсийн талаар бид өөрсдийн мэргэжлийн үнэлэмж шүүмжлэлийг ашиглан дараахи байдлаар шийдвэр гаргасан. Үүнд:
 - Монголын ОУИТБСА-аас гаргасан Маягт №1 дээрх өгөгдлүүдийн үнэлгээний байдлыг хянаж үзэх. Бид энэхүү ажлыг гүйцэтгэхдээ Зөвшилцсөн горимоор гүйцэтгэх нэгтгэлийн олон улсын стандартыг ашигласан. Үүний тулд гүйцэтгэсэн горимууд нь үзүүлэлт бүрийн шинж чанараас хамаарч болно, түүнчлэн өөр бусад төрлийн эх сурвалж болох баримт бичгүүдийг ашиглах, дүн шинжилгээний хяналт, тоонуудыг батлан нотлохын тулд хийгдэх хараат бус тулган баталгаажуулалт зэргээс бүрдсэн. Хандлагын хувьд зөвхөн тодорхойлогдсон ач холбогдолтой зөрүүнүүдийн хувьд ч бус зарим тохиолдолд компанийн тайлагнасан бүхий л болон хэсэг өгөгдлүүдийг ч хамран хийгдэх шаардлага гарч байсан.
 - Монголын ОУИТБСА-аас гаргасан Маягт №1-ээр ирүүлсэн тоонуудын тооцооллыг харж шалгахын тулд холбогдох компаниудын зүгээс тэдний тайланд тусгагдсан дүнгийн

дэлгэрэнгүй задаргааг (төлбөр хийгдсэн он, сар, өдөр болон дүнгүүд) авах хүсэлтийг гаргасан.

- Ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээллээр хангалттай тайлбар олж аваагүй тохиолдолд бид ялангуяа ЗГ-ын холбогдох байгууллагуудтай шийдэгдээгүй зөрүү тус бүрээр протокол үйлдэн, зөрүү тус бүрийн шалтгааныг тайлбарласан.
- Хэрвээ дээрх үйл явцын хүрээнд зөрүүнүүд нь шийдвэрлэгдэх боломжгүй гэж тооцогдвол холбогдох ЗГ-ын байгууллагууд болон тухайн компанийн хүмүүстэй хамтарсан уулзалтыг зохион байгуулж, Ажлын хэсгээс дэмжлэг болон нэмэлт удирдамж аван тодорхой зөрүүг бууруулах арга хэмжээг авч байсан.
- Тулган шалгах явцад тодорхойлогдсон зөрүүнүүдийг ангилж, зөрүүний шалтгааныг (эсвэл шаардлагатай бол шийдэгдээгүй байдлаар нь үлдээх) тайлбарласан. Энэ нь Маягтуудыг бэлтгэх явцад голлон үүсдэг асуудлууд болон ОУИТБСАА-ны ажлын явцыг тодорхойлоход чиглэл, зөвлөмжүүдийг өгсөн.


4.7 Талуудын оролцооны схем






4.8 Хамрагдсан компаниуд

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тайланд орж байгаа нийт 101 компанийг эрхэлж буй үйл ажиллагааны чиглэлээр нь авч үзвэл дараах байдалтай байна.




2009 оны татварын жилд Монгол улсын ЗГ-т төвлөрүүлсэн татвар, төлбөр, хураамж, хандив тусламжийн хэмжээг нэгтгэлд хамрагдсан 101 компанийн хувьд авч үзвэл дараах бүтэцтэй байна.

(сая төгрөгөөр)



Компаниудын 2009 онд улсад төлсөн татварын дүнг хувийн жингээр нь нь харуулбал:



Дээрх диаграмаас харахад “Эрдэнэт Үйлдвэр” ХХК нь хамгийн өндөр орлогыг төвлөрүүлсэн байна.

5. САНХҮҮГИЙН УРСГАЛЫН НЭГТГЭЛ

5.1 Анхлан тайлагнасан санхүүгийн нийт урсгал

Нэгтгэлийн явцад “Оюутолгой” ХХК-ийн ЗГ-аас худалдан авсан өрийн бичгийн орлого, төрийн өмчийн ногдол ашиг болон хүлээн авагч Засгийн газрын байгууллагуудад төлсөн бусад төлбөрүүдийг Засгийн газар хүлээн авсан тухайгаа өөрийн тайландаа тусгаагүйгээс анхны нэгтгэл хийхэд 265,5 тэрбум төгрөгийн зөрүү үүссэн.

Бүлэг	Тайлагнасан байдал		Анхны нэгтгэлийн зөрүүнүүд мян.төг
	Засгийн газрын байгууллагууд	Компаниуд	
	мян.төг	мян.төг	
1 Татварууд	299,868,830	299,176,914	691,916
2 Төлбөрүүд	137,864,995	137,842,368	22,627
3 Хураамжууд, үйлчилгээний шимтгэлүүд	10,015,277	9,608,983	406,294
4 Төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашиг	9,035,833	104,217,578	(95,181,745)
5 Хүлээн авагч Засгийн газрын байгууллагуудад төлсөн бусад төлбөрүүд	-	171,024,055	(171,024,055)
6 Засгийн газрын байгууллагуудад үзүүлсэн хандивууд	3,852,268	5,616,326	(1,764,058)
7 Байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардал	7,577,228	6,235,945	1,341,284
Нийт	468,214,430	733,722,168	(265,507,738)

Доорх хүснэгт нь компаниудын ирүүлсэн маягтын дүнгүүдийг ЗГ-аас ирүүлсэн маягтын дүнгүүдтэй харьцуулан гаргасан цэвэр дүнгүүдийг харуулж байна. Цэвэр зөрүүг задлан харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

	МЯН.ТӨГ
Компаниудын төлсөн дүн ЗГ-ын хүлээн авсан дүнгээс их	(267,969,859)
ЗГ-ын хүлээн авсан дүн компаниудын төлсөн дүнгээс их	2,462,121

5.2 Тохируулгын дараах санхүүгийн нийт урсгал

Нэгтгэлийн ажлын дараа зөрүүг шийдвэрлэх зорилгоор 2 талаас дэлгэрэнгүй мэдээлэл авах шаардлагатай болсоны үндсэн дээр ЗГ-ын байгууллагууд болон компаниудаас 2011 оны 4 дүгээр сарын 15-ны дотор мэдээлэлээ гаргаж өгөх албан бичгийг хүргүүлж, хариу мэдээлэл авч, зохих тохируулгыг хийснээр нийт шийдэгдээгүй зөрүү **145.9** тэрбум төгрөг болсон бөгөөд энэ нь оролцогч талуудаас өөр өөр тоо ирүүлсэний улмаас мөн "Оюу толгой" ХХК-ийн Засгийн газрын өрийн бичгийг худалдан авсан орлогыг Засгийн газар тайлагнаагүйгээс үүссэн. Энэ зөрүү нь ЗГ-ын нийт урсгалын 25%-г эзэлж байсан бөгөөд ОУИТБС-ын нэгтгэлийн нийт дүнд нилээд материаллаг хэмжээтэй байсан. .

"Оюу толгой" ХХК-ийн Засгийн газрын өрийн бичгийг худалдан авсан орлоготой холбоотой үүсээд байсан энэхүү зөрүүг аудиторудын зүгээс залруулаагүй ба уг зөрүүг хэрхэх талаар ажлын хэсгээс чиглэл аван шийдвэрлэхээр тохируулгын дараах санхүүгийн нийт урсгалыг 2 хувилбараар оруулсан.

Ажлын даалгаварт эдгээр зөрүүнүүдийг хэрхэн шийдвэрлэх талаар зөвлөмж өгөхийг даалгасан. Энэ талаар энэхүү тайланд тодорхой зөвлөмжийг оруулсан.

Тохируулгын дараах санхүүгийн урсгалыг харуулбал дараах байдалтай байна.

(мянган төгрөгөөр)

Бүх компаниуд								
Компаниас улсын болон орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөр	Анхны урсгал		Анхны нэгтгэлийн зөрүү*	Тохируулга		Тохируулгын дараа		Тохируулгын дараах шийдэгдээгүй зөрүү
	ЗГ-ын байгууллагын дүн /УТОХГ/	Компанийн дүн		ЗГ	Компани	ЗГ	Компани	
Төлсөн татварууд	299,868,830	299,176,914	691,916	643,031	1,306,013	300,511,861	300,482,927	28,935
Төлбөр	137,864,995	137,842,368	22,627	(1,198,619)	(368,278)	136,666,376	137,474,090	(807,714)
Хураамж, үйлчилгээний хөлс	10,015,277	9,608,983	406,294	853,290	1,778,884	10,868,567	11,387,867	(519,300)
Төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашиг	9,035,833	104,217,578	(95,181,745)	95,059,481	(122,264)	104,095,313	104,095,313	-
Хүлээн авагч Засгийн газарт төлсөн бусад төлбөрүүд	-	171,024,055	(171,024,055)	18,453,999	(9,148,056)	18,453,999	161,875,999	(143,422,000)
Төрийн байгууллагад үзүүлсэн дэмжлэг	3,852,268	5,616,326	(1,764,058)	1,828,212	1,226,834	5,680,480	6,843,159	(1,162,680)
Байгаль хамгаалах арга хэмжээнд зарцуулсан зардал	7,577,228	6,235,945	1,341,284	(1,335,957)	(10,214)	6,241,271	6,225,731	15,540
Нийт дүн	468,214,430	733,722,168	(265,507,738)	114,303,437	(5,337,082)	582,517,867	728,385,086	(145,867,219)

*ЗГ-ын байгууллагын тайлагнасан дүн компанийн дүнгээс (+) их, бага (-)

5.3 Ажлын хэсгийн 2011 оны 4 сарын 29-ний өдрийн хуралдаанд танилцуулсан санхүүгийн нийт урсгал

Ажлын хэсгийн 4 дүгээр сарын 29-ны хуралдаанаас "Оюутолгой" ХХК-тай холбоотой 143.4 тэрбум төгрөгийн зөрүүний талаар "Цаашид ийм орлого (төлбөр)-үүд гарч ирнэ тэгэхээр тайлагнах нь зүйтэй"

гэсэн шийдвэр гарч, зөрүүг ЗГ талд залруулсанаар шийдэгдээгүй зөрүү 2.4 тэрбум төгрөг болж, Ажлын хэсгийн анхны хуралдаанд танилцуулсан. Энэхүү зөрүүний ихэнх хувийг төлбөр, хураамж, үйлчилгээний хөлс, Төр, засгийн байгууллагуудад үзүүлсэн хандив дэмжлэг эзэлж байна.

(мянган төгрөгөөр)

Бүх компаниуд								
Компаниас улсын болон орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөр	Анхны		Анхны зөрүү*	Тохируулга		Тохируулгын дараа		Шийдэгдээгүй зөрүү
	ЗГ-ын байгууллагын дүн /УТОХГ/	Компанийн дүн		ЗГ	Компани	ЗГ	Компани	
Төлсөн татварууд	299,868,830	299,176,914	691,916	643,031	1,306,013	300,511,861	300,482,927	28,935
Төлбөр	137,864,995	137,842,368	22,627	(1,198,619)	(368,278)	136,666,376	137,474,090	(807,714)
Хураамж, үйлчилгээний хөлс	10,015,277	9,608,983	406,294	853,290	1,778,884	10,868,567	11,387,867	(519,300)
Төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашиг	9,035,833	104,217,578	(95,181,745)	95,059,481	(122,264)	104,095,313	104,095,313	-
Хүлээн авагч Засгийн газарт төлсөн бусад төлбөрүүд	-	171,024,055	(171,024,055)	162,653,999	(8,370,056)	162,653,999	162,653,999	-
Төрийн байгууллагад үзүүлсэн дэмжлэг	3,852,268	5,616,326	(1,764,058)	1,828,212	1,226,834	5,680,480	6,843,159	(1,162,680)
Байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардал	7,577,228	6,235,945	1,341,284	(1,335,957)	(10,214)	6,241,271	6,225,731	15,540
Нийт дүн	468,214,430	733,722,168	(265,507,738)	258,503,437	(4,559,082)	726,717,867	729,163,086	(2,445,219)

5.4 Ажлын хэсгийн 2011 оны 6 сарын 2-ний өдрийн хуралдаанд танилцуулсан санхүүгийн нийт урсгал

ОУИТБС-ын ажлын хэсгийн 2011 оны 4 дүгээр сарын 29-ний хуралдаанаас шийдвэрлэгдээгүй зөрүү тус бүр дээр нэмэлт тодруулга хийж, учир шалтгааныг компани, төрийн захиргааны байгууллага, аймаг, сум бүрээр гаргаж, зөрүүг хариуцагч бүртэй протокол байгуулж, баталгаажуулах тухай гарсан шийдвэрийн дагуу ЗГ-ын байгууллагууд руу дахин албан бичиг хүргүүлж, газар дээр нь очиж хамтран ажиллах, байнга мэдээлэл солилцох, хандив дэмжлэг хүлээн авсан Төр, засгийн байгууллагууд, орон нутгийн ЗДТГ-т хүргүүлсэн албан бичгийн хариуг авахын тулд утсаар ярьж шаардах, мөн зарим байгууллагууд дээр очиж холбогдох хүмүүстэй уулзаж, ярилцан мэдээллийг гаргуулах, компаниудаас төлсөн гэж ирүүлсэн зөрүүтэй татвар, төлбөр, хураамж, хандив, дэмжлэгийг нотлох анхан шатны баримтыг хувилуулж авах талаар албан бичиг илгээж, холбогдох хариуг авах зэрэг ажлыг хийж, идэвхитэй зохион байгуулж гүйцэтгэсний үр дүнд шийдэгдээгүй зөрүү 77.4 сая төгрөг болж Ажлын хэсгийн 2 дахь хуралдаанд танилцуулсан. Шийдэгдээгүй зөрүүний ихэнх нь Төр, засгийн байгууллагуудад үзүүлсэн хандив, дэмжлэг, байгаль хамгаалах арга хэмжээнд зарцуулсан зардал байна.

Бүлэг	Анхны нэгтгэлийн зөрүүнүүд	Тохируулга		Тохируулгын дараах шийдэгдээгүй цэвэр зөрүүнүүд
		Засгийн газрын байгууллагууд	Компаниуд	
	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
5.1 Татварууд	691,916	300,648,022	300,648,022	-
5.2 Төлбөрүүд	22,627	138,267,911	138,271,101	(3,190)
5.3 Хураамжууд, үйлчилгээний шимтгэлүүд	406,294	11,244,645	11,246,785	(2,141)
5.4 Төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашиг	(95,181,745)	104,095,313	104,095,313	-
5.5 Хүлээн авагч Засгийн газрын байгууллагуудад төлсөн бусад төлбөрүүд	(171,024,055)	169,528,159	169,528,159	-
5.6 Засгийн газрын байгууллагуудад өгсөн хандивууд	(1,764,058)	6,789,532	6,829,346	(39,814)
5.7 Байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардал	1,341,284	6,938,178	6,970,478	(32,301)
Нийт	(265,507,738)	737,511,760	737,589,205	(77,445)

5.5 Бүх тохируулга хийгдсэний дараах санхүүгийн нийт урсгал

Ажлын хэсгийн 2011 оны 6 дугаар сарын 2-ний өдрийн хуралдаанаас хойш 6 дугаар сарын 8-ний өдрийг хүртэлх хугацаанд компаниудаас үзүүлсэн хандив, дэмжлэгийг хүлээн авсан тухайгаа хариу ирүүлээгүй хөдөө орон нутгийн ЗДТГ-ын холбогдох мэргэжилтнүүдтэй харилцаж, хандив, дэмжлэгийн талаар зохих мэдээллийг авах, мөн шийдэгдээгүй үлдсэн зарим төлбөрийн анхан шатны баримтыг компаниас авах, УТЕГ-т компаниудаас ирүүлсэн мэдээллийг дамжуулж, зөрүүний шалтгааныг тодруулах зэргээр зөрүүг шийдвэрлэх бүхий л арга хэмжээг авч ажилласны үр дүнд шийдэгдээгүй зөрүү эцсийн байдлаар 58.2 сая төгрөг болсон.

(мянган төгрөгөөр)

Бүх компаниуд								
Компаниас улсын болон орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөр	Анхны нэгтгэл		Анхны нэгтгэлийн зөрүү*	Тохируулга		Тохируулгын дараа		Тохируулгын дараах шийдэгдэ эгүй зөрүү
	ЗГ-ын байгууллагын дүн /УТОХГ/	Компанийн дүн		ЗГ	Компани	ЗГ	Компани	
Төлсөн татварууд	299,868,830	299,176,914	691,916	779,192	1,471,108	300,648,022	300,648,022	-
Төлбөр	137,864,995	137,842,368	22,627	403,004	427,611	138,267,999	138,269,979	(1,980)
Хураамж, үйлчилгээний хөлс	10,015,277	9,608,983	406,294	1,229,368	1,637,783	11,244,645	11,246,766	(2,121)
Төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашиг	9,035,833	104,217,578	(95,181,745)	95,059,481	(122,264)	104,095,313	104,095,313	-
Хүлээн авагч Засгийн газарт төлсөн бусад төлбөрүүд	-	171,024,055	(171,024,055)	169,528,159	(1,495,896)	169,528,159	169,528,159	-
Төрийн байгууллагад үзүүлсэн дэмжлэг	3,852,268	5,616,326	(1,764,058)	2,950,319	1,208,020	6,802,587	6,824,346	(21,759)
Байгаль хамгаалах арга хэмжээнд зарцуулсан зардал	7,577,228	6,235,945	1,341,284	(639,051)	734,534	6,938,178	6,970,478	(32,301)
Нийт дүн	468,214,430	733,722,168	(265,507,738)	269,310,472	3,860,895	737,524,903	737,583,063	(58,161)

6. ШИЙДЭГДЭЭГҮЙ ЗӨРҮҮНҮҮД

6.1 Бүх тохируулга хийгдсэний дараа шийдэгдээгүй үлдсэн нийт зөрүүнүүд

Дүнгүүдийг нэгтгэж, хоёр талаас ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээлэлд үндэслэн холбогдох залруулгыг хийсний дараа тодорхой тооны зөрүүнүүд нь шийдэгдээгүй үлдсэн ба үүнийг санхүүгийн урсгалаар нь илүү дэлгэрэнгүй энэхүү бүлэгт тайлбарласан болно.

Засгийн газрын байгууллагууд болон компаниудын анхны зөрүүнүүдийн хураангуй, нэгтгэлийн үр дүнд хийсэн залруулгууд болон шийдэгдээгүй үлдсэн зөрүүнүүдийг дараахи байдлаар харуулав. Үүнд:

Бүлэг	Анхны нэгтгэлийн цэвэр зөрүүнүүд	Тохируулсан байдал		Шийдэгдээгүй үлдсэн цэвэр зөрүүнүүд
		Засгийн газрын байгууллагууд	Компаниуд	
		мян.төг	мян.төг	
5.1 Татварууд	691,916	300,648,022	300,648,022	-
5.2 Төлбөрүүд	22,627	138,267,999	138,269,979	(1,980)
5.3 Хураамжууд, үйлчилгээний шимтгэлүүд	406,294	11,244,645	11,246,766	(2,121)
5.4 Төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашиг	(95,181,745)	104,095,313	104,095,313	-
5.5 Хүлээн авагч Засгийн газрын байгууллагуудад төлсөн бусад төлбөрүүд	(171,024,055)	169,528,159	169,528,159	-

5.6	Засгийн газрын байгууллагуудад өгсөн хандивууд	(1,764,058)	6,802,587	6,824,346	(21,759)
5.7	Байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардал	1,341,284	6,938,178	6,970,478	(32,301)
	Нийт дүн	(265,507,738)	737,524,903	737,583,063	(58,161)

Доорх хүснэгт нь оролцогч талуудын дүнгүүдийг харьцуулснаар төлсөн болон хүлээн авсан дүнгийн цэвэр зөрүүг задлан харуулав.

	мян.төг	
Компаниудын төлсөн дүн ЗГ-ийн хүлээн авсан дүнгээс их	(267,969,859)	(58,161)
ЗГ-ын хүлээн авсан дүн компаниудын төлсөн дүнгээс их	2,462,121	-

Шийдэгдээгүй 58,161 мянган төгрөгийн зөрүүг компани тус бүрээр задлан харуулбал дараах бүтэцтэй байна.

Компаниуд	Шийдэгдээгүй үлдсэн зөрүүнүүд мян.төг
<i>Компаниудын төлсөн дүн ЗГ-ийн хүлээн авсан дүнгээс их</i>	
"Арева Монгол" ХХК	(18,901)
"Поло ресорсиз" ХХК	(7,750)
"Бэрэн групп" ХХК	(6,400)
"Шинь шинь" ХХК	(3,813)
"Хангад эксплорэйшн" ХХК	(3,401)
"АФК тавт" ХХК	(3,299)
"Олон овоот гоулд" ХХК	(3,000)
"Монголын алт корпораци" ХХК	(2,520)
"Саусгоби сэндс" ХХК	(2,103)
"Гоби коул энд энерги" ХХК	(2,000)
"Адамас майнинг" ХХК	(1,900)
"Ноён гарн" ХХК	(1,750)
"Адил оч" ХХК	(1,250)
"Тунсинь" ХХК	(850)
"Алтайн хүдэр" ХХК	(800)
"Их монгол майнинг" ХХК	(725)
"Дацан трейд" ХХК	(300)
"Тефис майнинг" ХХК	(200)
"Эрдэс холдинг" ХХК	(17)
Бүгд	(60,979)
<i>ЗГ-ын хүлээн авсан дүн компаниудын төлсөн дүнгээс их</i>	
"Доншен" ХХК	670
"Алтай гоулд" ХХК	2,148
Бүгд	2,818

6.2 Төлбөрүүд

Төлбөрүүдийн хувьд шийдэгдээгүй зөрүү нь гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөрөөс үүссэн. Төлбөрийн зөрүүг компаниудаар дараахи хүснэгтээр үзүүлэв. Үүнд:

Компаниуд	Шийдэгдээгүй үлдсэн зөрүүнүүд мян.төг
<i>Компаниудын төлсөн дүн ЗГ-ийн хүлээн авсан дүнгээс их</i>	
"АФК тавт" ХХК	(3,299)
Бүгд	(3,299)
<i>ЗГ-ын хүлээн авсан дүн компаниудын төлсөн дүнгээс их</i>	
"Доншен газрын тос" ХХК	670
"Алтай голд" ХХК	648
Бүгд	1,318

Зөрүү үүссэн шалтгаан: Компаниуд нь мэдээллээ дэлгэрэнгүй задаргаагаар бус бөөн дүнгээр ирүүлсэн.

Шийдээгүй шалтгаан: Компаниуд нь мэдээллээ дэлгэрэнгүй задаргаагаар өгөхгүй байгаагийн улмаас ХХҮГ-аас ирүүлсэн мэдээлэлтэй тулгаж, зөрүүгийн шалтгааныг тодорхойлох боломжгүй болсон.

6.3 Хураамж, үйлчилгээний шимтгэлүүд

Хураамжийн хувьд шийдэгдээгүй зөрүү нь зохих хууль тогтоомжийн дагуу төв, орон нутгийн төрийн захиргааны байгууллагад төлсөн үйлчилгээний хөлс (төлбөр)-өөс үүссэн.

Зөрүүг компаниудаар дараахи хүснэгтээр үзүүлэв. Үүнд:

Компаниуд	Шийдэгдээгүй үлдсэн зөрүүнүүд мян.төг
<i>Компаниудын төлсөн дүн ЗГ-ийн хүлээн авсан дүнгээс их</i>	
"Саусгоби сэндс" ХХК	(2,103)
"Эрдэс холдинг" ХХК	(17)
Бүгд	(2,120)
<i>ЗГ-ын хүлээн авсан дүн компаниудын төлсөн дүнгээс их</i>	
Бүгд	-

Зөрүү үүссэн шалтгаан: Компаниуд Төр, засгийн байгууллагад төлсөн хураамж үйлчилгээний хөлсийг нэгбүрчилэн тусгаж ирүүлдэг, харин Төр, засгийн байгууллагууд хүлээн авсан дүнгээ ОУИТБС-ын тайланд тусгадаггүй байна.

Шийдээгүй шалтгаан:

- Төлөгдсөн байгууллага нь хэтэрхий олон тэр бүр байгууллагуудад хандахад бэрхшээлтэй
- Нэг удаагийн төлсөн дүн нь маш бага, материаллаг түвшинг энэ удаад ажлын даалгаварт заагаагүйгээс шалтгаалаад холбогдох залруулгыг хийх боломжгүй болсон.

6.4 Төр, засгийн байгууллагуудад үзүүлсэн мөнгөн дэмжлэг

Хандив, дэмжлэгийн зөрүүг компаниудаар дараахи хүснэгтээр үзүүлэв. Үүнд:

Компаниуд	Шийдэгдээгүй үлдсэн зөрүүнүүд мян.төг
<i>Компаниудын төлсөн дүн ЗГ-ийн хүлээн авсан дүнгээс их</i>	
"Бэрэн групп" ХХК	(6,200)
"Шинь шинь" ХХК	(3,813)
"Олон овоот гоулд" ХХК	(3,000)
"Монголын алт корпораиц" ХХК	(2,520)
"Гоби коул энд энерги" ХХК	(2,000)
"Ноён гарри" ХХК	(1,750)
"Тунсинь" ХХК	(850)
"Адамас майнинг" ХХК	(700)
"Хангад эксплорэйшн" ХХК	(626)
"Дацан трейд" ХХК	(300)
Бүгд	(21,759)
<i>ЗГ-ын хүлээн авсан дүн компаниудын төлсөн дүнгээс их</i>	
Бүгд	-

Зөрүү үүссэн шалтгаан: Компаниудаас Төр, засгийн байгууллагад үзүүлсэн хандив, дэмжлэгийн дүнг хүлээн авсан яам, агентлаг болон төсвийн байгууллагууд ОУИТБС-ын тайланд тусгадаггүй байна.

Шийдээгүй шалтгаан:

- АМГ, Эх нялхсын эрдэм шинжилгээний үндэсний төв, Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын ЗДТГ зэрэг байгууллагаас хандив, дэмжлэгийг хүлээн авсан тухайгаа хариу ирүүлээгүй.
- Хэнтий аймгийн Бор-өндөр, Увс аймгийн Тариалан сумын ЗДТГ нь компаниас ирүүлсэн дүнгээс зөрүүтэй дүнгээр хариу ирүүлсэн.
- Говь-Алтай аймгийн Цээл, Дорнод аймгийн Дашбалбар, Өмнөговь аймгийн Ханхонгор зэрэг сумдын ЗДТГ-аас хандив, дэмжлэгийг хүлээн аваагүй гэсэн хариу ирүүлсэн.
- Харин хандив, дэмжлэг үзүүлсэн компаниудаас анхан шатны баримтаа хувилж ирүүлсэн.
- Компанийн зүгээс хандив, дэмжлэг өгсөн, хүлээн авагч байгууллага нь аваагүй гэсэн хариу ирүүлээд байгаа учраас аль талын баримтанд үндэслэн зөрүүг шийдвэрлэх нь тодорхой бус болоод байна.

6.5 Байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардал

Байгаль хамгаалах арга хэмжээнд зарцуулсан зардлын зөрүүг компаниудаар дараахи хүснэгтээр үзүүлэв. Үүнд:

Компаниуд	Шийдэгдээгүй үлдсэн зөрүүнүүд мян.төг
<i>Компаниудын төлсөн дүн ЗГ-ийн хүлээн авсан дүнгээс их</i>	
"Арева Монгол" ХХК	(18,901)
"Поло ресорсиз" ХХК	(7,750)
"Хангад эксплорэйшн" ХХК	(2,775)
"Адил оч" ХХК	(1,250)
"Адамас Майнинг" ХХК	(1,200)
"Алтайн хүдэр" ХХК	(800)

"Их Монгол майнинг" ХХК	(725)
"Бэрэн групп" ХХК	(200)
"Тэфис майнинг" ХХК	(200)
Бүгд	(33,801)
<i>ЗГ-ын хүлээн авсан дүн компаниудын төлсөн дүнгээс их</i>	
"Алтай голд" ХХК	1,500
Бүгд	1,500

Байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд төвлөрүүлсэн байдал

Байгаль хамгаалах зардлын 50 хувийн 31,751 мянган төгрөгийн шийдвэрлэгдээгүй зөрүү нь "Адамас майнинг", "Арева монгол", "Бэрэн групп", "Их монгол майнинг", "Поло ресорсез", "Тэфис майнинг", "Хангад эксплорэйшн" зэрэг компаниуд дээр үүссэн.

Зөрүү үүссэн шалтгаан: Компаниудаас "Х" лицензтэй холбоотой байгаль орчныг нөхөн сэргээх зардлын 50 хувийг хайгуул хийж буй сумдын ЗДТГ-ын тусгай дансанд байршуулдаг боловч, уг дүн нь ОУИТБС-ын тайлангийн нэгтгэлд хамрагдахгүй байна.

Шийдээгүй шалтгаан: Компаниудаас ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээллийн дагуу холбогдох сумдын ЗДТГ-т албан бичгээр хандсан боловч хариу өгөөгүй, мөн зарим нь хүлээн аваагүй гэсэн хариу өгсөн. Компаниуд руу дахин дахин хандаж анхан шатны баримтыг авсан. Харин аймаг, сумд нь алслагдсан, төвлөрүүлж байгаа дүн нь бага (100 мянган төгрөгөөс доош) цаг хугацаа ихээхэн шаардагдаж байгаа учраас энэхүү зөрүүнүүдийг шийдвэрлэх боломжгүйд хүрлээ.

Байгаль хамгаалах арга хэмжээнд зарцуулсан зардал

Байгаль хамгаалах арга хэмжээнд зарцуулсан зардлын 550 мянган төгрөгийн шийдвэрлэгдээгүй зөрүү нь "Адил Оч", "Алтай гоулд", "Алтайн хүдэр" зэрэг компаниуд дээр үүссэн.

Зөрүү үүссэн шалтгаан: Компаниудын геологичид нь БОАЖЯ-нд тайлангаа гаргаж өгөөгүй, мөн өгсөн ч нөхөн сэргээх арга хэмжээний зардлын дүнг тусгаагүйгээс шалтгаалсан байна.

Шийдээгүй шалтгаан: Засгийн газар талаас компанийн дүн баталгаажуулахгүй, компани нь геологичийн тайлангаа ирүүлээгүй зэргээс шалтгаалаад нэг талын дүнд үндэслэн залруулах боломжгүйд хүрсэн.

6.6 Төр, засгийн байгууллагуудад үзүүлсэн хандив, дэмжлэг

Компаниудын зүгээс яам, агентлагт 297.2 сая төгрөгийн хандив тусламж өгсөн, яам агентлагууд 64.1 сая төгрөгийн хандив тусламж хүлээн авсан гэж тайлагнасан ба анхны зөрүү нь 233.1 сая төгрөг болсон. Төр, засгийн байгууллагуудаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн 267.6 сая төгрөгийн залруулга хийсний дараа 11.7 сая төгрөгийн хандив шийдэгдээгүй үлдэж байна.

Д/Д	Хандив авсан байгууллагуудын нэр	Залруулагдсан байдал		Шийдээгүй үлдсэн зөрүү	Хандив үзүүлсэн компанийн нэр	Тайлбар
		ЗГ	Компани			
1	Эрдэс баялаг, эрчим хүчний яам	45,699	45,699	-	Дацан трейд, Монголросцветмет, Петрочайна дачин тамсаг, Цайрт минерал, Чинхуа Мак нарийн сухайт, Шинь Шинь, Эрдэнэт үйлдвэр-7 компани	3 дугаар сарын 29-нд албан бичиг хүргүүлсэн. Тус яамны Уул уурхай, хүнд үйлдвэрийн бодлогын газрын даргатай 4 сарын 14-нд уулзсанаар холбогдох мэдээллийг 4 дүгээр сарын 15-нд ирүүлсэн.
2	Нийгэм хамгаалал хөдөлмөрийн яам	29,066	29,066	-	Петро чайна дачин тамсаг-1 компани	2011.04.25-ний өдрийн 3/912 тоот албан бичгээр хандив, дэмжлэг аваагүй гэсэн хариу өгсөн ба 2009.07.27-ний өдрийн Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсээс тус компанид гаргаж өгсөн тодорхойлолтод үндэслэн залруулсан.

(мянган төгрөгөөр)

Д/д	Хандив авсан байгууллагуудын нэр	Залруулагдсан байдал		Шийдээг үйлдсэн зөрүү	Хандив үзүүлсэн компанийн нэр	Тайлбар
		ЗГ	Компани			
3	БНХАУ-д суугаа Монгол улсын элчин сайдын яам	12,668	12,668	-	Монголын алт корпораци, Эрдэнэт үйлдвэр-2 компани	3 дугаар сарын 17-нд албан бичгийг мэйл хаягаар анх явуулсан. Үүнээс хойш албан бичгийгудаа дараа мэйлээр явуулсан боловч хариу өгөөгүй. Менежертэй утсаар холбогдож шаардсанаар 5 сарын 5-нд хариу мэдээлэл өгсөн.
4	ОХУ-д суугаа Монгол улсын элчин сайдын яам	5,888	5,888	-	Монголросцветмет, Эрдэнэт үйлдвэр-2 компани	
5	ЦЕГазар	3,000	3,000	-	Монголын алт корпораци-1 компани	3 дугаар сарын 29-нд албан бичиг хүргүүлж олон удаа утсаар шаардсаны эцэст 5 сарын 5-нд хариу мэдээлэл ирүүлсэн.
6	Үндэсний статистикийн газар	5,000	5,000	-	Эрдэнэт үйлдвэр-1 компани	3 дугаар сарын 17-нд албан бичиг хүргүүлж, хариу мэдээллийн 4 сарын 15-нд авсан.
7	Стандартчилал хэмжил зүйн газар	1,000	1,000	-	Бороо гоулд, Шинь шинь-2 компани	3 дугаар сарын 29-нд албан бичиг хүргүүлж, хариу мэдээллийн 4 сарын 05-нд авсан.
8	Ашигт малтмалын газар	61,736	71,436	(9,700)	Баян эрч, Болд төмөр ерөө гол, Бороо гоулд, Бэрэн групп, Дацан трейд, Доншен газрын тос, МОНЭНКО, Монполимет, Олон овоот гоулд, Өрмөн уул, Таван толгой, Тунсинь, Шанлун, Шинь Шинь, Эрдэнэ монгол-15 компани	Бэрэн групп ХХК-иас 6,700 мянган төгрөг, Олон овоот гоулд ХХК-иас 3,000 мянган төгрөг, нийт 9,700 мянган төгрөгийн хандив, дэмжлэгийг компани өгсөн гэж анхан шатны баримтаа ирүүлсэн. Харин АМГ нь 2011.05.25-ний өдрийн 3-2883 тоот албан бичгийн хавсралт тайлбарт "Танай ирүүлсэн хавсралт-2-д дурьдсан компаниудаас Дацан трейд ХХК-иас бусад хандив, дэмжлэгтэй холбоотой мэдээлэл байхгүй байна" гэж ирүүлсэн.
9	Газрын тосны газар	3,000	3,000	-	Доншен газрын тос-1 компани	
10	Гадаадын иргэн харьяатын асуудал эрхлэх газар	46,720	46,720	-	Айвенхоу майнз монголия инк, Бороо гоулд, Доншен газрын тос, Петро чайна дачин тамсаг, Чинхуа Мак нарийн сухайт, Шинь Шинь, Эрдэнэт үйлдвэр-7 компани	3 дугаар сарын 29-нд албан бичиг хүргүүлсэн. Хариуг 4 дүгээр сарын 01-нд ирүүлсэн. Санаачлагатай сайн ажилласан.
11	Хил хамгаалах ерөнхий газар	33,498	33,498	-	Монголын алт корпораци, Петро чайна дачин тамсаг, Эрдэнэт үйлдвэр-3 компани	Хариу ирүүлэхгүй олон удаа шаардуулсан. Тус газар дээр 2-3 удаа очиж уулзсанаар 5 сарын 17-нд хариу мэдээлэл гаргаж өгсөн.
12	Төсвийн байгууллага	103,680	105,680	(2,000)	Бэрэн групп, Гоби коул энд энерги, Доншен газрын тос, Кожеговь, Монголын алт корпораци, Поло ресорсез, ХОТУ, Хурай-8 компани	СБД-ийн эргүүлийн цагдаагийн газар, ЭНЭШТөвийн ерөнхий мэс заслын тасаг, Монгол улсын хүүхэд асран хүмүүжүүлэх төв, Хүүхдийн ордон зэрэг байгууллагуудаас хариу мэдээлэл ирсэн. ЭНЭШТөвийн зурхний тасгийн эмч нь өөрчлөгдсөн учраас хариу өгөх албан тушаалтан олдоогүй.
	Дүн	350,955	362,655	(11,700)		

Төрийн байгууллагууд нь хандив, тусламжийн дүнг тодруулах тухай албан бичгийн хариу өгөх ажилд хангалтгүй, хойрго хандаж байсан нь дээрхи хүснэгтэн мэдээллийн тайлбар хэсгээс харагдах болов уу.

6.7 Компаниудаас үзүүлсэн нийт хандив, дэмжлэг

(мянган төгрөгөөр)

Д/д	Хандив авсан байгууллагуудын нэр	Залруулагдсан байдал		Шийдээг үйлдсэн зөрүү	Хандив үзүүлсэн компанийн нэр	Тайлбар
		ЗГ	Компани			
1	Эрдэс баялаг, эрчим хүчний яам	45,699	45,699	-	Дацан трейд, Монголросцветмет, Петро чайна дачин тамсаг, Цайрт минерал, Чинхуа Мак нарийн сухайт, Шинь Шинь, Эрдэнэт үйлдвэр-7 компани	3 дугаар сарын 29-нд албан бичиг хүргүүлсэн. Тус яамны Уул уурхай, хүнд үйлдвэрийн бодлогын газрын даргатай 4 сарын 14-нд уулзсанаар холбогдох мэдээллийг 4 дүгээр сарын 15-нд ирүүлсэн.
2	Нийгэм хамгаалал хөдөлмөрийн яам	29,066	29,066	-	Петро чайна дачин тамсаг-1 компани	2011.04.25-ний өдрийн 3/912 тоот албан бичгээр хандив, дэмжлэг аваагүй гэсэн хариу өгсөн ба 2009.07.27-ний өдрийн Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсээс тус компанид гаргаж өгсөн тодорхойлолтод үндэслэн залруулсан.

(мянган төгрөгөөр)

д/д	Хандив авсан байгууллагуудын нэр	Залруулагдсан байдал		Шийдээ гүй үлдсэн зөрүү	Хандив үзүүлсэн компанийн нэр	Тайлбар
		ЗГ	Компани			
3	БНХАУ-д суугаа Монгол улсын элчин сайдын яам	12,668	12,668	-	Монголын алт корпораци, Эрдэнэт үйлдвэр-2 компани	3 дугаар сарын 17-нд албан бичгийг мэйл хаягаар анх явуулсан. Үүнээс хойш албан бичгийгудаа дараа мэйлээр явуулсан боловч хариу өгөөгүй.
4	ОХУ-д суугаа Монгол улсын элчин сайдын яам	5,888	5,888	-	Монголросцветмет, Эрдэнэт үйлдвэр-2 компани	Менежертэй утсаар холбогдож шаардсанаар 5 сарын 5-нд хариу мэдээлэл өгсөн.
5	ЦЕГГазар	3,000	3,000	-	Монголын алт корпораци-1 компани	3 дугаар сарын 29-нд албан бичиг хүргүүлж олон удаа утсаар шаардсаны эцэст 5 сарын 5-нд хариу мэдээлэл ирүүлсэн.
6	Үндэсний статистикийн газар	5,000	5,000	-	Эрдэнэт үйлдвэр-1 компани	3 дугаар сарын 17-нд албан бичиг хүргүүлж, хариу мэдээллийн 4 сарын 15-нд авсан.
7	Стандартчилал хэмжил зүйн газар	1,000	1,000	-	Бороо гоулд, Шинь шинь-2 компани	3 дугаар сарын 29-нд албан бичиг хүргүүлж, хариу мэдээллийн 4 сарын 05-нд авсан.
8	Ашигт малтмалын газар	61,736	71,436	(9,700)	Баян эрч, Болд төмөр ерөө гол, Бороо гоулд, Бэрэн групп, Дацан трейд, Доншен газрын тос, МОНЭНКО, Монполимет, Олон овоот гоулд, Өрмөн уул, Таван толгой, Тунсинь, Шанлун, Шинь Шинь, Эрдэнэ монгол-15 компани	Бэрэн групп ХХК-иас 6,700 мянган төгрөг, Олон овоот гоулд ХХК-иас 3,000 мянган төгрөг, нийт 9,700 мянган төгрөгийн хандив, дэмжлэгийг компани өгсөн гэж анхан шатны баримтаа ирүүлсэн. Харин АМГ нь 2011.05.25-ний өдрийн 3-2883 тоот албан бичгийн хавсралт тайлбарт "Танай ирүүлсэн хавсралт-2-д дурьдсан компаниудаас Дацан трейд ХХК-иас бусад хандив, дэмжлэгтэй холбоотой мэдээлэл байхгүй байна" гэж ирүүлсэн.
9	Газрын тосны газар	3,000	3,000	-	Доншен газрын тос-1 компани	
10	Гадаадын иргэн харьяатын асуудал эрхлэх газар	46,720	46,720	-	Айвенхоу майнз монголия инк, Бороо гоулд, Доншен газрын тос, Петро чайна дачин тамсаг, Чинхуа Мак нарийн сухайт, Шинь Шинь, Эрдэнэт үйлдвэр-7 компани	3 дугаар сарын 29-нд албан бичиг хүргүүлсэн. Хариуг 4 дүгээр сарын 01-нд ирүүлсэн. Санаачлагатай сайн ажилласан.
11	Хил хамгаалах ерөнхий газар	33,498	33,498	-	Монголын алт корпораци, Петро чайна дачин тамсаг, Эрдэнэт үйлдвэр-3 компани	Хариу ирүүлэхгүй олон удаа шаардуулсан. Тус газар дээр 2-3 удаа очиж уулзсанаар 5 сарын 17-нд хариу мэдээлэл гаргаж өгсөн.
12	Төсвийн байгууллага	103,680	105,680	(2,000)	Бэрэн групп, Гоби коул энд энерги, Доншен газрын тос, Кожеговь, Монголын алт корпораци, Поло ресорсез, ХОТУ, Хурай-8 компани	СБД-ийн эргүүлийн цагдаагийн газар, ЭНЭШТөвийн ерөнхий мэс заслын тасаг, Монгол улсын хүүхэд асран хүмүүжүүлэх төв, Хүүхдийн ордон зэрэг байгууллагуудаас хариу мэдээлэл ирсэн. ЭНЭШТөвийн зүрхний тасгийн эмч нь өөрчлөгдсөн учраас хариу өгөх албан тушаалтан олдоогүй.
	Төр, засгийн байгууллагын дүн	350,955	362,655	(11,700)		
1	Архангай	6,555	6,555	-	Алтай гоулд, Бэрэн-2 компани	3 дугаар сарын 28-нд албан бичиг илгээж, 4 сарын 15-нд хариу мэдээлэл авсан. Цэнхэр сумын ЗДТГ-аас 6 сарын 8-нд хариу ирсэн.
2	Баян-Өлгий		200	(200)	Адамас майнинг-1 компани	3 дугаар сарын 28-нд албан бичиг илгээж 4 сарын 11-нд хариу мэдээлэл авсан. Ногооннуур сумын ЗДТГ-аас хариу ирээгүй.
3	Баянхонгор	153,267	153,267	-	Гоби коул энд энерги, Жи энд юу голд, Эрдэнэ монгол, Хан шижир, Монголросцветмет-5 компани	3 дугаар сарын 28-нд албан бичиг илгээж, хариу мэдээлэл 4 дүгээр сарын 15-нд авсан.
4	Булган	14,926	14,926	-	Өрмөн уул, Поло ресорсез-2 компани	3 дугаар сарын 28-нд албан бичиг илгээж, хариу мэдээлэл 4 дүгээр сарын 11-нд авсан.
5	Говь-Алтай	53,935	56,455	(2,520)	Гоби коул энд энерги, Монголын алт корпораци, Эрдэнэ монгол-3 компани	3 дугаар сарын 28-нд албан бичиг илгээж, хариу мэдээлэл 4 дүгээр сарын 06-нд авсан.
6	Говьсүмбэр	6,750	6,750	-	Шивээ-Овоо-1 компани	3 дугаар сарын 28-нд албан бичиг илгээж, хариу мэдээлэл 4 дүгээр сарын 14-нд авсан.

(мянган төгрөгөөр)

д/д	Хандив авсан байгууллагуудын нэр	Залруулагдсан байдал		Шийдээ гүй үлдсэн зөрүү	Хандив үзүүлсэн компанийн нэр	Тайлбар
		ЗГ	Компани			
7	Дархан-Уул	48,258	48,258	-	Гуравт, Бороо гоулд, Зүб гол, Зүрийн булан, Шарын гол-5 компани	3 дугаар сарын 28-нд албан бичиг илгээж, хариу мэдээл 4 дүгээр сарын 13-нд авсан.
8	Дорноговь	157,145	157,145	-	Айвенхоу майнз монголия инк, Баялаг жонш, Доншен газрын тос, Кожеговь, Коммод, Монголын алт корпораци, Цайрт минерал-7 компани	3 дугаар сарын 28-нд албан бичиг илгээж, хариу мэдээл 4 дүгээр сарын 13-нд авсан.
9	Дорнод	75,489	79,302	(3,813)	Адамас майнинг, Адуунчулуун, Дун-Эрдэнэ, Жамп, Монголын алт корпораци, Петрожайна дачин тамсаг, Шанлун, Шинь шинь, Эмээлт майнз-9 компани	3 дугаар сарын 28-нд албан бичиг илгээж, хариу мэдээл 4 дүгээр сарын 14-нд авсан.
10	Дундговь	1,500	1,500	-	Адил-Оч-1 компани	3 дугаар сарын 28-нд албан бичиг илгээж, хариу мэдээл 4 дүгээр сарын 14-нд авсан. Өлзийт сумын ЗДТГ-аас 6 сарын 8-нд хариу ирсэн.
11	Завхан	3,000	3,000	-	Баян айраг эксплорэшн-1 компани	3 дугаар сарын 28-нд албан бичиг илгээж, хариу мэдээл 4 дүгээр сарын 05-нд авсан.
12	Орхон	851,368	851,368	-	Эрдэнэт үйлдвэр-1 компани	3 дугаар сарын 28-нд албан бичиг илгээж, хариу мэдээл 4 дүгээр сарын 12-нд авсан.
13	Өвөрхангай	22,863	22,863	-	АУМ, Поло ресорсез-2 компани	3 дугаар сарын 28-нд албан бичиг илгээж, хариу мэдээл 4 дүгээр сарын 08-нд авсан.
14	Өмнөговь	3,263,748	3,264,374	(626)	Айвенхоу майнз монголия инк, Брейвхарт, Их монгол майнинг, Монголын алт корпораци, Олон овоот гоулд, Поло ресорсез, Саусоби сэндс, Таван толгой, Хангад эксплорэйшн, Чинхуа Мак нарийн сухайт, Энержи ресурс-11 компани	3 дугаар сарын 28-нд албан бичиг илгээж, хариу мэдээл 4 дүгээр сарын 15-нд авсан. Баян-Овоо, Мандал-Овоо зэрэг сумдын ЗДТГ-аас 6 сарын 8-нд хариу ирсэн. Ханхонгор сумын эмнэлэг хандив, дэмжлэг аваагүй гэсэн хариу ирүүлсэн.
15	Сүхбаатар	146,083	146,083	-	Баян эрч, Кожеговь, Поло ресорсез, Сентерра гоулд, Цайрт минерал, Эрвэн хүдэр-6 компани	3 дугаар сарын 28-нд албан бичиг илгээж, хариу мэдээл 4 дүгээр сарын 11-нд авсан.
16	Сэлэнгэ	1,533,901	1,533,901	-	Бороо гоулд, Болд төмөр ерөө гол, Гацуурт, Монголын алт корпораци, Сентерра голуд, Хурай, Флинк монголия, Шижир талст, Эрдэнэт үйлдвэр, Эрдэс холдинг-10 компани	3 дугаар сарын 28-нд албан бичиг илгээж, хариу мэдээл 4 дүгээр сарын 15-нд авсан.
17	Төв	83,078	84,828	(1,750)	Адамас майнинг, Анхай интернэйшнл, Бороо гоулд, Брейвхарт, Заамарын их алт, Монголросцветмет, Ноён гари, Өрмөн уул, ХОТУ-9 компани	3 дугаар сарын 28-нд албан бичиг илгээж, хариу мэдээл 4 дүгээр сарын 14-нд авсан. Ноён гари компани дэлгэрэнгүй мэдээлэл өгөөгүй учраас хаана хандаж хариу мэдээлэл авах нь тодорхойлогдоогүй.
18	Увс	5,163	5,463	(300)	Дацан трейд, Монголросцветмет, Поло ресорсез-3 компани	3 дугаар сарын 28-нд албан бичиг илгээж, хариу мэдээл 4 дүгээр сарын 11-нд авсан. Тариалан сумын ЗДТГ-аас дутуу ирсэн.
19	Ховд	2,100	2,100	-	МОНЭНКО-1 компани	3 дугаар сарын 28-нд албан бичиг илгээж, хариу мэдээл 4 дүгээр сарын 07-нд авсан.
20	Хэнтий	29,623	30,473	(850)	Адамас майнинг, Баялаг жонш, Дацан трейд, Их монгол майнинг, Нордвинд, Тунсинь, Эрдэнэт үйлдвэр-7 компани	3 дугаар сарын 28-нд албан бичиг илгээж, хариу мэдээл 4 дүгээр сарын 06-нд авсан. Бор-Өндөр сумын ЗДТГ-аас авсан хандивын дүнг баталгаажуулж, компанийн дүнгээс дутуу ирсэн.
	Аймгуудын дүн	6,458,752	6,468,811	(10,059)		
	Нийт дүн	6,809,707	6,831,466	(21,759)		

6.8 Хандив, тусламжийг бүртгэх тухай Сангийн сайдын журмын хэрэгжилт

Төр, засгийн байгууллагад үзүүлсэн хандив, тусламж 1.8 тэрбум төгрөгийн анхны зөрүү үүссэн байгаагаас харахад уг журмын хэрэгжилт муу байна гэсэн дүгнэлтэд хүргэж байна. Гэхдээ ОУИТБС-ын тайланг 2 дугаар сарын 15-ний дотор ЗГ-ын нэгж (сум, дүүрэг, аймаг нийслэлийн ЗДТГ) байгууллагууд болон компаниуд гаргаж, ҮТЕГ 3 сарын 15-ний дотор нэгтгэн СЯ-нд хүргүүлдэг учраас уг журам нь тухайн оны тайлагналын хугацаанаас хойш буюу 2010 оны 3 сарын 1-нд батлагдсан тул 2009 оны нэгтгэл тайланд хамруулж ойлгох нь тохиромжгүй байна.

Компаниуд анхны тайландаа тусгаж өгсөн хандив, тусламжийн дүнг нэгтгэлийн явцад гаргаж ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээллээр 1.8 тэрбум төгрөгөөр нэмж тусгаж өгсөн ба үүнээс төрийн байгууллагад үзүүлсэн хандив, тусламж биш, төрийн бус байгууллага, эвсэл, холбоо, хөдөлгөөн, оюутан сурагчдын сургалтын төлбөр, тэмцээн наадам ивээн тэтгэсэн санхүүжилт, хувь хүнд олгосон эмчилгээний зардал зэрэгт зарцуулсан 648.5 (хавсралт Т-ээс үзнэ үү) сая төгрөгийг залруулгын дүнгээс хасч 1.2 тэрбум төгрөгийн хандив, дэмжлэгийг анхны нэгтгэлийн дүн дээр нэмж тохируулгыг хийсэн.

Төрийн (дээр дурьдсан) байгууллагууд анхны тайландаа 3.8 тэрбум төгрөгийн хандивыг тусгасан ба нэгтгэл тайлангийн явцад компаниас үзүүлсэн хандив, тусламжийн дүнг тулган тодруулах зорилгоор холбогдох байгууллагуудад албан бичиг хүргүүлж, хариуг авч ажилласны үр дүнд 3.0 тэрбум төгрөгийн хандив, дэмжлэгийн дүн тохируулагдсан байна.

Компаниудын анхны тайлангаар 5.6 тэрбум төгрөгийн хандив, тусламж тусгагдсан ба нэгтгэлийн явцад 1,2 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 6,8 тэрбум төгрөгийн хандив, дэмжлэгийн дүнг холбогдох байгууллагуудаас тодруулж, зөрүүг шийдвэрлэсэн байна. Хандив, дэмжлэгийн дэлгэрэнгүйг (Хавсралт Р,С)-д харуулав.

6.9 Оролцоо

Монгол улсын Сангийн сайдын 2010 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн 45 тоот тушаалаар батлагдсан "Хандив, тусламжийг бүртгэх журам"-ын 2.2, 2.3-д заасан заалтыг хагас дутуу хэрэгжүүлсэн Говьсүмбэр, Дархан-Уул, Дорнод, Өмнөговь, Сүхбаатар зэрэг аймгуудыг дурьдаж байна. Харин яам, агентлагууд энэ журмыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Сум, аймгийн ЗДТГ-ууд өөрийн нутаг дэвсгэрт уул уурхай нь байршин үйл ажиллагаагаа явуулж буй компаниудаас хүлээн авсан татвар, төлбөр, төрөл бүрийн үйлчилгээний хураамж, хандив, тусламжийн дүнг ОУИТБС-ын маягтад заасан үзүүлэлтийн дагуу гаргаж, холбогдох дээд байгууллагадаа мэдээлж нэгтгүүлээгүйг эс тооцвол нэгтгэл тайлантай холбоотой дэлгэрэнгүй мэдээлэл авах зорилгоор хүргүүлсэн албан бичгэнд хариу өгөх ажилд аймаг, сумын ЗДТГ-ууд санаачлагатай сайн оролцож байсан. Энэ нь өнгөрсөн жилийнхтэй харьцуулахад орон нутгийн байгууллагуудын ОУИТБС-ын талаарх ойлголт сайжирсантай холбоотой байна.

7. АСУУДЛУУД

7.1 Байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд байршуулсан талаар

2009 оны байдлаар байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд байршуулсан дансны эцсийн үлдэгдэл 2.0 тэрбум орчим төгрөг байна. Анхны нэгтгэлээр 347,9 сая төгрөгийн зөрүү үүссэн бөгөөд гол шалтгаан нь дараах байдлаас үүдэлтэй байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 39.1.9-д заасны дагуу компаниуд нь байгаль хамгаалах эрх үүргээ 100 хувь биелүүлсэн тохиолдолд байршуулсан мөнгийг эргүүлэн авах эрх үүсдэг. Үүргийн биелэлтийг Мэргэжлийн хяналтын алба хянаж шалган акт үйлддэг. Гэвч компаниуд нь тухайн жилд хийж гүйцэтгэх ёстой байгаль хамгаалах ажлаа бүрэн биелүүлж чаддаггүй ба МХА-ны дүгнэлтээр 50-60 хувь, эсвэл 70 хувь гэх мэтээр акт дүгнэлт үйлддэг нь хуульд заасан 100 хувь гүйцэтгэсэн байх шаардлагыг хангадаггүй учраас байршуулсан мөнгөө эргүүлэн авахад хүндрэл үүсдэг байна.

Иймд компаниуд мөнгөө эргүүлэн авдаггүй ба анх төвлөрүүлсэн мөнгөө дараа жилийн байгаль хамгаалах ажлын зардалд тооцуулахаар үлдээдэг байна. Засгийн газрын зүгээс зөвхөн тухайн жилд нэмж төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг тайлагнадаг бол компаниуд нь өмнөх жилүүдэд болон энэ жил

нэмж төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгөө нийтэд нь тайлагнадаг байдлаас шалтгаалан анхны зөрүү үүссэн байна.

Төрийн сангийн тусгай дансны хөдөлгөөнийг харуулбал дараах байдалтай байна.

(сая төгрөгөөр)		
Онууд	Сангийн төвлөрүүлэлт	Сангийн буцаалт
2006	21.8	
2007	611.8	
2008	566.1	21.0
2009	385.4	125.5*
Дүн	1,585.1	146.5
Эцсийн үлдэгдэл	1,438.6	

*2009 онд зөвхөн "Экзодэм" ХХК 9.0 сая төгрөг, "Петрочайна Дачин Тамсаг" ХХК нь 116,5 сая төгрөгийг буцаан авсан байна.

7.2 Байгаль хамгаалах зардлын талаар

Байгаль хамгаалах зардлын анхны зөрүү нь 1.7 тэрбум болсон ба ЗГ-ын дүн нь компаниудын тайлагнасан дүнгээс илүү илэрхийлэгдсэн байна. Энэхүү зөрүүгийн шалтгааныг тодруулбал:

Ашиглалтын лиценз эзэмшдэг компаниуд нь уулын ажлын төлөвлөгөө болон уулын ажлын тайланг Ашигт малтмалын газарт, байгаль хамгаалах ажлын тайланг БОАЖЯ-ны Байгалийн нөөцийн газарт гаргаж өгдөг.

Уулын ажлын төлөвлөгөөгөөр нийт зардлын 10 хувьтай тэнцэх хэмжээний дүнгээр байгаль хамгаалах зардалд зарцуулах ёстой гэсэн шалгуурыг АМГ-аас тавьдаг ба компаниуд нь энэ шалгуурын үндсэн дээр уулын ажлаа төлөвлөж, гүйцэтгэлээрх тайлангаа мөн энэ шалгуурт нийцүүлэн тайлагнадаг байна.

Компаниуд нь БОАЖЯ-нд байгаль хамгаалах талаар хийж гүйцэтгэсэн ажлын тайланг ирүүлдэг ба энэ нь Ашигт малтмалын тухай хуулийн 38.1.8, 39.1.9-д заасны дагуу байгаль хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгон холбогдох тусгай дансанд байгаль орчныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах тухайн жилийн зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээг тооцох үндэслэл болдог. Үүнээс шалтгаалан тусгай дансанд бага мөнгө төвлөрүүлэхийн тулд БОАЖЯ-нд ирүүлдэг тайландаа байгаль хамгаалах зардлыг бага дүнгээр тусгадаг, АМГ-т байгаль хамгаалах талаар нилээд их ажил хийж гүйцэтгэсэн гэж харагдахын тулд зардлыг өндөр дүнгээр тайлагнадаг байдал нь харагдаж байна. Гэтэл ОУИТБС-ын тайлангаар ирүүлсэн дүн нь бодит гүйцэтгэл дээр үндэслэсэн бөгөөд тус газруудад илгээдэг тайлангийн дүнгээс зөрүүтэй байна.

Эндээс үзэхэд ижил утга бүхий тайланг 3 байгууллага өөр өөр дүнгээр авч байгаа нь эдгээр байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах, тайлангийн дүн адил байх нөхцлийг бүрдүүлэх шаардлагатай байгаа нь харагдаж байна.

7.3 Хураамж үйлчилгээний шимтгэл зөрүү үүсгэсээр байгаа талаар

Хураамж үйлчилгээний хөлсөнд ЗГ талаас огт мэдээлэл өгөгдөхгүй, мэдээлэл нэгтгэх тайлагнах механизм нь тодорхойгүй байгаа зэргээс энд үүссэн зөрүүг шийдвэрлэх ямарч боломжгүй байна. Компаниуд ихэвчлэн анх тайлагнасанаас дахин ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээлэлдээ улам нэмж ирүүлж байгаа нь зөрүүг улам нэмэгдүүлж байна. Энэ нь ихэвчлэн материаллаг бус дүнтэй бөгөөд хураамж шимтгэл төлсөн байгууллагууд нь улсын хэмжээнд тархан байрласан байгаа нь ЗГ талаас дүнг олж тохируулахад хүндрэлтэй, цаг хугацаа их шаардагдахаар байна. Хэдийгээр материаллаг дүнгүүдийг баталгаажуулахаар албан тоот явуулсан боловч газруудаас хариу ирүүлэхгүй, ирүүлсэн мэдээллүүд нь энэхүү ажлын шаардлагыг хангахгүй зэрэг нь зөрүүг шийдвэрлэхэд нөлөөлж байна.

7.4 Хандив тусламжийн талаар

ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд оролцох төрийн захиргааны байгууллагуудын чиг үүргийг ЗГ-ын 2007 оны 80 дугаар тогтоолоор баталсан хавсралтад сум, дүүрэг, аймаг нийслэлийн ЗДТГ нь орон нутгийн

төсөвт хүлээн авсан татвар, төлбөр, үйлчилгээний төрөл бүрийн хөлс, хандив дэмжлэг хүлээн авсан төсвийн байгууллагуудын мэдээг ОУИТБС-ын тайлангийн маягтад заасан үзүүлэлтийн дагуу аж ахуйн нэгж бүрийн нэрээр гаргаж өгөхийг тодорхой тусгасан хэдий ч жил бүрийн нэгтгэл тайланд орон нутгийн төсвийн байгууллагуудад төлсөн хандив, дэмжлэгийн дүн тусгагдахгүй зөрүү үүсгэсээр байна.

Мөн нэгтгэл тайлангийн ажлыг гүйцэтгэх явцад ЗГ-ын болон төсвийн байгууллагуудтай харьцаж, мэдээлэл солилцох үед "Хандив, тусламжийг бүртгэх" журмын талаархи ойлголт муу байсныг дурьдах нь зүйтэй.

7.5 Засгийн газрын тайланг гаргахад нэгжүүдийн уялдаа холбоо, хяналт чухал байгаа талаар

Анхны нэгтгэлээс үүссэн 265.0 тэрбум төгрөгийн зөрүүнд ЗГ-ын зүгээс тайлагнаагүй дараах материаллаг дүн бүхий зөрүү нөлөөлсөн. Тухайлбал:

(мянган төгрөгөөр)			
Урсгал	Компанийн нэр	Дүн	Хариуцах төрийн байгууллагууд
Аздууаауодзгí óóááóó áýóóú á¿òèé ææ áóóéí í yææéí Çàñàèéí áàçàðò í íááí ò á¿òóóááýò¿¿í èé í òí í ä ò°èñ°í ò°éá°ò	Петро Чайна Дачин Тамсаг Доншен газрын тос	18,133,692 9,154,229	Газрын тосны газар
Төрийн өмчийн ногдол ашиг	"Эрдэнэт үйлдвэр" ХХК	95,059,481	Төрийн өмчийн хороо
Бусад	"Оюу толгой" ХХК	143,422,000	Сангийн яам
Дүн		265,769,402	

Эндээс харахад анхны зөрүүнд дээр дурьдсан төлбөрүүд нөлөөлсөн байна. Бид анхны зөрүү үүсэхэд нөлөөлсөн асуудлуудын талаар холбогдох газруудтай уулзан шалтгааныг тодрууллаа.

ЗГ-ын тайлангийн нэгтгэлийг УТЕГ гүйцэтгэдэг ба нэгтгэл хийхийн өмнө ОУИТБС-ын тайланг гаргадаг зарим байгууллагууд руу хугацаандаа тайлан гаргуулах талаар албан бичиг илгээсэн байна. Гэвч ГТГ-аас нэгтгэлийн ажил дуусаад аль хэдийн ОУИТБС-ын ажлын албанд шилжүүлсний дараа буюу хугацаандаа мэдээллээ ирүүлээгүйгээс шалтгаалан ЗГ-ын тайланд хамрагдаж чадаагүй байна.

ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд оролцох төрийн захиргааны байгууллагуудын чиг үүргийг Засгийн газрын 2007 оны 80 дугаар тогтоолоор баталсан хавсралтаас үзэхэд ТӨХ нь төрийн болон орон нутгийн өмчийн ноогдол ашгийг тайлагнах үүрэгтэй ба хүлээн авсан ногдол ашгийг огт тайлагнаагүй нь зөрүү үүсэхэд нөлөөлсөн байна. ТӨХ нь 2008 онд бас тайлагнаагүй байсан.

"Оюутолгой" ХХК нь 2009 онд хөрөнгө оруулалтын гэрээний дагуу ЗГ-ын хямдруулсан өрийн бичгийг худалдан авахад төлсөн 100 сая ам.доллар буюу 143.0 тэрбум төгрөгийг тайлагнасан боловч Сангийн яамны зүгээс энэ орлогыг ямар нэгэн татвар, төлбөр, хураамж буюу орлогын урсгал биш гэж үзээд тайлагнаагүй нь зөрүү үүсэхэд нөлөөлсөн байна. ОУИТБ-ын зарчмаар компани нь ЗГ-т төлсөн аливаа төлбөрийг (өрийн бичиг худалдан авалт ч хамаарна) тайлагнах, ЗГ нь хүлээн авсан орлогын урсгалыг тайлагнах үүрэгтэй байдаг тул СЯ нь энэхүү хүлээн авсан орлогыг тайлагнах үүрэгтэй юм.

Энэ бүгдээс үзэхэд ОУИТБС-ын тайлан гаргах эрх бүхий ЗГ-ын зарим нэг байгууллагууд тайлан гаргахад ач холбогдол өгөхгүй байгаагаас хугацаа хоцруулах, огт тайлан ирүүлэхгүй байх зэрэг зөрчил байсаар байна. ТӨХ-ны хувьд энэ зөрчил өнгөрсөн жил мөн давтагдаж байсан.

УТЕГ нь тайлангийн нэгтгэл хийхдээ бүх газрыг хамруулах талаас идэвхтэй ханддаггүй, СЯ нь орлогын урсгалууд нь бүрэн хамрагдсан эсэхэд хяналт тавьдаггүй, зөвхөн УТЕГ-аас ирүүлсэн нэгтгэлийг ОУИТБС-ын ажлын албанд хүргүүлэх тухай албан бичиг бэлтгэх л үүрэгтэй оролцож байгаа нь учир дутагдалтай байна.

7.6 Тайланг илэрхийлсэн валютын зөрүү

Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийг "Ашигт малтмалын тухай" хуулийн 32.1-32.3-д заасны дагуу хайгуулын талбайн гектар тутамд ам.доллароор тогтоосон учраас компаниуд ам.доллароор төлбөрийг шилжүүлдэг, харин санхүүгийн тайланг гаргахдаа "Нягтлан

бодох бүртгэлийн тухай” хуулийн 6, 9.2-д заасан заалтуудад үндэслэн төлбөр хийсэн өдрийн Монголбанкнаас зарласан ханшийг үндэслэн төгрөгт шилжүүлж бүртгэж, ОУИТБС-ын тайланд уг төлбөрийг төгрөгөөр тусгадаг.

Анхны нэгтгэл тайлангаар ЗГ талаасаа ам.доллороор, компани талаасаа мянган төгрөгөөр илэрхийлэгдсэн нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 6.1-д заасан “Нягтлан бодох бүртгэлийн үзүүлэлтийн нэгжийг Монгол Улсын мөнгөн тэмдэгт төгрөг, мөнгөөр илэрхийлнэ” гэсэн заалтад нийцэхгүй байгаагаас гадна монгол төгрөг, гадаад валютын аль алианаар нь илэрхийлэн нэгтгэсэн тайлангийн зөрүүний үзүүлэлтийн нэгж буруу илэрхийлэгдэж байна.

АМГ-аас ОУИТБС-ийн тайлангийн маягтанд дур мэдэн Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын *òõñààé ç°* ашөөрлийн төлбөр /доллар/ гэсэн мөр оруулан тайлагнаж байгаа нь бүх компаниуд дээр энэ төлбөр дээр зөрүү үүсгэж байна. Төгрөгөөр илэрхийлэхдээ мянгачилж, валютаар илэрхийлэхдээ бүхлээр нь илэрхийлж байна.

СЯ нь ОУИТБС-ын тайлангийн үзүүлэлтийн нэгж, хоёр өөр валютаар илэрхийлэгдэн нэгтгэгдсэн дүнг анзааралгүй, хянаж шалгахгүйгээр нэгтгэл тайланг албан бичгээр баталгаажуулан ОУИТБСАА-нд хүргүүлж байгаагаас харахад нэгтгэл тайлангийн зөрүүг багасгах тал дээр ЗГ талаас санаачлагатай ажил хэрэгчээр хандаж байгаа нь харагдахгүй байна.

7.7 УТЕГ-ын мэдээллийн нэгдсэн системд байгаа дутагдлын талаар

Аймаг, нийслэл, сум, дүүргийн татварын хэлтэст аж ахуйн нэгжээс төлөгдсөн татвар, төлбөр, хураамжийг мэдээллийн баазад шивж оруулахдаа аж ахуйн нэгжийн регистрийн дугаараар бус, бусад харилцагч гэсэн өөр кодоор шивж оруулдаг байна. Энэ нь компаниас ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээллийн дагуу тухайн татварын байгууллагад хандахад уг компанийн нэр, регистрээр шүүж үзэхэд гарч ирдэггүй хүндрэл учирч байсан.

7.8 Тайланг нэгтгэх явцад гарч буй алдааны талаар

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орон нутагт төвлөрдөг 30 хувийг давхардуулж тусгадаг.

Нэг татварын илүү төлөлтөөс нөгөө татварын дутуу төлөлт рүү шилжүүлэн тооцдог. (Ингэж шилжүүлэн тооцсон дүнгээр ААН-тэй тооцоо нийлдэггүй).

Татварын хяналт шалгалтын актаар тавигдсан нөхөн татвар, торгуулийн дүнг ОУИТБС-ын тайланд тусгадаг.

Он дамжиж төсвийн дансанд орсон дүнг дараа оны нэгтгэлд хамруулдаг. (Компани нь тухайн төлсөн хугацааны тайландаа тусгадаг).

7.9 Хөдөө орон нутагт төлөгдөж байгаа төлбөрүүд зөрүүгийн дүнд нилээд нөлөө үзүүлж байна.

Орон нутгийн төсөвт төвлөрдөг газрын төлбөр, ус рашаан ашигласны төлбөр татварын нэгдсэн мэдээллийн баазад нэгтгэгдэхгүй байна. Уг төлбөрүүдийг газрын албаны байцаагч хураадаг боловч орон нутгийн татварын байцаагчид өгч мэдээллийн баазад нь нэгтгүүлдэггүй байна.

Зөрүүг тодруулж орон нутгийн байгууллагуудтай холбогдож мэдээлэл авахад маш их цаг хугацаа, хүч хөдөлмөр аудитын багийн зүгээс шаардагдсаныг хэлэх нь зүйтэй.

7.10 Лиценз шилжүүлэлт нь зөрүү үүсэхэд нөлөөлж байна.

Ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийг эзэмшигч компаниуд өөр компанид худалдан борлуулсан, шилжүүлсэн тохиолдолд авсан компани нь өөрийн нэрээр лицензийн төлбөрийг төлөлгүй хуучин компанийн нэрээр төлбөр төлөгдсөнөөр компанийн дүн бага АМГ-аас ирүүлсэн мэдээллийн дүн

их байгаа нь зөрүү үүсгээд байна. Эндээс харахад АМГ-ын лицензийн шилжих хөдөлгөөний бүртгэл хангалтгүй, мөн компаниудын ажилд хандах хандлага муу байгааг харуулж байна.

Компаниуд лиценз тус бүр дээрээ охин компани шинээр байгуулж тус охин компанид лиценз эзэмшүүлж байна. Үүний улмаас нэг компанийхаа өмнөөс нөгөө компани нь төлбөрийг төлж байгаагаас зөрүү хаанаа үүссэн эсэхийг тодруулахад маш их цаг зав зарцуулагдаж хүндрэл учруулж байна.

7.11 Хүндрэл бэрхшээл

ҮТЕГ-аас АМНАТ-ийг анх тайлагнахдаа хөдөө орон нутаг руу буцаан шилжүүлдэг 30%-ийн төлбөрөө нэмж оруулж тайлагнаснаас зөрүү үүсгэх нэг нөхцөлийг бүрдүүлсэн.

Тухайлбал: "Буд Инвест" ХХК-ийн хувьд ЗГ талаас анх 49,044 мянган төгрөг, компани талаас 37,726 мянган төгрөгийг тайлагнасан байсан. Үүссэн зөрүүг тодруулахаар 2 талд албан бичгийг хүргүүлэхэд мөн л тайлагнасан дүнгээ баталгаажуулсан дэлгэрэнгүй мэдээллүүд ирүүлсэн. Ингээд компани талд дутуу байгаа учраас компаниас дахин тодруулах албан бичиг хүргүүлсэн. Гэтэл нягтлан бодогч нь "би энэ дүнгүүдийг санхүүгийн баримтаасаа хайгаад олохгүй байна" гэж утсаар хандахад "танай талд дутуу харагдаад байна дахиад сайн шүүгээд үз" гэж шаардсан. Нягтлан бодогч хэд хоногийн дараа санхүүгийн баримт материалд байхгүй байна гэсэн мэдэгдэл бүхий бичиг ирүүлсэн. Ингээд ҮТЕГ луу хандахад шүүж үзээд бид 30%-ийнхаа төлбөрийг оруулсан байна гэж хариу ирүүлсэн. Нэг төлбөрийн зөрүүг тодорхойлохын тулд ингэж маш их цаг хугацаа, хүч хөдөлмөр зарцуулдаг гэдгийг эндээс харж болно.

ОУИТБС-ын нэгтгэл тайлангийн ажил эхлээд компаниуд руу албан бичиг илгээж дэлгэрэнгүй мэдээллийг авсаны үндсэн дээр холбогдох аймаг, нийслэл, сум, дүүргийн татварын байгууллагуудад албан бичиг илгээж хариуг авахад "манайд төлөөгүй байна, мэдээллийн баазад байхгүй байна" гэх мэтийн хариу өгч байсан байгууллагуудаас (протокол үйлдэх гэхээр) холбогдох мэдээлэл гарч ирж байгаагаас харахад тэнд ажиллаж байгаа төрийн албан хаагчдын ажилд хандах хандлага, ажил мэргэжлийн үр чадвар дутмаг, хийсэн ажилдаа хариуцлага хүлээхээс зайлхийдэг зэрэг нь бидний ажилд хүндрэл учруулж байсан.

Ажлын хэсгийн анхны хуралдааны шийдвэрийг тус хуралд оролцсон АМГ-ын мэргэжилтэн Санхүү, эдийн засгийн тасгийн ажилтнуудадаа огт танилцуулаагүйн улмаас энэ тасгаас дахин мэдээлэл авч чадахгүй ихээхэн цаг хугацааг зарцуулж байсан.

АМГ-ын санхүүгийн программ шинэчлэгдсэнтэй холбоотойгоор 2009 оны эхний 3 сарын мэдээлэл тодорхой бус байснаас ихээхэн чирэгдэл болж байв.

АМГ-ын зарим хэлтэс, тасаг нь мэдээллийг гаргаж өгөхөөс татгалзаж байсан. Татгалзаж байгаа шалтгаанаа дараахь байдлаар тайлбарлаж байна. "Байгууллагын дотоод нууц, эдгээр уул уурхайн компанийн зөвшөөрөлгүй бид нар мэдээлэл гаргаж өгөхгүй гэх мэтчилэн тайлбар өгч байсан". Энэ байдал нь энэхүү тайлангийн "ил тод" гэсэн утгыг алдагдуулж байна. ЗГ-ын байгууллагын ажилтнуудын хүнд суртал, хөшүүн хойрго байдал, албан бус байдлаар асуудалд хандах, тайлангийн талаархи ямарч ойлголт байхгүй "юун утгагүй юм нэхээд ажил хийлгэхгүй байна", "даргаас заавал албан цохолтоор үүрэг авсан тохиолдолд гаргаж өгнө" гэхчилэн уцаарласан цааргалсан, бие биен лүүгээ түлхсэн байдлаар хандах зэрэг нь аудитын багийн гишүүдэд дахин дахин чирэгдэл учруулж байсныг дурьдах нь зүйтэй.

Мөн компаниуд яам, агентлагт өгсөн хандив, дэмжлэгийн баримтыг гаргаж өгөхөөр эргээд биднийг аливаа зүйлээр дарамтлах вий гэж тэд болгоомжилж байсан.

7.12 ОУИТБС-ын тайланг хайхрамжгүй, алдаатай бэлтгэдэг байдал давтагдсаар байна.

ОУИТБС-ын тайлангаа ЗГ болон компани талаас бөглөхдөө буруу буюу илүү дутуу дүнгээр бөглөх, мөн ОУИТБС-ын тайлангаа гаргаж өгөөгүй зэргээс үүдэж зөрүү үүсэх анхны шалтгаан үүсч байна. Энэ нь буруу зөрүү тайлагнасан тохиолдолд ЗГ-ын агентлаг болон компанийн удирдлага болон нягтлан бодогчидтой хариуцлага тооцох систем байхгүй байгаатай шууд холбоотой юм.

Компаниудын нягтлан бодогч олон дахин солигдож байгаа нь өмнөх нягтлан бодогчийнхоо ажлыг мэдэхгүй, эсвэл тайланг бөглөх ойлголт дутмаг, хайнга хандах зэргээс үүдэлтэй зөрүү байна. Зарим нэгэн компанийн нягтлан бодогч болон санхүүгийн ажилтнуудын үр чадвар дутмаг, жилийн жилд санхүүгийн ажилтнууд нь өөрчлөгдөж байгаа зэргээс шалтгаалан тухайн оны санаачлагын тайланг огт гаргаж өгөхгүй мөн тайланд тусгагдаж байгаа тоон үзүүлэлтийн мөн чанарт анхаарлаа хандуулж үнэн зөв илэрхийлэхгүй байгаа нь анхны зөрүүг үүсгээд байна.

Компаниудаас үзүүлсэн хандив дэмжлэгийн дүнг баталгаажуулах зорилгоор яам агентлаг болон томоохон төсвийн байгууллагууд руу албан бичиг хүргүүлдэг ба эдгээр байгууллагууд нь хариу өгөх тал дээр хариуцлагагүй, хойрго хандаж байна. Энэ нь өнгөрсөн тайлангийн хугацааны мэдээлэл тодруулж байгаатай холбогдуулан ихэнх байгууллагууд архивын баримт үзэхээс төвөгшөөж байна.

7.13 Тайлан гаргахад хойрго ханддаг байдал

Биднийг нэгтгэлийн ажлаа бүрэн хийхэд анхны өгөгдсөн мэдээлэл болон тэдгээрийг батлах, дэлгэрэнгүй мэдээллээр хангах байдал зарим компаниуд хойрго хандаж байсан. Тухайлбал:

“Т энд Ч” ХХК нь ОУИТБС-ын 2009 оны тайлангаа өгөөгүйгээс анхны нэгтгэлээр 93,106 мянган төгрөгийн зөрүү үүссэн. Компани нь лицензээ өөр компанид шилжүүлээд одоо үйл ажиллагаа явуулаагүй байгаагаас холбоо барих утас, хаягийг нь тодруулах гэж ихээхэн цаг хугацаа алдсаны эцэст Төв аймгийн татварын хэлтсээс утсыг нь олж, 2011 оны 4 дүгээр сарын 8-нд албан тоот хүргүүлсэн. Албан тоот хүргүүлээд нягтлан бодогчтой нь холбогдоход “би ажилд ороод удаагүй учраас өмнөх санхүүгийн талаар мэдэхгүй байна, тэгээд ч манайх олборлолт хийгээгүй учраас гаргаж өгөх ёстой үгүйг мэдэхгүй байна” гэсэн хариултыг анх өгсөн. Түүнээс хойш хэд хэдэн удаа утсаар холбогдоход “би ажил ихтэй байна, амжихгүй байна, одоо ингээд явуулаа” гэх мэт аргацаасан тайлбар тавьж ихээхэн чирэгдэл учруулж байсан.

Тус компанийн талаар интернетээс мэдээлэл хайх явцад Төв аймгийн Заамар суманд Өгөөмөр гэдэг газар алтны олборлолт хийчихээд нөхөн сэргээлт хийгээгүй хаяад явсан гэсэн нийтлэл гарчиг бүхий мэдээллүүдэд орсон байгаа юм. Үнэхээр нягтлан бодогчийн хэлсэнээр одоо олборлолт хийхээ больсон юмуу гэхээр Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын нутагт орших “Хөх булгийн хөндий” хэмээх газарт алт олборлож байна гэсэн мэдээлэл байгаа юм.

“Доншен газрын тос” ХХК-нд 2011 оны 2 дугаар 19-ний өдөр тодруулга авах талаар албан бичиг явуулсан боловч хариу ирэхгүй сарын хугацаа өнгөрсөн. Ингээд албан бичгийн хариуг шаардаж утсаар холбогдоход туслах нягтлан бодогч Цолмон нь “манай санхүүгийн албаны дарга Хятад хүн байдаг, танай албан бичгийг уншаад хариу өгөхгүй, харин бид нар Газрын тосны газарт л мэдээлэл өгөх үүрэгтэй” гэж хариулсан. Иймд аудитын багийн зүгээс арга хэмжээ авч Ерөнхий сайдын ахлах зөвлөх, ОУИТБС-ын Үндэсний Зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Долгорын гарын үсэгтэй шаардах албан бичгийг 2011 оны 3 дугаар 29-ний өдөр хүргүүлэхэд мөн л хариу өгөхөөс татгалзсан. Ингээд 2011 оны 4 дүгээр сарын 8-ний өдөр ОУИТБС-ын зохицуулагч Ш.Цолмон болон “Улаанбаатар аудит корпораци” ХХК-ийн ерөнхий захирал Б.Осоргарав нар тус компани дээр очиж удирдлагатай уулзахаар болж компани руу утсаар ярьж цаг авах гэтэл “та нар наашаа ирэх хэрэггүй бид нар бэлтгэж байгаа” гэсэн хариу өгсөн учраас очиж уулзах товийг хойшлуулсан. Үүнээс хойш 7 хоногийн дараа албан бичгийн хариу ирсэн болно.

Ер нь гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд аливаа асуудалд хандахдаа хойрго удаан, үл тоомсорлосон байдалтай байгаа хандлага ажиглагдсаныг дурьдах нь зүйтэй.

Харин нэгтгэл тайлангийн ажилд идэвхи санаачлага гарган ажиллаж, бидний шаардсан мэдээллийг үнэн зөв, цаг хугацаанд нь гаргаж ирүүлсэн “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Оюу толгой” ХХК, “Чинхуа мак Нарийн сухайт” ХХК, “Цэвдэг” ХХК, “Өрмөн уул” ХХК, “Адуунчулуун” ХХК, “Анхай интернешнл” ХХК, “Баян-Эрч” ХХК, “Гурван төхөм” ХХК зэрэг компаниудыг онцлон дурьдмаар байна.

(Оролцооны хүснэгтийг Хавсралт М-ээс үзнэ үү).

8. ЗӨВЛӨМЖҮҮД

8.1 Олборлох үйлдвэрлэлийн салбарт борлуулсан ЗГ-ын өрийн бичгийн орлогыг ОУИТБС-ын тайланд хамруулах тухай

ОУИТБС-ын тайлан нь мөнгөн сууриар бэлтгэдэг учир олборлох үйлдвэрлэл эрхэлдэг компаниудад борлуулсан өрийн бичгийн орлогыг оролцуулаад авсан мөнгөн урсгал нь ЗГ-ын орлогод тооцогдох ёстой. Олон нийтийн хэвлэл мэдээлэлээр өргөн хүрээнд хэлэлцэгдсэн орлогыг орхигдуулсанаар ОУИТБС-ын тайланд нөлөөлж болно. Цаашид Монгол улсад хэрэгжих уул уурхайн томоохон төслүүдийн хувьд урьдчилгаа төлбөр хэлбэрийн мөнгөн урсгалууд гарах магадлалтай тул үүнийг ОУИТБС-ын тайланд оруулах эсэх дээр ажлын хэсэг тодорхой шийдвэр гаргах нь зүйтэй байна.

8.2 Компаниуд нь хандив тусламжийн зарим хэсгийг ашиг орлогын урсгал хэсэгт тайлагнах тухай

Компаниудын тайлагнан ирүүлсэн хандив тусламжийн дүнгүүд нь ихэнх тохиолдолд ЗГ-т өгсөн бус харин сайн дурын болон нийгэм, олон нийтийн ашиг тусын (барилга, засвар гэх мэт) түлд өгсөн зардлуудыг харуулж байгаа билээ. (Хавсралт Т)

Тиймээс ЗГ-т төлөөгүй буюу өгөөгүй дүнг ОУИТБС-ын маягтны Хамрах хүрээ 2 буюу Ашиг орлогын урсгал хэсэгт оруулах нь зүйтэй хэмээн зөвлөж байна. Түүнчлэн, Ажлын Хэсэг нь ЗГ-т тайлагнах хандив, тусламжийн дүнгийн хамгийн бага дүнг тогтоох буюу анхааран үзэх хэрэгтэй.

8.3 Дэд-гүйцэтгэгч нарын тухайд

Уул уурхайн салбараас ЗГ-ын тайлагнасан дүн дутуу илэрхийлэгдсэн нь Ажлын хэсэг болон Үндэсний зөвлөл нь ОУИТБС-ын тайлан нэгтгэлд ороогүй уул уурхайн салбараас Засгийн газрын тайлагнасан дүн материаллаг хэмжээтэй эсэхийг хянах хэрэгтэй нь харагдаж байна.

Уул уурхайн томоохон хэмжээний ажлын дэд гүйцэтгэгчээр ажиллан, улс орон нутгийн төсөвт материаллаг хэмжээний татвар, төлбөр, хураамж төлж байгаа компаниудыг ОУИТБС-ын маягтанд багтаах, түүнчлэн боломжтой бол маягтыг бөглүүлэн ирүүлэхийг шаардах нь зүйтэй байна. Учир нь Монгол улсад ялангуяа иймэрхүү чиглэлийн туслан гүйцэтгэгч оператор компаниудын үйл ажиллагаа улам бүр нэмэгдэх хандлагатай байна.

8.4 Хандив, тусламжийг бүртгэх журмыг хэрэгжүүлэх талаар

Төрийн захиргааны байгууллагууд нь Сангийн сайдын 2010 оын 45 тоот тушаалаар батлагдсан "Хандив, тусламжийг бүртгэх" журмын талаар ойлголт сул байгаа нь нэгтгэл тайлангийн ажлыг гүйцэтгэх явцад ажиглагдсан учраас Сангийн яамнаас хэрэглэгчдэд сургалт, семинар зохион байгуулж, цаашид журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах нь зүйтэй байна.

8.5 Материаллаг байдлын түвшинг тодорхой болгох тухай

Хураамж, үйлчилгээний 10-15 нэр төрлийн хөлс (төлбөр)-ийг бага дүнгээр олон газрыг хамруулан 1.1-50.0 мянган төгрөгийг компаниуд төлдөг ба дэлгэрэнгүй мэдээлэлдээ ч тусгаж өгдөг. Харин ЗГ энэ бүхнийг нэгтгэж ОУИТБС-ын тайланд тусгах боломжгүй байна. Ийм учраас цаашид ОУИТБС-ын нэгтгэлийн ажлыг гүйцэтгэх ажлын даалгаварт нэг удаагийн төлөлт нь 50.0 мянган төгрөгөөс доош дүнтэй хураамж, үйлчилгээний хөлс (төлбөр)-ийг аудиторруудад компанийн баримтанд үндэслэн зохих залруулга хийхийг зөвшөөрөх гэсэн саналыг дэвшүүлж байна.

Нэгтгэл тайланд хамрагдах уул уурхайн үйл ажиллагаа эрхэлдэг компаниудын тоо жилээс жилд олноор нэмэгдэж байгаатай холбогдоод бүх аймгийн бараг бүх сумдыг хамрах магадлал өндөр болно. Ийм учраас хайгуулын үеийн байгаль орчныг хамгаалах зардалд зориулан орон нутгийн ЗДТГ-т төвлөрүүлдэг 50 хувь болон хандив, тусламжийн дүнг тодруулахад, орон нутагт харилцаа, холбоо муутай байдгаас шалтгаалаад цаг хугацаа их зарцуулах учраас хайгуулын үеийн байгаль орчныг

хамгаалах зардал болон хандивын материаллаг түвшинг нэгтгэлийн ажлыг гүйцэтгэх ажлын даалгаварт тодорхой дүнгээр зааж өгч байх саналыг мөн дэвшүүлж байна.

8.6 Өөр валютаар илэрхийлэгдсэнээс үүссэн зөрүүг арилгах тухай

АМГ нь компаниудаас хүлээн авсан төлбөрөө уг төлбөрийг хүлээн авсан өдрийн Монголбанкнаас $\text{᠑᠙9᠑᠗᠘᠗᠗.᠙᠔}᠐000000$, аж ахуйн нэгж бүрээр гарган ҮТЕГ-т мэдээлдэг болох, СЯ нь тайлангийн нэгтгэлийг зөвхөн Монгол төгрөгөөр хийж байх талаар журамлаж, үүрэг болгох нь зүйтэй байна.

8.7 ЗГ-ын зүгээс анхны зөрүү үүсгэж байгаа асуудлыг сайжруулах тухай

Хайгуулын олон лиценз эзэмшигч уул уурхайн компаниуд нь ("Х" лиценз) бараг бүх аймгийн ихэнх сумдад байгаль хамгаалах зардлын 50 хувийг орон нутгийн төсөвт (доод тал нь 50 мянгаас 15 сая хүртэл) төвлөрүүлж байна. Харин БОАЖЯ нь зөвхөн ашиглалтын лиценз эзэмшигч компаниудаас "Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө"-нд тусгасан нөхөн сэргээлтийн зардлын 50 хувийг төвлөрүүлдэг ба хайгуулын лиценз эзэмшигч компаниудаас хөрөнгө төвлөрүүлдэггүй байна. Хайгуулын лиценз эзэмшигч компаниуд ОУИТБС-ын тайланд уг төвлөрүүлсэн дүнг тусгаж, харин ЗГ талаас энэ дүнг хэн тайлагнах чиг үүрэг нь тодорхой бус учраас зөрүү үүсгэж байна. Энэ зөрүүг гаргахгүй байх үүднээс аймаг, нийслэл, сум, дүүргийн ЗДТГ-аас АМГ-т нэгтгүүлдэг байх талаар ажлын чиг үүргийг нарийн тодорхойлж өгөх нь чухал байна.

Мөн "Ашигт малтмалын тухай" хуулийн 43.1-д зааснаас илүү хэмжээгээр авч ажиллуулсан ажлын байр тутамд хөдөлмөрийн хөлсний хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төлбөрийг сар бүр сум, дүүргийн төсөвт төвлөрүүлсэн дүнг тухайн аймаг, сум, дүүргийн ЗДТГ нэгтгэн ХХҮГ-т тайлагнаж байх талаар талуудын чиг үүрэгт тодорхой тусгаж өгөх.

Байгаль орчныг хамгаалах зарлын гүйцэтгэлийн тайланг БОАЖЯ-ны Байгалийн нөөцийн газар хүлээн авахдаа компаниудаас АМГ-ын даргын 2009 оны 411 дүгээр тушаалаар батлагдсан "Маягт-7"-оор гаргаж Геологи, судалгааны хэлтэст өгсөн "Байгаль орчны нөхөн сэргээлтийн ажлын мэдээ"-нд тусгасан дүнг үндэслэл болгож хүлээн авч байх, улмаар энэ дүнгээр ОУИТБС-ын нэгтгэлийг хийж байх нь зүйтэй байна.

8.8 МОУИТБС-ын ажлын албаны бүтэц зохион байгуулалтын талаар

Уул уурхайн компанийн ил тод байдлыг хангах үйл ажиллагаа жилээс жилд өргөжин тэлж, нэмэгдэж байгаатай холбогдуулан уг ажлын албаны ажлын цар хүрээ асар ихээр нэмэгдэж байгаа учраас орон тоог нэмэгдүүлэх нь зүйтэй байна. Ажлын цар хүрээ нэмэгдэхийн хирээр орон тоо хүрэлцэхгүй, ажил цалгардах магадлалтай байна.

8.9 Орон нутагт төвлөрдөг төлбөрийг ҮТЕГ-ын мэдээллийн баазад нэгтгэх талаар

"Газрын төлбөрийн тухай" хуулиар татварын байгууллага нь уг төлбөрийн ногдуулалт, төлөлтөд хяналт тавих талаар тодорхой заагдсан байдаг боловч сум, дүүрэг, аймаг, нийслэлийн газрын албаны ажил мэтээр үзэж татварын байгууллагуудын мэдээллийн баазад нэгтгэлгүй орхигдуулж байгаа байдалд анхаарч, цаашид зохих арга хэмжээ авч ажиллах нь жилийн жилд үүсээд байгаа зөрүүг дахин үүсгэхгүй байхад том алхам болно гэж үзэж байна.

8.10 ҮТЕГ-ын тайлангийн нэгтгэлд гарч буй дутагдлыг арилгах талаар

Уул уурхайн үйл ажиллагаа эрхэлж буй компанийн тоо жилээс жилд нэмэгдэж, мөн тэдгээрийн ашиг орлого өсөхийн зэрэгцээ ОУИТБС-ын тайлангийн нэгтгэлд өргөн хүрээгээр хамрагдах учраас компаниас төлсөн татвар, төлбөр, хураамж, үйлчилгээний хөлсийг ил тод байлгах үүднээс ялангуяа тэмдэгтийн хураамж болон төрөл бүрийн үйлчилгээний хөлс, газрын төлбөр, ус, рашаан ашигласны төлбөр зэргийг бусад гэсэн бөөн дүнгээр бус, төлбөр, хураамжийн нэр төрлөөр, аж ахуйн нэгжийн нэр, регистрээр мэдээлийн нэгдсэн баазад оруулдаг болгох, мөн "Эрдэс баялагийн хэлтэс" нь Үндэсний статистикийн хорооны дарга, Сангийн сайдын 2011 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 01/12/13 тоот хамтарсан тушаалаар батлагдсан Маягт ОУИТБС-6, уг маягтыг нөхөх заавар зэрэгт өөрийн ажлаа уялдуулан зохион байгуулах нь зүйтэй байна.

ОУИТБС-ын тайлангийн нэгтгэлийг хийхдээ өмнөх жилүүдэд зөрүү үүсгээд байсан алдаа, дутагдлыг гаргахгүй байх тал дээр анхаарч ажиллахаас гадна ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд оролцох Төр, захиргааны байгууллагуудаас холбогдох мэдээллийг авч, орхигдуулахгүйгээр тусгаж байх нь чухал байна.

8.11 Нэгтгэлийн тайлан бэлтгэх хугацааны талаар

Нэгтгэл тайланд хамрагдаж буй уул уурхайн компаниудын тоо жилээс жилд өсч, ажлын цар хүрээ нэмэгдэж байгаа тул нэгтгэлийн ажлын хугацааг урт болгох нь зүйтэй байна. Хугацаа урт байснаар нэгтгэл ажлын чанарт сайнаар нөлөөлнө. Мөн нэгтгэлд хамрагдах компанийн тоо нэмэгдэх тутам орон нутгийг хамрах хүрээ тэлж байна. Тухайлбал: Хөдөө орон нутгийн алслагдсан суманд үзүүлсэн хандив, дэмжлэгийн дүнг баталгаажуулахад /зөвхөн албан бичиг хүргэхэд/ хагас сарын хугацаа шаардлагатай байна. Энэ нь аймаг, сум хооронд шуудан долоо хоногт нэг удаа явдагтай холбоотой байна.

Хавсралт А-Нэгтгэлийн дүнд үүссэн залруулгууд (1) – санхүүгийн урсгалаар

Тайлангийн Бүлэг 5.1-д маягтуудаар анхлан ирүүлсэн санхүүгийн урсгалуудын нийт дүнг харуулсан. Энэхүү хавсралт нь Монголын ОУИТБСАА-аас тогтоосон маягтуудын дагуу анхлан ирүүлсэн дүнд хийсэн залруулгуудыг дүрслэн харуулж байгаа болно.

1. Татварууд

Анхлан ирүүлсэн маягтууд дахь татварууд хэсгийн зөрүүнүүд болон нэгтгэлийн үр дүнд засгийн газрын нэгж байгууллагууд, компаниудаас ирүүлсэн дүнд хийсэн залруулгуудыг дараахи байдлаар харуулав. Үүнд:

Бүлэг	Анхны нэгтгэлийн зөрүүнүүд, цэвэр мян.төг	Тохируулагдсан байдал		Тохируулгын дараах шийдэгдээгүй зөрүүнүүд, цэвэр мян.төг
		Засгийн газрын байгууллагууд мян.төг	Компаниуд мян.төг	
1.1 Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	9,967,704	97,304,508	97,304,508	-
1.2 Гаалийн албан татвар	(19,047,045)	12,255,464	12,255,464	-
1.3 Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	9,064,800	185,650,852	185,650,852	-
1.4 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	(368,745)	2,812,561	2,812,561	-
1.5 Онцгой албан татвар (шатах тослох материал импортолсон бол)	1,148,117	2,295,506	2,295,506	-
1.6 Автобензин, дизелийн түлшний албан татвар	(63,387)	127,847	127,847	-
1.7 Автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар	(9,528)	201,284	201,284	-
1.8 Мөнгөн дүнгээрх бусад татварууд (1)	-	-	-	-
1.9 Мөнгөн дүнгээрх бусад татварууд (2)	-	-	-	-
Нийт	691,916	300,648,022	300,648,022	-

1.1 Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ)

Үзүүлэлт	Анхны нэгтгэлийн зөрүүнүүд, цэвэр мян.төг	Тохируулагдсан байдал		Тохируулгын дараах шийдэгдээгүй зөрүүнүүд, цэвэр мян.төг
		Засгийн газрын байгууллагууд мян.төг	Компаниуд мян.төг	
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	9,967,704	97,304,508	97,304,508	-

ААНОАТ-ын анхны зөрүүнд хийгдсэн томоохон залруулгуудыг дурьдвал:

- “Адамас Майнинг” “Анхай интернэшнл”, “Багануур”, “Баярсголд”, “Болд төмөр ерөө гол”, “Гацуурт”, “Оюу толгой”, “МОНЭНКО”, “Рео”, “Шинь Шинь” зэрэг компаниуд нь анхны тайландаа аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг дутуу тусгасан ба нэгтгэл тайлангийн явцад ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээллээр төлсөн дүнгээ тодорхойлж өгсөн.
- “АУМ” ХХК нь анхны тайландаа дүн тусгаагүй байсан. ЗГ талд 35,463 мянган төгрөг тусгагдсан байсан ба компаниас нэгтгэл тайлангийн үед тодруулахад татварын хяналт шалгалтын актын төлбөрт 36,477 мянган төгрөг төлсөн ба үүнээс өөр татвар төлөөгүй, “Нордвинд” ХХК нь 2005, 2006, 2007 онуудыг хамарсан татварын хяналт шалгалтаар тавигдсан актын төлбөрийг ААНОАТ-т оруулж тусгасан.
- “Олон овоот гоулд”, “Энержи ресурс” компаниуд нь анхны тайландаа уг татварыг мөнгөн сууриар бус аккруэл сууриар тусгасан байна.
- “Бумбат”, “Монполимет”, “Одод”, “Очир ундраа”, “Кайнар Вольфрам”, “Сүйхэнт” зэрэг компаниуд нь 2009 оны тайлангаа ОУИТБСанаачлагын ажлын албанд гаргаж өгөөгүй ба нэгтгэл тайлангийн үед гаргаж өгсөн.
- “Таван толгой”, “Шивээ овоо” компаниуд нь анхны тайландаа төлсөн татвараа дутуу тусгасан мөн 2008 оны эцэст төлсөн татварын дүнгээр анхны зөрүү үүссэн. Харин уг татвар нь он дамжиж улсын төсөвт орсон учраас УТЕГ 2009 оны тайландаа тусгасан байна.
- “Тунсинь”, “Цайрт минерал”, “Эрдэнэт үйлдвэр” зэрэг компаниуд нь анхны тайландаа НӨАТ-ын илүү төлөлтөөс “Чинхуа Мак нарийн сүхайт” ХХК нь ХХОАТ-ын илүү төлөлтөөс суутган тооцсон дүнг тусгаагүй, харин УТЕГ анхны тайландаа суутган тооцсон дүнг тусгаж өгсөн байна.
- “Хангад эксплорэйшн” ХХК болон УТЕГ нь анхны тайландаа Чингэлтэй дүүрэгт төлсөн татварын дүнг тусгаагүй байна
- “Цогт онон” ХХК анхны тайландаа уг татварыг мянган төгрөгөөр илэрхийлээгүй, төгрөгөөр илэрхийлж тусгаснаар зөрүү үүссэн байна.
- “Эрэл” ХХК нь анхны тайландаа Нийслэлийн татварт төлсөн татварын дүнг дутуу тусгасан нь дэлгэрэнгүй мэдээллээр нотлогдсон.
- “Монголболгаргео” ХХК нь анхны тайландаа 5,510 мянган төгрөгөөр, “Монголчехметалл” ХХК нь 120 мянган төгрөг, “Сонор Трейд” ХХК нь 4,617 мянган төгрөгөөр тус тус дутуу тусгасан болох нь ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээллээр тодорхой болсон.
- “Шижир алт” ХХК анхны тайландаа төлсөн татвараа 8,711 мянган төгрөгөөр дутуу тусгасан байна.

1.2 Гаалийн албан татвар

Үзүүлэлт	Анхны нэгтгэлийн зөрүүнүүд, цэвэр мян.төг	Тохируулагдсан байдал		Тохируулгын дараах шийдэгдээгүй зөрүүнүүд, цэвэр мян.төг
		Засгийн газрын байгууллагууд мян.төг	Компаниуд мян.төг	
Гаалийн албан татвар	(19,047,045)	12,255,464	12,255,464	-

Гаалийн татварын анхны зөрүүнд хийгдсэн томоохон залруулгуудыг дурьдвал:

- Гаалийн албан татварын хувьд гаалийн ерөнхий газраас ирүүлсэн тайлан болон дэлгэрэнгүй мэдээлэлд үндэслэн компаниуд руу тохируулах үүднээс ажилласан ба компаниуд нь ихэвчилэн гаальд төлсөн НӨАТ, онцгой албан татвар, авто бензин дизелийн түлшний албан татвар, гаалийн бүрдүүлэлтийн хураамж зэргийг бүхэлд нь тайлагнасан учраас залруулыг гаалийн ерөнхий газрын тайлангийн дүнгээр хийсэн.
- “Адуунчулуун” ХХК нь тайландаа 7,746 мянган төгрөгийн, “Буд инвест” ХХК нь 10,891 мянган төгрөгийн, “Коммод” ХХК нь 14,257 мянган төгрөгийн, “Монполимет” ХХК нь 60,274 мянган

төгрөгийн, "Саусгоби сэндс" ХХК нь 11,245 мянган төгрөгийн татварыг тусгаагүй болох нь дэлгэрэнгүй мэдээллээр тодорхой болсоны дагуу залруулав.

- "Алтайн хүдэр" ХХК нь гаалийн албан татвартаа 84,967 мянган төгрөгийн, "Багануур" ХК нь 221,843 мянган төгрөгийн, "Болд төмөр ерөө гол" ХХК нь 2,884,049 мянган төгрөгийн, "Бэрэн групп" ХХК нь 16,773 мянган төгрөгийн "Доншен" ХХК нь 5,361 мянган төгрөгийн, "Кожеговь" ХХК 36,464 мянган төгрөгийн, "Монэнко" ХХК 575,392 мянган төгрөгийн, "Шижир алт" ХХК 122,984 мянган төгрөгийн НӨАТ-ыг тус тус оруулж тайлагнасан тул хасч тохируулсан.
- "АУМ" ХХК нь 26,481 мянган төгрөгөөр, "Гацуурт" ХХК нь 385,254 мянган төгрөгөөр тус тус дутуу тайлагнасан болох нь дэлгэрэнгүй мэдээллээр тодорхой болсоны дагуу залруулав.

1.3 Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар (ЗБҮӨАТ)

Үзүүлэлт	Анхны нэгтгэлийн зөрүүнүүд, цэвэр мян.төг	ТОхируулагдсан байдал		Тохируулгын дараах шийдэгдээгүй зөрүүнүүд, цэвэр мян.төг
		Засгийн газрын байгууллагууд мян.төг	Компаниуд мян.төг	
Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	9,064,800	185,650,852	185,650,852	-

ЗБҮӨАТ-ын анхны зөрүүнд хийгдсэн томоохон залруулгуудыг дурьдвал:

- ҮТЕГ нь анхны тайландаа "Монголросцветмет" ХХК-ийн ЗБҮӨАТ-ын илүү төлөлтөөс ААНОАТ-ын дутуу төлөлтөд шилжүүлэн тооцсон дүнг давхардуулан тусгасан байна.
- "Олон овоот гоулд" ХХК-иас төлсөн татварыг ҮТЕГ анхны тайландаа хүлээн авсан тухайгаа тусгаагүй ба нэгтгэлийн явцад татварын газраас ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээлэлд тусгагдаж ирсэнээр тохируулсан.
- "Уян ган" ХХК нь анхны тайландаа уг татварыг төлөлтөөр нь бус ногдуулалтаар нь тусгасан байна. /Өөрөөр хэлбэл мөнгөн сууриар бус аккруэл сууриар тусгасан байна./
- "Цогт онон" ХХК нь анхны тайландаа төлсөн татвараа дутуу тусгасан нь нэгтгэл тайлангийн явцад компаниас ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээллээр нотлогдсон.
- "Бумбат", "Монполимет", "Чайлдсан", "Сүйхэнт", "Эс Би Эф" зэрэг компаниуд нь 2009 оны тайлангаа ОУИТБСанаачлагын ажлын албанд гаргаж өгөөгүй ба нэгтгэл тайлангийн үед гаргаж өгсөн.
- "Эрдэнэт үйлдвэр" ХХК нь анхны тайландаа НӨАТ-ын илүү төлөлтөөс шилжүүлэн тооцсон дүнг тусгаагүй, харин ҮТЕГ анхны тайландаа суутган тооцсон дүнг тусгаж өгсөн байна.
- "Алтай гоулд" ХХК нь анх тайланд тусгахдаа 22,608 мянган төгрөгөөр, "Булгангангат" ХХК нь 10,057 мянган төгрөгөөр, "Заамарын их алт" ХХК нь 4,153 мянган төгрөгөөр илүү тусгасан ба нэгтгэлийн явцад компаниас ирсэн дэлгэрэнгүй мэдээллийн дагуу хасч тохируулгыг хийсэн.
- "Бэрх Уул" ХХК нь 29,773 мянган төгрөгөөр, "Гацуурт" ХХК нь 2,018,416 мянган төгрөгөөр, "Гурван төхөм" ХХК нь 65,712 мянган төгрөгөөр анхны тайландаа дутуу, "Монголболгаргео" ХХК нь 34,656 мянган төгрөгөөр илүү тусгасан ба нэгтгэл тайлангийн явцад компаниас ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээллийн дагуу тохируулгыг хийсэн.
- "Доншен" ХХК нь газрын тосны олборлолт хийдэг боловч энэхүү татвар /алтны олборлолт хийдэг компани төлдөг татвар/ дээр 32,301 мянган төгрөгийг андуурч тусгаснаас анхны зөрүү үүссэн. Компани нь ирүүлсэн мэдээлэлдээ орчуулгын алдаанаас болж буруу дүнг тайланд тусгасан болохоо тайлбарласан тул, уг дүнг хасч, залруулсан.

1.4 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар (ҮХЭХАТ)

Үзүүлэлт	Анхны нэгтгэлийн зөрүүнүүд, цэвэр мян.төг	Тохируулагдсан байдал		Тохируулгын дараах шийдэгдээгүй зөрүүнүүд, цэвэр мян.төг
		Засгийн газрын байгууллагууд мян.төг	Компаниуд мян.төг	
Үл хөдлөх эд хөрөнгийн татвар	(368,745)	2,812,561	2,812,561	-

ҮХЭХАТ-ын анхны зөрүүнд хийгдсэн томоохон залруулгуудыг дурьдвал:

- “Монголросцветмет”, “Тунсинь”, “Эрдэнэт үйлдвэр”, “Эрэл”, зэрэг компаниуд нь анхны тайландаа уг татварыг төлсөн тухайгаа тусгасан боловч УТЕГ хүлээн авсан тухайгаа тусгаагүй байна. Эдгээр компаниуд нь Орхон, Дархан-Уул, Хэнтий, Дорноговь зэрэг аймгуудын төсөвт төлсөн ба нэгтгэл тайлангийн үед тус аймгууд руу албан бичиг илгээж хариуг хүлээн авч зохих тохируулгыг хийсэн.
- “Бумбат”, “Одод”, “Шарын гол”, “Эмээлт майнз” зэрэг компаниуд нь 2009 оны тайлангаа ОУИТБСанаачлагын ажлын албанд гаргаж өгөөгүй ба нэгтгэл тайлангийн үед гаргаж өгсөн.
- “Шивээ овоо” ХХК нь 2009 оны эцэст төлсөн татвараа анхны тайландаа тусгаж ирүүлсэн байна. Уг татвар нь он дамжиж төсөвт орсон учраас компанийн дүнгээс хасч тохируулсан.
- “Болд төмөр ерөө гол” ХХК нь анх тайландаа 4,737 мянган төгрөгөөр дутуу тусгасан болох нь дэлгэрэнгүй мэдээллээр тодорхой болсоны дагуу тохируулсан.
- “Бэрх Уул” ХХК нь тайландаа 1,359 мянган төгрөгөөр, “Монголчехметалл” ХХК нь 10,359,8 мянган төгрөгөөр илүү тайлагнасан болохоо дэлгэрэнгүй мэдээллээрээ ирүүлсэний дагуу хасч тохируулсан.
- “Шижир алт” ХХК нь анхны тайландаа 23,000 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна. Тус компани нь уг дүнг нэгтгэл тайлангийн явцад ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээлэлдээ “Түшиг даатгал” компанид төлсөн хөрөнгийн даатгалын дүнг оруулж тусгасан тухайгаа тайлбар ирүүлсэнээр зөрүүг хасч, залруулсан.

1.5 Онцгой албан татвар (шатах тослох материал импортолсон бол)

Үзүүлэлт	Анхны нэгтгэлийн зөрүүнүүд, цэвэр мян.төг	Тохируулагдсан байдал		Тохируулгын дараах шийдэгдээгүй зөрүүнүүд, цэвэр мян.төг
		Засгийн газрын байгууллагууд мян.төг	Компаниуд мян.төг	
Онцгой албан татвар (шатах тослох материал импортолсон бол)	1,148,117	2,295,506	2,295,506	-

Онцгой албан татварын анхны зөрүүнд хийгдсэн томоохон залруулгуудыг дурьдвал:

- “Монголросцветмет”, “Монголын алт корпораци”, “Петро чайна дачин тамсаг” зэрэг компаниуд нь уг татварыг анхны тайландаа тусгаагүй ба нэгтгэл тайлангийн явцад дэлгэрэнгүй мэдээлэлдээ тусгаж ирүүлсэнээр тохируулгыг хийсэн.
- “Эрдэнэт үйлдвэр” ХХК нь анхны тайландаа автобензин дизелийн түлшний албан татварыг оруулж тусгасан нь нэгтгэл тайлангийн явцад ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээллээр нотлогдсон.
- “Гацуурт” ХХК нь анхны тайландаа тусгаагүйгээс 6,449 мянган төгрөгийн зөрүү үүссэнийг нэгтгэл тайлангийн явцад компаниас ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээллийн дагуу нэмж, тохируулсан.

- “Доншен” ХХК нь анх тайландаа 5,674 мянган төгрөгөөр илүү тайлагнасан ба нэгтгэл тайлангийн явцад компаниас ирсэн мэдээллийн дагуу хасч, тохируулсан.

1.6 Автобензин, дизелийн түлшний албан татвар

Үзүүлэлт	Анхны нэгтгэлийн зөрүүнүүд, цэвэр мян.төг	Тохируулагдсан байдал		Тохируулгын дараах шийдэгдээгүй зөрүүнүүд, цэвэр мян.төг
		Засгийн газрын байгууллагууд мян.төг	Компаниуд мян.төг	
Автобензин, дизелийн түлшний албан татвар	(63,387)	127,847	127,847	-

Энэ төрлийн татварын анхны зөрүүнд хийгдсэн томоохон залруулгуудыг дурьдвал:

- “Петро чайна дачин тамсаг” ХХК нь уг татварыг анхны тайландаа шатах тослох материалын онцгой албан татварын дүнг оруулж тусгасан нь нэгтгэл тайлангийн явцад ирүүлсэн нэмэлт мэдээллээр нотлогдсон.
- “Эрдэнэт үйлдвэр” ХХК нь анхны тайландаа шатах тослох материалын онцгой албан татварын дүнд оруулж тусгасан нь нэгтгэл тайлангийн явцад ирүүлсэн нэмэлт мэдээллээр нотлогдсон.
- “Доншен” ХХК нь анх тайландаа огт тусгаагүй байснаас 1,379 мянган төгрөгийн зөрүү үүссэн ба нэгтгэл тайлангийн явцад компаниас ирүүлсэн мэдээллийн дагуу нэмж, тохируулсан.

1.7 Автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар

Үзүүлэлт	Анхны нэгтгэлийн зөрүүнүүд, цэвэр мян.төг	Тохируулагдсан байдал		Тохируулгын дараах шийдэгдээгүй зөрүүнүүд, цэвэр мян.төг
		Засгийн газрын байгууллагууд мян.төг	Компаниуд мян.төг	
Автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар	(9,528)	201,284	201,284	-

Энэ төрлийн татварын анхны зөрүүнд хийгдсэн томоохон залруулгуудыг дурьдвал:

- “Монголросцветмет”, “Хангад эксплорэйшн”, “Эрэл” зэрэг компаниуд нь анхны тайландаа уг татварыг төлсөн тухайгаа тусгасан боловч УТЕГ хүлээн авсан тухайгаа тусгаагүй байна. Эдгээр компаниуд нь Дархан-Уул, Хэнтий зэрэг аймгууд болон Сүхбаатар дүүргийн төсөвт төлсөн ба нэгтгэл тайлангийн үед тус аймгууд руу албан бичиг илгээж хариуг хүлээн авч, зохих тохируулгыг хийсэн.
- “Петро чайна дачин тамсаг” ХХК нь анхны тайландаа тусгаагүй ба нэгтгэл тайлангийн явцад компаниас ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээллээр нотлогдсон.
- “Энержи ресурс” ХХК нь анхны тайландаа уг татварыг илүү тусгасан ба нэгтгэл тайлангийн явцад компаниас ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээллээр нотлогдсон.
- “Гацуурт” ХХК нь анхны тайландаа тусгаагүйгээс 7,447 мянган төгрөгийн зөрүү үүссэнийг компаниас ирсэн дэлгэрэнгүй мэдээллийн дагуу нэмж, залруулав.
- “Гоби коул энд энержи” ХХК нь анх тайлагнасан дүнгээ дэлгэрэнгүй мэдээллээрээ баталгаажуулсан ба УТЕГ-аас анх тайлагнахдаа 1,779 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан болох нь нэгтгэл тайлангийн явцад ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээллийн дагуу ЗГ талд нэмж, тохируулсан.
- “Доншен” ХХК нь анхны тайландаа 3,268 мянган төгрөгөөр дутуу тусгасан болох нь дэлгэрэнгүй мэдээлэлдээ ирүүлсэний дагуу компани талд, залруулсан.

- “Монгол газар”, “Монполимет” зэрэг компаниуд нь 2009 оны тайлангаа ОУИТБСанаачлагын ажлын албанд гаргаж өгөөгүй ба нэгтгэл тайлангийн үед гаргаж өгсөн.

2. Төлбөрүүд

Анхлан ирүүлсэн маягтууд дахь төлбөрүүд хэсгийн зөрүүнүүд болон нэгтгэлийн үр дүнд ЗГ-ын нэгж байгууллагууд, компаниудаас ирүүлсэн дүнд хийсэн залруулгуудыг дараахи байдлаар харуулав. Үүнд:

Үзүүлэлт	Анхны нэгтгэлийн зөрүүнүүд, цэвэр мян.төг	Тохируулагдсан байдал		Тохируулгын дараах шийдэгдээгүй зөрүүнүүд, цэвэр мян.төг
		Засгийн газрын байгууллагууд мян.төг	Компаниуд мян.төг	
2.1 Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	17,078,028	105,319,548	105,319,548	-
2.2 Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	(8,910,088)	9,082,332	9,082,332	-
2.3 Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр /доллар/	4,993,390	2,399,427	2,399,427	-
2.4 Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр	358,941	1,762,518	1,762,518	-
2.5 Газрын төлбөр	(11,302,525)	12,057,815	12,057,815	-
2.6 Ус, рашаан ашигласны төлбөр	(450,624)	2,383,477	2,383,477	-
2.7 Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр	(4,648)	4,389	4,389	-
2.8 Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр	(757,202)	4,208,271	4,210,251	(1,980)
2.9 Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	(982,645)	1,050,223	1,050,223	-
2.10 Бусад	-	-	-	-
Нийт	22,627	138,267,999	138,269,979	(1,980)

2.1 Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (“роялти төлбөр”)

Үзүүлэлт	Анхны нэгтгэлийн зөрүүнүүд, цэвэр мян.төг	Тохируулагдсан байдал		Тохируулгын дараах шийдэгдээгүй зөрүүнүүд, цэвэр мян.төг
		Засгийн газрын байгууллагууд мян.төг	Компаниуд мян.төг	
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (“роялти төлбөр”)	17,078,028	105,319,548	105,319,548	-

АМНАТ-ийн анхны зөрүүнд хийгдсэн томоохон залруулгуудыг дурьдвал:

- “Адамас Майнинг” ХХК нь анхны тайландаа тусгаагүйгээс зөрүү үүссэн. Компаниас ирсэн дэлгэрэнгүй мэдээллийн дагуу компани талд 19,162 мянган төгрөгийн нэмж, залруулсан.
- “Адил-Оч” ХХК нь 16,281 мянган төгрөгөөр, “Заамарын их алт” ХХК нь 29,659 мянган төгрөгөөр, “Анхай интернэшнл” ХХК нь 10,695 мянган төгрөгөөр дутуу тусгасанаа хүлээн зөвшөөрсөн дэлгэрэнгүй мэдээлэл ирүүлсэний дагуу компани талд нэмж, залруулав.
- “Адуунчулуун” ХХК-иас УТЕГ анх 55,520 мянган төгрөгийн төлбөрийг хүлээн авсан гэж тусгасан байсан. Нэгтгэл тайлангийн явцад гаргаж ирүүлсэн мэдээлэлдээ мэдээллийн баазад орон

- андуурч шивсэн, тус компаниас 52,250 мянган төгрөгийн төлбөр хүлээн авсан гэж залруулж ирүүлсэний дагуу ЗГ талаас 3,270 мянган төгрөгийн хасч, тохируулгыг хийсэн.
- “Булгангангат” ХХК-иас төлсөн 78,719 мянган төгрөгийн төлбөрийг УТЕГ анхны тайландаа дутуу тусгасан байсныг нэгтгэл тайлангийн явцад УТЕГ-аас ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээллийн дагуу ЗГ талд нэмж залруулав.
 - “Гурван төхөм” ХХК нь ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээллээрээ анх тайлагнасан дүнгээ зөв гэдгээ баталгаажуулсан ба УТЕГ-аас ирсэн мэдээллээр илүү буюу буруу тайлагнасан болох нь тогтоогдсоны дагуу ЗГ талд 13,461 мянган төгрөгийг хасч залруулсан.
 - “Доншен” ХХК нь тайланд анх тусгахдаа андуурч буруу тайлагнаснаас 3,374,831 мянган төгрөгийн анхны зөрүү үүссэн. Компаниас ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээлэлд андуурч буруу дүн тусгасан гэж мэдэгдсэний дагуу компани талд хасч залруулсан.
 - ЗГ анхны тайландаа орон нутагт төлсөн төлбөрийг тусгаагүйгээс анхны зөрүү үүссэн ба нэгтгэл тайлангийн явцад Хэнтий, Дорноговь аймгуудаас дэлгэрэнгүй мэдээлэл ирүүлсэний дагуу “Монголросцветмет” “Шивээ овоо” зэрэг компаниудын зөрүүг шийдвэрлэж, зохих залруулгыг хийсэн.
 - “Монголын алт корпораци” “Уян ган” “Флинк монголия” “Цайрт минерал” “Цогт онон”, “Цэвдэг”, “Чинхуа Мак нарийн сухайт” “Поло ресорсез” “Хоту”, “Шижир талст” “Эрдэнэт үйлдвэр” зэрэг компаниудаас улс болон орон нутгийн төсөвт төлсөн төлбөрийг УТЕГ давхардуулж тусгасан байна. Мөн “Цайрт минерал” ХХК нь анхны тайландаа 2008 оны эцэст төлсөн 360,660 мянган төгрөгийн он дамжсан төлбөрийг тусгаагүй байна.
 - УТЕГ “Таван толгой” ХХК-иас орон нутгийн төсөвт төлсөн төлбөрийг давхардуулж тусгасан ба компани нь анхны тайландаа 2009 оны 12 сарын 29-нд төлсөн татварыг тусгаагүй байна.
 - “Тунсинь”, “Эрэл” зэрэг компаниудаас орон нутгийн төсөвт төлсөн төлбөрийг УТЕГ анхны тайландаа тусгаагүй ба нэгтгэл тайлангийн явцад Хэнтий, Дорноговь, Дархан-Уул аймгуудын ЗДТГ-аас ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээлэлд үндэслэн залруулсан.
 - “Бумбат”, “Чайлдсан”, “Шарын гол” “Эм Жи Эйч”, “Эс Би Эф” зэрэг компаниуд нь 2009 оны тайлангаа ОУИТБСанаачлагын ажлын албанд гаргаж өгөөгүй ба нэгтгэл тайлангийн үед гаргаж өгсөн.
 - “Энержи ресурс” ХХК нь анхны тайландаа ногдуулалтаараа тусгасан байна.
 - “Эрвэн хүдэр” ХХК нь анхны тайландаа тус төлбөрийг хугацаандаа төлөөгүйн улмаас татварын хяналт шалгалтын актаар тавигдсан торгуулийн дүнг тусгасан учраас хасч тохируулгыг хийсэн.

2.2 Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр (төгрөг)

Үзүүлэлт	Анхны нэгтгэлийн зөрүүнүүд, цэвэр мян.төг	Тохируулагдсан байдал		Тохируулгын дараах шийдэгдээгүй зөрүүнүүд, цэвэр мян.төг
		Засгийн газрын байгууллагууд мян.төг	Компаниуд мян.төг	
Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	(8,910,088)	9,082,332	9,082,332	-

Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийн анхны зөрүүнд хийгдсэн томоохон залруулгуудыг дурьдвал:

- Энэ төлбөрийг Ашигт малтмалын газар ам.доллароор тайланд тусгаж, компаниуд төлсөн төлбөрөө тайландаа Монголбанкны ханшаар төгрөгт хөрвүүлэн тайлагнасныг залруулсан.
- Мөн ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийг эзэмшигч компаниуд өөр компанид худалдан борлуулсан, шилжүүлсэн тохиолдолд авсан компани нь өөрийн нэрээр лицензийн төлбөрийг төлөлгүй хуучин компанийн нэрээр төлбөр төлөгдсөнөөр компанийн дүн бага АМГ-

- аас ирүүлсэн мэдээллийн дүн их байгаа нь зөрүү үүсгээд байгааг хоёр талаас ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээлэлд үндэслэн залруулгыг хийсэн.
- Адамас Майнинг”, “Алтайн хүдэр”, “АУМ”, “Анхай интернэшнл”, “Баян айраг эксплорэйшн”, “Баян эрч”, “Бороо голд”, “Бэрэн групп”, “Гацуурт”, “Гоби коул энд энерги”, “Дацан трейд”, “Коммод”, “Сентерра Гоулд”, “Сонор Трейд” зэрэг компаниуд нь бүх төлсөн төлбөрөө маягтынхаа дагуу ам.доллараар төлбөрөө төгрөгөөр хөрвүүлэн илэрхийлсэн, ЗГ талаас “төлбөр доллар” гэсэн мөр нэмж оруулан доллароор илэрхийлсэнээс зөрүү үүссэнийг 2 талаас ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээллийн дагуу залруулав.
 - “Аниан ресорсиз”, “Бумбат”, “Монгол газар”, “Монгол цамхаг”, “Вестерн проспектор групп” зэрэг компаниуд нь ОУИТБС-ын тайлангаа өгөөгүйгээс анхны зөрүү үүссэн ба нэгтгэл тайлангийн явцад санаачлагын тайланг ирүүлсэн тул залруулгыг хийсэн.
 - “Болд төмөр ерөө гол” ХХК нь анх тайлагнахдаа төгрөгөөр илэрхийлсэн ба дүнгээ дэлгэрэнгүй мэдээллээрээ баталгаажуулсан ба ЗГ талаас 21,090 долларын төлбөрийг дутуу тусгасан байсан нь дэлгэрэнгүй мэдээллээр тодорхой болсоны дагуу ЗГ талд нэмж залруулсан.
 - “Булгангангат”, “Бэрх Уул”, зэрэг компаниуд нь анх тайланд тусгахдаа буруу буюу илүү тусгасанаа дэлгэрэнгүй мэдээлэлд тусгаж ирүүлсэн тул компани талд хасч, залруулсан.
 - “Бүүргэнт” ХХК нь анх тайланд тусгахдаа буруу буюу дутуу тусгаснаа дэлгэрэнгүй мэдээллээрээ ирүүлсэний дагуу компани талд нэмж, залруулсан.
 - “Саусгоби Сэндс” ХХК нь анхны тайландаа уг төлбөрт төлсөн дүнг 3,121,954 мянган төгрөгөөр тайлагнасан ба дэлгэрэнгүй мэдээлэлдээ “Айвенхоу майнз Монголия инк” компанийн эзэмшлийн 4010Х, 4012Х лицензийн төлбөрийг тусгаж ирүүлсэн байгааг компанийн нягтлан бодогчоос дахин тодруулж, 433,462 мянган төгрөгийн төлбөрийг хасч, тохируулсан. Харин АМГ дэлгэрэнгүй мэдээлэлдээ хүлээн авсан төлбөрөө нэмж тусгаж өгсөн тул ЗГ талд 1,551,551 мянган төгрөгийг нэмж, тохируулсан.
 - “Кожеговь” ХХК нь дэлгэрэнгүй мэдээлэлдээ лицензийн төлбөрийг дүнд үйлчилгээний хөлс оруулан 217,045 мянган төгрөгөөр ирүүлсэн бол АМГ-аас ирүүлсэн мэдээллээр 192,729 мянган төгрөг нь лицензийн төлбөр, 24,316 мянган төгрөг нь үйлчилгээний хөлс гэж тусгаж өгсөнөөр зохих залруулгыг хийсэн.
 - “МОНЭНКО” ХХК нь доллараар илэрхийлэгдэх төлбөрөө тухайн үеийн ханшаар төгрөгт шилжүүлж, нийт төлбөрийг төгрөгөөр илэрхийлсэн байснаас үүдэн анхны зөрүү болох 1,116,814 мянган төгрөгийн зөрүү үүссэн байна. АМГ болон компанийн дэлгэрэнгүй мэдээллийн дагуу зохих залруулгыг хийсэн боловч зөрүү үүссэн. Зөрүүг шийдвэрлэх зорилгоор АМГ-т хандахад тус компанийн дэлгэрэнгүй мэдээлэлд тусгагдсан 7560х, 7559х лиценз нь “Эм Өү Өү Ай Си Өү” компанийн эзэмшлийнх, харин 11515х лицензийг АМГ-т өөрийн компанийн нэр дээр бүртгүүлээгүй байгаагаас шалтгаалсан тухай тайлбар өгсөний дагуу 519,608 мянган төгрөгийн залруулгыг 2 талд хийж, шийдвэрлэсэн.

2.3 Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр (ам.доллар)

Үзүүлэлт	Анхны нэгтгэлийн зөрүүнүүд, цэвэр мян.доллар	Тохируулагдсан байдал		Тохируулгын дараах шийдэгдээгүй зөрүүнүүд, цэвэр мян.доллар
		Засгийн газрын байгууллагууд мян.доллар	Компаниуд мян.доллар	
Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр /доллар/	4,993,390	2,399,427	2,399,427	-

- Энэ төлбөрийг АМГ доллараар тайлагнасан бол ихэнх компаниуд төгрөгөөр тайлагнасан.

2.4 Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр

Үзүүлэлт	Анхны нэгтгэлийн зөрүүнүүд, цэвэр мян.төг	Тохируулгын байдал		Тохируулгын дараах шийдэгдээгүй зөрүүнүүд, цэвэр мян.төг
		Засгийн газрын байгууллагууд мян.төг	Компаниуд мян.төг	
Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр	358,941	1,762,518	1,762,518	-

Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөрийн анхны зөрүүнд хийгдсэн томоохон залруулгуудыг дурьдвал:

- “Баян эрч” ХХК-ийн анхны нэгтгэл дээр үүссэн зөрүү нь доллароор төлсөн ба тайланд тусгахдаа төгрөгөөр илэрхийлсэнээс зөрүү үүссэнийг тохируулсан.
“Доншен” ХХК нь Газрын тосны газарт шилжүүлдэг бүтээгдэхүүн хуваах гэрээний төлбөрт төлсөн дүнгээ энд давхардуулж тайлагнаснаа хүлээн зөвшөөрсөний дагуу хасч, залруулав.
- “Их тохойрол” ХХК нь ОУИТБС-ын 2009 оны тайлангаа гаргаж өгөөгүйгээс 98,271 мянган төгрөгийн анхны зөрүү үүссэн. Компаниас ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээлллийн дагуу компани талд нэмж тохируулсан.
- “Таван толгой”, “Шанлун” зэрэг компаниуд нь тус төлбөрийг төлсөнөө, “Тунсинь”, “Эрдэс холдинг” зэрэг компаниудаас төлсөн төлбөрийг АМГ хүлээн авсанаа анхны тайландаа тусгаагүй байна.
- “Шарын гол” ХК 2009 оны тайлангаа ОУИТБС-ын ажлын албанд гаргаж ирүүлээгүй ба энэ компаниас тайланг нэгтгэлийн явцад гаргуулан авсанаар залруулга хийгдсэн.
- “Шинь Шинь” ХХК нь анхны тайландаа илүү тусгасан нь нэгтгэл тайлангийн явцад гаргаж ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээллээр нотолсон тул хасч, залруулсан.
- “Эрэл” ХХК нь анхны тайландаа дутуу тусгасан нь нэгтгэл тайлангийн явцад ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээллээр нотлогдсон.

2.5 Газрын төлбөр

Үзүүлэлт	Анхны нэгтгэлийн зөрүүнүүд, цэвэр мян.төг	Тохируулагдсан байдал		Тохируулгын дараах шийдэгдээгүй зөрүүнүүд, цэвэр мян.төг
		Засгийн газрын байгууллагууд мян.төг	Компаниуд мян.төг	
Газрын төлбөр	(11,302,525)	12,057,815	12,057,815	-

Газрын төлбөрийн анхны зөрүүнд хийгдсэн томоохон залруулгуудыг дурьдвал:

- “Адил оч” ХХК нь анх тайлагнахдаа 576 мянган төгрөгөөр, “Баялаг жонш” ХХК нь 160 мянган төгрөгөөр илүү буюу буруу тусгаснаа хүлээн зөвшөөрсөн мэдээлэл ирүүлсэний дагуу тохируулга хийж зөрүүг шийдвэрлэсэн.
- “АФК тавт” ХХК нь ОУИТБС-ын 2009 оны тайлангаа өгөөгүйгээс анхны зөрүү үүссэн ба компаниас мэдээлэл ирсэний дагуу компани талд нэмж тохируулга хийж зөрүүг, шийдвэрлэсэн.
- “Булгангангат” ХХК нь 500 мянган төгрөгөөр, “Дун-эрдэнэ” ХХК нь 1,000 мянган төгрөгөөр дутуу тайлагнаснаа хүлээн зөвшөөрсөн дэлгэрэнгүй мэдээлэл ирүүлсэний дагуу компани талд нэмж залруулга хийсэн. Мөн “Булгангангат” ХХК-иас төлсөн 2,960 мянган төгрөгийн төлбөрийг ҮТЕГ тусгаагүй байна. Уг төлбөр нь Төв аймгийн ЗДТГ-т төлсөн дүн учраас тус аймаг руу албан бичиг хүргүүлж, хариу ирсэний дагуу ҮТЕГ-ын дүнг нэмж тохируулга хийснээр зөрүүг шийдвэрлэсэн.
- “Доншен” ХХК нь Газрын тосны газарт төлбөрөө төлсөн ба ОУИТБС-ын тайланд тусгахдаа доллараар төлсөнөө төгрөгөөр илэрхийлсэн байна. Иймээс бүртгэлдээ өөр өөр ханшаар бүртгэснээс зөрүү үүсэхээс сэргийлж төгрөгийг доллараар тохируулсантай холбоотойгоор

- компани талд 23,945 мянган төгрөгийг хасч тохируулсан байна. Газрын тосны газраас хариу ирсэний дагуу үүсээд байсан 53,210 долларын зөрүүг ЗГ талд тохируулж зөрүүг шийдвэрлэсэн.
- “Петро чайна дачин тамсаг” ХХК-иас хүлээн авсан 365,440 мянган төгрөгийн төлбөрийг Газрын тосны газар анхны тайландаа тусгаагүй ба нэгтгэл тайлангийн явцад ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээлэлд үндэслэн залруулгыг хийсэн.
 - “Эрдэнэт үйлдвэр” ХХК-иас Орхон аймагт төлсөн төлбөрийг УТЕГ анхны тайландаа тусгаагүй ба нэгтгэл тайлангийн явцад Орхон аймгаас тодруулга ирж зөрүү шийдвэрлэгдсэн. Уг төлбөрийн 8,170,000 мянган төгрөгийг шилжүүлгээр (мөнгөөр), 2,012,763 мянган төгрөгийг ДЦС-ын алдагдалд суутган тооцсон байна.

Дараах компаниудаас зарим аймаг, нийслэл, сум, дүүргийн газрын алба болон татварын газруудад төлсөн төлбөрүүдийг УТЕГ дараах компаниудтай холбоо бүхий анхны тайландаа оруулж тайлагнаагүй байна. Үүнд:

№	Компанийн нэр	Төлбөр хүлээн авсан байгууллага
1	“Анхай интернэйшнл” ХХК	Төв аймаг
2	“Алтай гоулд” ХХК	Архангай аймаг
3	“Алтайн хүдэр” ХХК	Говь-Алтай аймгийн Цээл сум
4	“Багануур” ХК	Багануур дүүрэг
5	“Баян эрч” ХХК	Сүхбаатар аймаг
6	“Бороо гоулд” ХХК	Сэлэнгэ аймаг Мандал, Баянгол
7	“Буд инвест” ХХК	Төв аймаг
8	“Бүүргэнт” ХХК	Сэлэнгэ аймаг
9	“Бэрх уул” ХХК	Хэнтий аймгийн Нровлин сум
10	“Гацуурт” ХХК	Булган аймгийн Сэлэнгэ сум, Дархан-Уул аймаг
11	“Гуравт” ХХК	Дархан-Уул аймаг, Хонгор сум
12	“Гоби коул энд энержи” ХХК	Баянхонгор аймаг Шинэжинст сум
13	“Дацан трейд” ХХК	Увс аймаг Тариалан сум
14	“Зүрийн булан” ХХК	Дархан-Уул аймаг Хонгор сум
15	“Их монгол майнинг” ХХК	Өмнөговь аймаг
16	“Их тохойрол” ХХК	Төв аймаг
17	“Кайнар вольфрам” ХХК	Баян-Өлгийн аймаг Улаанхус, Ногооннуур, Цэнгэл
18	“Монголын алт корпораци” ХХК	Дорноговь
19	“Монголросцветмет” ХХК	Хэнтий, Дорноговь, Дундговь, Нийслэлийн
20	“Монголчех металл” ХХК	Төв аймаг
21	“Монполимет” ХХК	Булган аймаг
22	“Олон овоот” ХХК	Өмнөговь аймаг
23	“Өрмөн уул” ХХК	Булган аймгийн Бүрэгхангай
24	“Поло ресорсез” ХХК	Төв, Булган
25	“Саусгоби сэндс” ХХК	Өмнөговь аймаг
26	“Сүйхэнт” ХХК	Төв аймаг
27	“Тунсинь” ХХК	Хэнтий
28	“Уулс заамар” ХХК	Төв аймгийн Заамар
29	“Уулс ноён” ХХК	Дархан-Уул аймгийн Хонгор
30	“Хан шижир” ХХК	Баянхонгор аймгийн Бөмбөгөр сум
31	“ХОТУ” ХХК	Төв аймгийн Заамар
32	“Хурай” ХХК	Сэлэнгэ аймаг, Нийслэл
33	“Цогт онон” ХХК	Төв аймаг
34	“Цэвдэг” ХХК	Төв аймаг
35	“Шижиер алт” ХХК	Булган аймгийн Бүрэгхангай сум, Төв аймаг
36	“Энержи ресурс” ХХК	Өмнөговь аймаг

№	Компанийн нэр	Төлбөр хүлээн авсан байгууллага
37	"Эрдэнэт үйлдвэр" ХХК	Орхон аймаг
38	"Эрдэс холдинг" ХХК	Сэлэнгэ аймаг, Нийслэл
39	"Эрэл" ХХК	Дорноговь, Дархан-Уул, Нийслэл

2.6 Ус, рашаан ашигласны төлбөр

Үзүүлэлт	Анхны нэгтгэлийн зөрүүнүүд, цэвэр мян.төг	Тохируулагдсан байдал		Тохируулгын дараах шийдэгдээгүй зөрүүнүүд, цэвэр мян.төг
		Засгийн газрын байгууллагууд мян.төг	Компаниуд мян.төг	
Ус, рашаан ашигласны төлбөр	(450,624)	2,383,477	2,383,477	-

Ус, рашаан ашигласны төлбөрийн анхны зөрүүнд хийгдсэн томоохон залруулгуудыг дурьдвал:

- "Адил оч" ХХК нь анх тайланд буруу дүнгээр тусгаснаа хүлээн зөвшөөрсөн мэдээлэл ирүүлсэний дагуу компани талаас хасч, залруулсан.
- "АУМ" ХХК нь анхны тайландаа 13,000 мянган төгрөгөөр, "Дун эрдэнэ" ХХК нь 1,000 мянган төгрөгөөр дутуу тусгасан ба нэгтгэл тайлангийн явцад ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээллийн дагуу компани талд нэмж, тохируулсан.
- "Бумбат", "Сүйхэнт" зэрэг компаниуд нь 2009 оны тайлангаа ОУИТБСанаачлагын ажлын албанд гаргаж өгөөгүй ба нэгтгэл тайлангийн үед гаргаж өгсөн тул залруулагдсан.
- "Буд инвест", "Гацуурт", "Дацан трейд", "Зүрийн булан", "Монголросцветмет", "Үүрт гоулд", "Хан шижир", "Хурай", "Шижир талст" зэрэг компаниуд нь усны хэмнэлтийн төвд төлсөн үйлчилгээний хөлсийг уг төлбөрийн дүнд оруулж тайлагнасан.
- "Булгангангат", "Доншен", "Уян ган" зэрэг компаниуд нь анхны тайландаа уг төлбөрийг илүү тайлагнасан ба нэгтгэл тайлангийн явцад дэлгэрэнгүй мэдээлэлдээ илүү тусгасан дүнг хасч ирүүлсэн тул зохих залруулгыг хийсэн.

Дараах компаниудаас зарим аймаг, нийслэл, сум, дүүргийн татварын албанд төлсөн төлбөрүүдийг УТЕГ дараах компаниудтай холбоо бүхий анхны тайландаа оруулж тайлагнаагүй байна. Үүнд:

№	Компанийн нэр	Төлбөр хүлээн авсан байгууллага
1	"Анхай интернэйшнл" ХХК	Төв аймаг Баянжаргалан
2	"Алтай гоулд" ХХК	Архангай аймаг
3	"Алтайн хүдэр" ХХК	Говь-Алтай аймгийн Цээл сум
4	"Адамас майнинг" ХХК	Баян-Өлгий аймгийн Баяннуур сум
5	"Баян эрч" ХХК	Сүхбаатар аймаг
6	"Бороо гоулд" ХХК	Сэлэнгэ аймаг Мандал сум
7	"Бүүргэнт" ХХК	Сэлэнгэ аймаг
8	"Бэрх уул" ХХК	Хэнтий аймаг Норовлин сум
9	"Гацуурт" ХХК	Өвөрхангай Бат-Өлзий сум
10	"Гуравт" ХХК	Дархан-Уул аймаг
11	"Гурван төхөм" ХХК	Төв аймгийн Сэргэлэн сум
12	"Дацан трейд" ХХК	Увс аймаг Тариалан
13	"Заамарын их алт" ХХК	Төв аймаг
14	"Зүрийн булан" ХХК	Дархан-Уул аймаг Хонгор сум
15	"Их монгол майнинг" ХХК	Өмнөговь аймаг
16	"Цайрт минерал" ХХК	Сүхбаатар аймаг Асгат, Сүхбаатар сум
17	"Монголросцветмет" ХХК	Хэнтий аймаг
18	"Монполимет" ХХК	Төв аймаг
19	"Нордвинд" ХХК	Хэнтий аймгийн Галшар сум

№	Компанийн нэр	Төлбөр хүлээн авсан байгууллага
20	"Олон овоот" ХХК	Өмнөговь аймаг
21	"Өрмөн уул" ХХК	Булган аймаг Бүрэгхангай сум
22	"Петро чайна дачин тамсаг" ХХК	Дорнод аймаг Матад сум
23	"Поло ресорсез" ХХК	Дорноговь аймаг Алтанширээ, Иххэт сум
24	"Сүйхэнт" ХХК	Төв аймаг Сэргэлэн
25	"Тунсинь" ХХК	Хэнтий аймаг
26	"Уулс ноён" ХХК	Дархан-Уул аймаг Хонгор сум
27	"Хан шижир" ХХК	Дархан-Уул аймаг Хонгор сум, Баянхонгор аймаг
28	"Хангад эксплорэйшн" ХХК	Өмнөговь аймаг
29	"Цэвдэг" ХХК	Төв аймаг
30	"Хурай" ХХК	Сэлэнгэ аймаг
31	"Чайлдсан" ХХК	Төв аймаг
32	"Шижир алт" ХХК	Булган аймгийн Бүрэгхангай сум
33	"Энержи ресурс" ХХК	Өмнөговь аймаг
34	"Эрдэнэт үйлдвэр" ХХК	Булган аймаг
35	"Эрдэс холдинг" ХХК	Сэлэнгэ аймаг, Налайх дүүрэг

2.7 Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр

Үзүүлэлт	Анхны нэгтгэлийн зөрүүнүүд, цэвэр мян.төг	Тохируулагдсан байдал		Тохируулгын дараах шийдэгдээгүй зөрүүнүүд, цэвэр мян.төг
		Засгийн газрын байгууллагууд мян.төг	Компаниуд мян.төг	
Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр	(4,648)	4,389	4,389	-

Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн анхны зөрүүнд хийгдсэн томоохон залруулгуудыг дурьдвал:

- "Эрдэс холдинг" ХХК-иас төлсөн төлбөрийг УТЕГ анхны тайландаа тусгаагүй ба Сэлэнгэ аймгаас ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээлэлд үндэслэн залруулсан.
- "АФК тавт" ХХК нь нь 2009 оны тайлангаа ОУИТБСанаачлагын ажлын албанд гаргаж өгөөгүй ба нэгтгэл тайлангийн үед гаргаж өгсөн тул залруулагдсан.
- "Гацуурт" ХХК нь анхны тайландаа буруу дүн тусгаснаа хүлээн зөвшөөрсөн мэдээлэл ирүүлсэний дагуу компани талаас хасч, зөрүүг шийдвэрлэсэн.
- "Зүбгол" ХХК-ийн тайланд тусгасан 1,500 мянган төгрөгийг компаниас тодруулахад анхан шатны баримт ирсэн. Баримтанд гоожингийн үнийг хувь хүний дансанд хийсэн нь тогтоогдсоны дагуу компани талаас хасч, залруулсан.

2.8 Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр

Үзүүлэлт	Анхны нэгтгэлийн зөрүүнүүд, цэвэр мян.төг	Тохируулагдсан байдал		Тохируулгын дараах шийдэгдээгүй зөрүүнүүд, цэвэр мян.төг
		Засгийн газрын байгууллагууд мян.төг	Компаниуд мян.төг	
Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр	(757,202)	4,208,271	4,210,251	(1,980)

Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөрийн анхны зөрүүнд хийгдсэн томоохон залруулгуудыг дурьдвал:

- Компаниуд ихэвчилэн энэ төлбөрт үйлчилгээний хөлс, урилга, үнэмлэхний үнэ, тодорхойлолт гаргуулсаны хөлс зэргийг оруулж тайлагнасан.
- "Айвенхоу майнз монголия инк" (Оюу толгой), "Петро чайна дачин тамсаг", "Шанлун" зэрэг компаниуд нь анхны тайландаа визнээс өмнө буцсан ажилчны ажлын байрны төлбөрийг ХХҮГ-аас буцаан авсан дүнг оруулж тайлагнасан. Мөн ХХҮГ анхны тайландаа "Айвенхоу майнз монголия инк" (Оюу толгой) компаниас төлсөн төлбөрийг дутуу тайлагнасан ба нэгтгэлийн явцад ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээлэлд тусгаж өгсөнөөр залруулга хийгдсэн.
- "АУМ" ХХК нь анхны нэгтгэлд тусгасан дүнгээ 2 удаа баталгаажуулсаны дагуу ЗГ талаас 3,217 мянган төгрөгийг хасч, тохируулсан.
- "Бороо гоулд", "Гоби коул энд энерги" зэрэг компаниуд нь анх тайланд тусгахдаа хураамж үйлчилгээний хөлсөө оруулж тайлагнасан нь нэгтгэлийн явцад компаниас ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээллээр нотлогдсон тул хасч, тохируулав.
- "Зүрийн булан" ХХК нь Дархан аймгийн Хонгор сумын ЗДТГ-т 45,086 мянган төгрөгийг төлсөн ба энэ нь ХХҮГ-ын мэдээллийн санд нэгтгэгдээгүйгээс зөрүү үүссэн. Орон нутаг руу нь албан тоот илгээж, хариу ирсэний дагуу ЗГ-т нэмж, тохируулга хийсэн.
- "Их Монгол Майнинг" ХХК 39,866 мянган төгрөгийг тайлагнасанаас анхны зөрүү үүссэн ба компани дээр очиж ажиллахад гадаадын ажилчинд олгосон цалинг оруулж тайлагнасан болох нь тогтоогдсоны дагуу хасч, залруулсан.
- "Кожеговь" ХХК-ийн зөрүүг ХХҮГ-аас ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээлэлд үндэслэн тохируулгыг хийж, зөрүүг шийдвэрлэсэн.
- "Монголын алт корпораци", "Флинк монголия", "Шинь Шинь", "Эрэл" зэрэг компаниудаас хүлээн авсан төлбөрийг ХХҮГ анхны тайландаа дутуу тусгасан ба нэгтгэлийн явцад ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээлэлд нэмж тусгасан.
- "Цайрт минерал" ХХК-иас Сүхбаатар аймагт төлсөн төлбөрийг ХХҮГ анхны тайландаа тусгаагүй ба нэгтгэл тайлангийн явцад Сүхбаатар аймгийн ЗДТГ-аас ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээлэлд үндэслэн залруулгыг хийсэн.
- "Бэрх Уул", "Энержи ресурс" зэрэг компаниуд анхны тайландаа төлсөн төлбөрийг тусгаагүй байсан ба дэлгэрэнгүй мэдээллээр төлсөн дүнг ирүүлсэн.
- "Бумбат", "Эмээлт майнз", "Эрдэнэ монгол" зэрэг компаниуд нь 2009 оны тайлангаа ОУИТБСанаачлагын ажлын албанд гаргаж өгөөгүй ба нэгтгэл тайлангийн явцад тайланг дэлгэрэнгүй мэдээллийн хамт ирүүлсэний үндсэн дээр залруулгыг хийсэн.
- "Шижир алт" ХХК нь анх тайландаа 15,676 мянган төгрөгөөр илүү тусгасан байсан. ХХҮГ-аас ирүүлсэн мэдээллийн дагуу тохируулгыг хийсэн.

2.9 Түгээмэл тархацтай орд газрын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр

Үзүүлэлт	Анхны нэгтгэлийн нээ рүүнүүд, цэвэр	Тохируулагдсан байдал		Тохируулгын дараах шийдэгдээгүй зөрүүнүүд, цэвэр мян.төг
	мян.төг	Засгийн газрын байгууллагууд мян.төг	Компаниуд мян.төг	
Түгээмэл тархацтай орд газрын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	(982,645)	1,050,223	1,050,223	-

Түгээмэл тархацтай орд газрын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн анхны зөрүүнд хийгдсэн томоохон залруулгуудыг дурьдвал:

- "Адуунчулуун" ХХК нь дутуу тайлагнаснаа хүлээн зөвшөөрсөн мэдээлэл ирүүлсэний дагуу нэмж, залруулав.
- "Гацуурт" ХХК нь анх тайланд тусгахдаа буруу дүн тусгаснаа хүлээн зөвшөөрсөн мэдээлэл ирүүлсэний дагуу компани талаас хасч, залруулсан.

- “Уулс заамар” ХХК анхны тайландаа ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг энэ төлбөрийн хэсэгт тайлагнасан байна.
- “Шинь Шинь”, “Цайрт минерал” зэрэг компаниуд нь анхны тайландаа уг төлбөрийг илүү тусгасан ба нэгтгэл тайлангийн явцад компаниас ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээлэлд үндэслэн залруулгыг хийсэн.
- “Энержи ресурс” ХХК-иас хүлээн авсан дүнг ҮТЕГ анхны тайландаа тусгаагүй ба нэгтгэл тайлангийн явцад Өмнөговь аймгийн ЗДТГ-аас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн залруулсан.

3. Хураамжууд, үйлчилгээний шимтгэлүүд

Анхлан ирүүлсэн маягтууд дахь хураамжууд, үйлчилгээний шимтгэлүүд хэсгийн зөрүүнүүд болон нэгтгэлийн үр дүнд засгийн газрын нэгж байгууллагууд, компаниудаас ирүүлсэн дүнд хийсэн залруулгуудыг дараахи байдлаар харуулав:

Бүлэг	Анхны нэгтгэлийн зөрүүнүүд, цэвэр мян.төг	Тохируулагдсан байдал		Тохируулгын дараах шийдэгдээгүй зөрүүнүүд, цэвэр мян.төг
		Засгийн газрын байгууллагууд мян.төг	Компаниуд мян.төг	
3.1	Зохих хууль тогтоомжийн дагуу төв, орон нутгийн төрийн захиргааны байгууллагад төлсөн улсын тэмдэгтийн болон бусад хураамж (313,445)	161,666	163,787	(2,120)
3.2	Зохих хууль тогтоомжийн дагуу төв, орон нутгийн төрийн захиргааны байгууллагад төлсөн үйлчилгээний хөлс (562,175)	779,678	779,678	-
3.3	Гаалийн үйлчилгээний хураамж 1,281,913	10,303,301	10,303,301	-
Нийт	406,294	11,244,645	11,246,765	(2,120)

а. Зохих хууль тогтоомжийн дагуу төв, орон нутгийн төрийн захиргааны байгууллагад төлсөн улсын тэмдэгтийн болон бусад хураамж

Үзүүлэлт	Анхны нэгтгэлийн зөрүүнүүд, цэвэр мян.төг	Тохируулагдсан байдал		Тохируулгын дараах шийдэгдээгүй зөрүүнүүд, цэвэр мян.төг
		Засгийн газрын байгууллагууд мян.төг	Компаниуд мян.төг	
Зохих хууль тогтоомжийн дагуу төв, орон нутгийн төрийн захиргааны байгууллагад төлсөн улсын тэмдэгтийн болон бусад хураамж (313,445)	(313,445)	161,666	163,787	(2,120)

б. Зохих хууль тогтоомжийн дагуу төв, орон нутгийн төрийн захиргааны байгууллагад төлсөн үйлчилгээний хөлс

Үзүүлэлт	Анхны нэгтгэлийн зөрүүнүүд, цэвэр мян.төг	Тохируулагдсан байдал		Тохируулгын дараах шийдэгдээгүй зөрүүнүүд, цэвэр мян.төг
		Засгийн газрын байгууллагууд мян.төг	Компаниуд мян.төг	
Зохих хууль тогтоомжийн дагуу төв, орон нутгийн төрийн захиргааны байгууллагад төлсөн үйлчилгээний хөлс (562,175)	(562,175)	779,678	779,678	-

Хураамж, үйлчилгээний хөлс (төлбөр)-ийн анхны зөрүүнд хийгдсэн томоохон залруулгуудыг дурьдвал:

- “Айвенхоу майнз монголия инк” /Оюу толгой/ ХХК нь анхны тайландаа хураамж болон үйлчилгээний хөлсийг дутуу тусгасан нь нэгтгэлийн тайлангийн явцад компаниас ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээллээр нотлогдсон. Уг дүнг ГХЯ, СХЗГ, ХХҮГ, ГИХАЭГ, АМГ зэрэг байгууллагуудаас нэгтгэл тайлангийн явцад ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээлэлд үндэслэн залруулсан. Мөн компани нь анхны тайландаа лицензийн төлбөрийг хураамж, үйлчилгээний хөлс хэсэгт давхардуулж тусгасан тухайгаа албан бичгээр тайлбар ирүүлсэний үндсэн дээр компани талаас хасч, залруулсан.
- “Арева Монгол”, “АУМ”, “Сентерра гоулд” зэрэг компаниуд нь анх тайлагнасан дүнгээ дэлгэрэнгүй мэдээллээрээ буруу гэдгээ хүлээн зөвшөөрсөний дагуу хасч, залруулав.
- “Бороо гоулд” ХХК-иас төлсөн хураамж үйлчилгээний хөлсийг ЗГ тайлагнаагүй учраас 11,794 мянган төгрөгийн зөрүү үүссэн. Компаниас ирсэн эдгээр хураамж, үйлчилгээний хөлсний талаар дэлгэрэнгүй мэдээллээс харахад төрийн бус байгууллагад өгсөн хураамжийн хөлс болон нэг удаагийн төлөлтөөрөө материаллаг түвшингээс доогуур дүнтэй замын хураамж зэргийг хасч тохируулав.
- “Бүүргэнт”, “Гацуурт”, “Дацан трейд” зэрэг компаниуд нь Усны газарт төлсөн үйлчилгээний хөлсөө тайлагнасанаас зөрүү үүссэн ба Усны газраас хариу ирсэний дагуу ЗГ талд нэмж, тохируулав.
- “Болд төмөр ерөө гол” ХХК нь ХХҮГ, ГИХАЭА, Гадаад харилцааны яаманд төлсөн үйлчилгээний хөлс болох 82,803 мянган төгрөгийг оруулж тайлагнаснаас анхны зөрүү үүссэн ба тус газруудаас тодруулга ирсэний дагуу ЗГ талд залруулсан.
- “Бүүргэнт” ХХК нь СХЗҮ төвд сорьц хийлгэсэн үйлчилгээний хөлс болох 1,482 мянган төгрөгийг тайлагнаснаас анхны зөрүү үүссэн ба тус газарт албан тоот хүргүүлж хариу ирсэний дагуу ЗГ талд нэмж, залруулсан.
- “Гоби коул энд энержи” ХХК нь төрийн бус байгууллагад төлсөн үйлчилгээний хөлсөө оруулж тайлагнасан болох нь дэлгэрэнгүй мэдээллээр тогтоогдсоны дагуу компани талаас 2,542 мянган төгрөгийг хасч тохируулсан. Үлдсэн зөрүү болох 155 мянган төгрөгийг тодруулахаар ХХҮГ-т хандсаны дагуу хариу ирж, зөрүү шийдвэрлэгдэв.
- “Петро чайна дачин тамсаг” ХХК нь анхны тайландаа төлсөн хураамжийн дүнг тайлагнасан ба дэлгэрэнгүй мэдээллээр төлсөн дүнгээ нотлоогүй учраас хасч залруулсан.
- “Чинхуа МАК нарийн сухайт” ХХК анхны тайланд тусгагдсан дүнг ХХҮГ, МХЕГ, ГИХАЭГ, АТГ зэрэг байгууллагуудаас ирүүлсэн дэлгэрэнгүй мэдээлэлд үндэслэн залруулсан.

с. Гаалийн үйлчилгээний хураамж

Үзүүлэлт	Анхны нэгтгэлийн зөрүүнүүд, цэвэр мян.төг	Тохируулагдсан байдал		Тохируулгын дараах шийдэгдээгүй зөрүүнүүд, цэвэр мян.төг
		Засгийн газрын байгууллагууд мян.төг	Компаниуд мян.төг	
Гаалийн үйлчилгээний хураамж	1,281,913	10,303,301	10,303,301	-

Гаалийн үйлчилгээний хураамжийн анхны зөрүүнд хийгдсэн томоохон залруулгуудыг дурьдвал:

- Компаниуд ихэвчилэн гаалийн үйлчилгээний хураамжийг гаалийн албан татварт оруулан тайлагнасан.
- “Адуунчулуун” ХХК-ниас ирсэн дэлгэрэнгүй мэдээллийн дагуу компани талд 63 мянган төгрөгийг нэмж, тохируулсан.
- “Алтайн хүдэр” ХХК-ийн гаалийн үйлчилгээний хураамжийг Гаалийн ерөнхий газраас ирүүлсэн мэдээлэлд үндэслэж компани талд 860 мянган төгрөгийг нэмж, тохируулсан.

- “Саусгоби сэндс” ХХК-нь 2009 оны тайланд гаалийн үйлчилгээний хураамжийг дутуу тусгаснаас үүдэн 2,362,723 мянган төгрөгийн зөрүү үүссэн байна. Тус зөрүүг ГЕГазраас тодруулахад компанийн 2009 онд гаалийн бүрдүүлэлтийн хураамжид төлөгдсөн хураамжийн жагсаалтыг Өмнөговь аймгийн Гашуун сухайт, Шивээ хүрэнгийн боомтоос ирүүлсэн тул компани талд 2,561,996 мянган төгрөгийг нэмж, залруулсан.

4. Төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашиг

Анхлан ирүүлсэн маягтууд дахь төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашиг хэсгийн зөрүүнүүд болон нэгтгэлийн үр дүнд засгийн газрын нэгж байгууллагууд, компаниудаас ирүүлсэн дүнд хийсэн залруулгуудыг дараахи байдлаар харуулав.

Үзүүлэлт	Анхны нэгтгэлийн зөрүүнүүд, цэвэр мян.төг	Тохируулагдсан байдал		Тохируулгын дараах шийдэгдээгүй зөрүүнүүд, цэвэр мян.төг
		Засгийн газрын байгууллагууд мян.төг	Компаниуд мян.төг	
4.1 Төрийн өмчийн ногдол ашиг	(95,105,381)	104,095,313	104,095,313	-
4.2 Орон нутгийн өмчийн ногдол ашиг	(76,364)	-	-	-
Нийт	(95,181,745)	104,095,313	104,095,313	-

а. Төрийн өмчийн ногдол ашиг

Үзүүлэлт	Анхны нэгтгэлийн зөрүүнүүд, цэвэр мян.төг	Тохируулагдсан байдал		Тохируулгын дараах шийдэгдээгүй зөрүүнүүд, цэвэр мян.төг
		Засгийн газрын байгууллагууд мян.төг	Компаниуд мян.төг	
Төрийн өмчийн ногдол ашиг	(95,105,381)	104,095,313	104,095,313	-

Төрийн өмчийн ногдол ашгийн анхны зөрүүнд хийгдсэн томоохон залруулгуудыг дурьдвал:

- “Эрдэнэт үйлдвэр” ХХК-иас хүлээн авсан төрийн өмчийн ногдол ашгийг УТЕГ-аас анхны тайланд тусгаагүй байна. Уг дүнг ЗГ-ын 2007 оны 80-р тогтоолын хавсралтад зааснаар ТӨХ аж ахуйн нэгж бүрийн нэрээр санаачлагын маяганд заасан үзүүлэлтийн дагуу УТЕГ-т гаргаж мэдээлэх чиг үүрэг тодорхойлогдсон хэдий ч уг дүнг УТЕГ-т мэдээлээгүйгээс зөрүү үүссэн байна. Нэгтгэл тайлангийн явцад СЯ-ны Төрийн сангийн газраас төрийн өмчийн ногдол ашгийн дүнг тодруулж залруулгыг хийсэн.

б. Орон нутгийн өмчийн ногдол ашиг

Үзүүлэлт	Анхны нэгтгэлийн зөрүүнүүд, цэвэр мян.төг	Тохируулагдсан байдал		Тохируулгын дараах шийдэгдээгүй зөрүүнүүд, цэвэр мян.төг
		Засгийн газрын байгууллагууд мян.төг	Компаниуд мян.төг	
Орон нутгийн өмчийн ногдол ашиг	(76,364)	-	-	-

- “Шижир алт” ХХК нь анхны тайланд хувь нийлүүлсэн компанидаа олгосон ногдол ашгийг тусгасан учраас хасч, залруулсан.

5. Төрийн байгууллагад төлсөн бусад төлбөрүүд

Анхлан ирүүлсэн маягтууд дахь төрийн байгууллагад төлсөн бусад төлбөрүүд хэсгийн зөрүүнүүд болон нэгтгэлийн үр дүнд засгийн газрын нэгж байгууллагууд, компаниудаас ирүүлсэн дүнд хийсэн залруулгуудыг дараахи байдлаар харуулав. Үүнд:

